

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-23
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	24-120
1. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	27-48
2. Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	49-50
3. “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	50-56
4. Нийтийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	56-80
5. Монголбанкны бүтцийн талаарх Монголбанкны мэдээлэл сонсох	80-88
6. “Монголбанкны бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	88-94
7. Эдийн засагт тулгамдаж буй асуудлууд болон холбогдох байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээлэл сонсох	94-101
8. “Монголбанкны бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн санал хураалт	101-102
9. Нийтийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн санал хураалт	102-105
10. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	105-112
11. Хадгаламжийн даатгалын корпорацийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаар мэдээлэл сонсох	112-120

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
07 дугаар сарын 07-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Д.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан;
Тасалсан: Э.Батшугар, О.Цогтгэрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан үг хэлж, хэлэлцэх асуудлын 1 дүгээрт байгаа Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн үг хэлэв.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	2
Татгалзсан:	15
Бүгд:	17

11.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлж, хэлэлцэх асуудлын 9 дүгээрт байгаа Хадгаламжийн даатгалын корпорацын өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаар Монголбанкны мэдээлэл сонсох асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	11
Бүгд:	17

35.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Нэг.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга

Г.Эрхэмбаяр, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Нямсүрэн, Эрчим хүчний сайдын зөвлөх Б.Нямаа, Д.Лхамсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, М.Энхцэцэг, П.Сайнзориг, Б.Жаргалан, Х.Ганхуяг, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 3.1.35-д нэмэлтээр оруулж буй дараах заалтаас “сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс бусад” гэснийг хасах буюу дараах байдлаар өөрчлөн найруулах:

“3.1.35.”Эрчим хүчний төсөл” гэж нэрлэгдсэн сүлжээнд холбогдон ажиллах эрчим хүчний эх үүсвэрийн зураг төсөл боловсруулах, эрчим хүчний барилга байгууламж барих, ашиглах, өмчлөх, шилжүүлэх, эрчим хүч үйлдвэрлэх цогц үйл ажиллагаа бүхий төслийг” гэж өөрчлөх найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Цэнгүүн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг уг хуулийн төсөл дээр ажлын хэсэг байгуулж, ажиллах шаардлагатай тул хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Р.Сэддорж: Горимын санал дэмжигдээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан дээрх зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 6.20 дахь хэсгийн “холбогдох түншлэлд” гэсний дараа “Өрийн удирдлагын тухай хуулийн 34.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Бадамсүрэн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 6.3 дахь хэсгийн “эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” гэснийг “Эрчим хүчний зохицуулах хороо” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 18
Бүгд: 18
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг “Засгийн газрын шийдвэрийн дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран эрчим хүчний төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг тухай бүр байгуулна.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.1.35 дахь заалтын “өмчлөх” гэсний дараа “төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлсэн тохиолдолд” гэж нэмэх бөгөөд төслийн 3.1.36 дахь заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 13
Бүгд: 18
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах:

“6.3.эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

6.4.Энэ хуулийн 6.3-т заасан ажлын хэсэг 9-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

6.4.1.гишүүдийн 3-ыг нь эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон байх;

6.4.2.гишүүдийн 2-ыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон байх;

6.4.3.гишүүдийн 2-ыг нь эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон байх;

6.4.4.гишүүдийн 2-ыг нь тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн холбоод төрийн бус байгууллагын төлөөлөл байх;

6.11.Сонгон шалгаруулалтын баримт бичигт эрчим хүчний төслийн онцлогтой уялдуулан доор дурдсан нөхцөлийг харгалзан үзнэ.

- 6.11.1.эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх үнэ;
- 6.11.2.эрчим хүчний төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэх тохиолдолд төрд шилжүүлэх нөхцөл хугацаа;
- 6.11.3.Төслийн хугацаанд нийлүүлэх эрчим хүчний хэмжээ;
- 6.11.4.төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийн хэмжээ;
- 6.11.5.санхүүжилтийн зардал;
- 6.11.6.туслан гүйцэтгэгчийн чадавх болон туршлагын шаардлага;
- 6.11.7.төслийн эрсдэл, хариуцлага хүлээх чадамж, баталгаа;
- 6.11.8.төслийн үйл ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл;

6.12.эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах урилгад дараах мэдээллийг тусгана.

6.12.1.төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр төсөл хэрэгжүүлэх тохиолдолд түншлэлийн төрөл;

6.12.2.санхүүжилтийн эх үүсвэрийн тодорхой хэсгийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлэх эсэх;

6.12.3.сонгон шалгаруулалт зохион байгуулах хэл;

6.12.4.дэнчингийн хэмжээ;

6.12.5.энэ хуулийн 6.11-д заасан нөхцөл;

6.12.6.гүйцэтгэлийн баталгааны хэмжээ;

6.12.7.сонгон шалгаруулалтын үе шат;

6.12.8.эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх дээд үнэ” гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дугаар заалтын 6.18 дахь заалтын “сонгон шалгаруулахдаа” гэсний дараа “төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу” гэж санал нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Р.Сэддорж нар үг хэлэв.

Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 12
Бүгд: 18
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 15.4.1 дэх хэсгийн “менежментийн үйлчилгээ, санхүүжүүлэх болон зураг төсөл, төсөв боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх” гэсэн заалтыг хэвээр үлдээж, Төслийн 15.4, 15.4.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 12
Бүгд: 18
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.1.14, 10.1.15 дахь заалт:

10.1.14.Түншлэлийн төсөлд төсвөөс санхүүжүүлэх санхүүжилт хийх тохиолдолд хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусгуулах санал хүргүүлэх.

10.1.15 дах хэсгийг бүхэлд нь хасах” гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 14
Бүгд: 18
22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 39.1 дэх хэсгийн “зөвшөөрөлд үндэслэн” гэсний дараа “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг “төрийн захиргааны төв” гэсний дараа “байгууллага, хуульд заасан тохиолдолд түншлэлийн гэрээ байгуулсан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7

Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “мөн хэсгийн “гаргаж” гэсний өмнө “, хуульд заасан тохиолдолд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан Төслийн “**2 дугаар зүйл**.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хувийн хэвшлийн” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “гэрээний талууд нь” гэсний дараа, мөн зүйлийн 33.3 дахь хэсгийн “түншлэгч талыг төлөөлж” гэсний дараа, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “түншлэлийн асуудал эрхэлсэн” гэсний өмнө 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “зөвшөөрөлд үндэслэн” гэсний дараа гэж, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “21.7” гэсний дараа “21.11” гэж, мөн хэсгийн “гаргаж” гэсний өмнө гэж тус тус нэмснийг хасах” гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 12
Бүгд: 18
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 34.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.5.Төр,хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15.4-д заасан эрчим хүчний төсөлд санхүүгийн үр ашигтай байх, мөн төслийн ирээдүйн мөнгөн урсгалаар баталгаа гаргуулж байгаа зээл үнэт цаасыг эргэн төлөх чадвартай тохиолдолд энэ хуулийн 34.2.1-д заасан шаардлага хамаарахгүй бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх болон Засгийн газрын өрийн баталгаа гаргах цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн чадлыг дотоодын нийт хэрэглээний 40 хувиас илүүгүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Амармөрөн, Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Хот байгуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

Р.Сэддорж: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	5
Бүгд:	18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нийтийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Д.Цолмон, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, мөн газрын референт Б.Төрбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга О.Оюунзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Батбаатар, мөн Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Амармөрөн, П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, хуулийн төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлтийг

Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар танилцуулав.

Илтгэл болон хууль зүйн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, А.Ундраа, О.Номинчимэг, М.Мандхай, Ш.Бямбасүрэн, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Р.Сэддорж нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./18:00/

Тав.Монголбанкны бүтцийн талаарх Монголбанкны мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Тамгын газрын захирал Г.Пүрэвсүрэн, Хяналтын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Монголбанкны бүтцийн талаарх мэдээллийг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Найдалаа, Л.Соронзонболд, М.Мандхай, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Хяналтын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монголбанкны бүтцийн талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.“Монголбанкны бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Тамгын газрын захирал Г.Пүрэвсүрэн, Хяналтын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, Л.Соронзонболд, Ө.Шижир, Б.Жаргалан нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./19:08/

Долоо.Эдийн засагт тулгамдаж буй асуудлууд болон холбогдох байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, мөн газрын Макро зохистой бодлогын хэлтсийн дарга Н.Батболд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Хадгаламжийн даатгалын корпорацын Гүйцэтгэх захирал С.Баатарсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээллийг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Лувсанжамц, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Хадгаламжийн даатгалын корпорацын Гүйцэтгэх захирал С.Баатарсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 19 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан “Монголбанкны бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн санал хураалтаар үргэлжлэв.

Р.Сэддорж: “Монголбанкны бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 19 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Нийтийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн санал хураалтаар үргэлжлэв.

Р.Сэддорж: 1.Нийтийн өмчийн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

42.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

43.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Найм.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, М.Бадамсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл үг хэлэв.

Р.Сэддорж: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг санал хураалтад оролцож амжаагүй тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл тогтоолын төслийг дахин найруулах шаардлагатай тул хойшлуулах тухай үг хэлэв.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн батлах санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 20 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Хадгаламжийн даатгалын корпорацийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал С.Баатарсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн байлцав.

Хадгаламжийн даатгалын корпорацийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаар мэдээллийг Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал С.Баатарсүрэн танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Л.Соронзонболд, О.Батнайрамдал нарын тавьсан асуултад Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал С.Баатарсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хадгаламжийн даатгалын корпорацийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаар мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 20 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 6 цаг 40 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 20 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 12 минут.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батболд, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Улсын Их Хурлын гишүүн Батчимэг, Бямбасүрэн, Ганхуяг, Жаргалан, Лувсанжамц, Мандхай, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Найдалаа, Цэнгүүн, Энхцэцэг, Сэддорж нарын Улсын Их Хурлын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Гишүүд хуралдааны танхимд орж ирье. Ирцэд орсон гишүүд.

Хэлэлцэх асуудал

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газраас 2025 оны 06 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

2.Хот байгуулалтын тухай хууль хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан 2025 оны 05 сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

3.Нийтийн өмчийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

4.“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

5.Монгол банкны бүтцийн талаар Монголбанкны мэдээллийг сонсох

6.“Монголбанкны бүтцийн өөрчлөлтийн талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

7.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

8.Эдийн засагт тулгамдаж буй асуудлууд болон холбогдох байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээлэл сонсох

9.Хадгаламжийн даатгалын корпорацын өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаар Монголбанкны мэдээлэл сонсох

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу. Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Б.Жаргалан: Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны 1 дүгээр асуудал буюу Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анх Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 26-нд хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай тов хүсэж, процесс эхэлсэн байгаа. Тэгээд 7 дугаар сарын 2-ны Эдийн засгийн байнгын хорооны хурлаар Ардчилсан намын бүлгээс бас завсарлага авсан. Тэгээд улмаар 7 дугаар сарын 3-ны Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэх эсэх асуудлыг бол дэмжсэн. Энэ дээр ямар ойлголцлоор дэмжсэн бэ гэхээр хууль санаачлагчаас хуулийн төсөлтэй холбогдуулан дагалдаж гарах Улсын Их Хурлын тогтоол, мөн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулах, нэр бүхий төслүүдийг заах гэх мэтчилэн нөгөө хуулийн биелэлттэй холбоотой асуудлуудыг нарийвчилж, гишүүдэд мэдээлэл өгнө гэсэн байдлаар бол пүрэв гаргийн буюу 7 дугаар сарын 3-ны Улсын Их Хурлын хаврын чуулганаар бол ердийн горимоор хэлэлцэх эсэх асуудлыг бол дэмжсэн байгаа.

Харамсалтай нь бол хууль санаачлагчаас бол саяын хэлсэн амлалтууддаа хүрээгүй. Дагалдаж гарах тогтоолууд энэ тэр бол байхгүй байгаад байгаа. Ажлын хэсэг бол байгуулагдаагүй хэлэлцэх эсэх асуудал дэмжигдсэнтэй холбоотойгоор. Тэгэхээр би бол энэ хэлэлцэх эсэх асуудлаас өнөөдрийн хуралдаанаас Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг бол хасах саналтай байгаад байгаа. Яагаад вэ гэхээр энэ дээр бол ерөөсөө зөвшилцөл байхгүй байгаа гэж ойлгож байгаа.

2 дугаарт үүнтэй холбоотойгоор би Улсын Их Хурлын даргын захирамжаар Эрчим хүчний тухай хуулийн ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийг бол Эдийн засгийн байнгын хорооны нэр бүхий гишүүд тус ажлын хэсэгт орсон байж байгаа. Энхцэцэг гишүүн энэ ажлын хэсгийг бас ахалж байгаа. Бүтэн бараг жил гаруй ажилласан ажлын хэсгийн дүгнэлт шаардлагатай гэж би бол хувьдаа үзэж байгаа. Энэ Байнгын хороонд байгаа Цэнгүүн гишүүн, Энхцэцэг гишүүн тэргүүтэй нэр бүхий гишүүд энэ Эрчим хүчний хуулийн ажлын хэсэгт бол ороод ажиллаад бас тодорхой үр дүн гараад явж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр Эрчим хүчний хуулийн ажлын хэсэг ажиллаад явж байхад энэ хуулийн төсөлтэй холбоотой ямар ямар үр дагаврууд гарах вэ энэ тэр гэдгийг бол ажлын хэсгийн ч гэсэндээ бас дүгнэлт гарах ёстой гэж үзээд байгаа юм.

Тэгэхээр Засгийн газраас өргөн мэдүүлсэн богино хугацаанд өргөн мэдүүлээд яаралтай горимоор хэлэлцэх эсэх нь бол 3-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар бол уначихсан байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг бол ингэж яаруу сандруу байдлаар наадмын өмнө бол хэлэлцэх нь бол буруу гэсэн байр суурьтай байна. Тэгэхээр энэ дээр хурал даргалагч хэлэлцэх асуудлаас Эрчим хүчний тухай хуулийн төслийг хасаж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Р.Сэддорж: Яамнаас бол хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний талаар тогтоолын төсөл бол ирүүлсэн байгаа. Хууль батлагдсаны дараа энэ тогтоол бол баталгаажна. Яригдана. Мөн маргааш Улсын Их Хурлаар бас Засгийн газраас бичиг ирсэн байна. Улсын Их Хурлын Тамгын газарт яаралтай горимоор дахин хэлэлцүүлж өгөөч гэсэн. Тийм учраас маргааш Улсын Их Хурлаар энэ асуудал авч хэлэлцэгдэх байх. Тэгээд одоо Их Хурлын гишүүний гаргасан горимын санал. Энэ жагсаалт нь ирчихсэн байна. Энэ бүх гишүүдэд тараагдсан байна. Ирчихсэн байна. Тэгээд өөр горимын саналтай гишүүд байна уу. Хэлэлцэх асуудал дээр. Эхлээд санал хураана.

Жаргалан гишүүний гаргасан горимын саналаар хэлэлцэх асуудлын 1-т байгаа Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байна. Ингээд гишүүд санал хураалтад бэлдье. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг дээр л тогтоол ярина. Тийм хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг дээр энэ тогтоолын тухай яригдана. Эцсийн хэлэлцүүлэг дээр. Энэ бол эхний хэлэлцүүлэг байгаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Жаргаланд энэ жагсаалт очсон уу. Жагсаалт өгье. Ажлын албанаас энэ жагсаалтуудыг яаралтай өгье. Санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдэж хуруугаа уншуулъя. Чойжилсүрэн сайд энэ талаараа тайлбарла даа. Сайдын микрофоныг.

Б.Чойжилсүрэн: Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амрыг эрье. Бид өнгөрсөн 7 хоногийн 5 дахь өдөр үдээс хойш Улсын Их Хурлын чуулган дээр хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн. Түүнээс хойш ажлын өдрүүд байгаагүй. Өнөөдөр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэр гараад, өнөөдөр Эдийн засгийн байнгын хороо хуралдахаар анхны боломж нь л энэ шүү дээ.

Тэгэхээр ажлын хэсэг байгуулах саналыг одоо Байнгын хороо дээр байгуулах байх. Урьдчилж байгуулах бололцоо байхгүй. Тэгэхээр гишүүд маань хэлэлцэх эсэхээ үлдээгээд, ажлын хэсгээ байгуулбал бид нар нээлттэй байна. Мэдээллээр хангая. 5 дахь өдрийн үдээс хойш 16 цагийн үед хэлэлцэх эсэх нь дэмжигдээд, өнөөдөр ажлын эхний өдөр.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн хуруугаа уншуулчих. Санал хураалт болох гэж байна. Ингээд хэлэлцэх асуудлын 1 дүгээрт байгаа Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн Жаргалан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хэлэлцэх эсэхийг хойшлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Ингээд хэлэлцэх асуудлыг баталъя. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна. Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Эдийн засгийн байнгын хорооны дарга болон гишүүдийн энэ өдрийн амрыг айлтгая. Энэ хэлэлцэх асуудлын 7-д нь байна уу, 8-д нь байна уу Хадгаламжийн даатгалын корпорацын асуудлыг Их Хурал дээр сонсоно гээд энэ хаанаас ямар явуулгаар наашаа орж ирснийг би бол мэдэхгүй байгаа. 6900 төрийн өмчит аж ахуйн нэгж байгаа. Тэгээд тэр төрийн өмчит аж ахуйн нэгж болгоны асуудлыг Их Хурлын чуулган эсвэл Байнгын хороо дээр ярина гэвэл энэ бүтэхгүй асуудал. 1 дүгээрт.

2 дугаарт Төв банкны тухай хууль буюу энэ Монголбанкны хууль дээр энэ асуудлыг нь хаана ярих вэ гэдгийг нь хүртэл биччихсэн байгаа. 19.2.Хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банк дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмыг хэрэгжилтэд нь хяналт тавина гэж Монголбанканд ийм үүрэг байгаа. Тэгээд Банк дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйл дээр корпорацийн удирдах дээд байгууллага нь Хадгаламжийн даатгалын үндэсний хороо байна. Тэгээд Үндэсний хороонд болохоор Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга байна. Тэгээд 23.3 дээр нь Үндэсний хорооны даргын эзгүйд түүний үүргийг Үндэсний хорооны даргын томилсон аль нэг гишүүн гүйцэтгэх бөгөөд Үндэсний хорооны даргын үүрэг гүйцэтгэж байгаа гишүүн Үндэсний хорооны даргаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ гээд ийм хуультай. Тэгээд бид нар энэ хуулийг нь хэрэгжүүлэхгүйгээр зүгээр асуудал болгоныг, байгууллага болгоныг ингэж Улсын Их Хурал дээр авчирч ярина гэх юм бол Улсын Их Хурал эсвэл энэ Эдийн засгийн байнгын хороо чинь бүр хэлэлцэх асуудал олдохгүй болчихоод хуульдаа ч байхгүй юмыг энд авчирч хэлэлцэх гээд байгаа юм шиг ийм асуудал руу ороод байгаа учраас энэ Хадгаламжийн даатгалын корпораттай холбоотой асуудлыг хэлэлцэх эсэх асуудлаас хасаж өгнө үү гэдэг хуулийг хэрэгжүүлэх ийм зарчмын санал гаргаж байгаа юм.

Р.Сэддорж: Энэ чинь Их хурлын гишүүдээс гарсан санал байгаа юм. Их Хурлын гишүүнээс гаргаад, би Их Хурлын гишүүд энэ мэдээллийг сонсъё гэхээр сонсох шаардлагатай байгаа. Тэгвэл Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналаар хэлэлцэх асуудлаас Хадгаламжийн даатгалын корпорацийн яг захирал нь бол ирээгүй байгаа юм байна. Ингээд Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналаар хэлэлцэх асуудлаас хасах санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэе. Бадамсүрэн гишүүн санал хураалтад бэлдье. Одоо санал хураалт болох гэж байна. Бадамсүрэн гишүүн үгүй ээ энд нөгөө хуруугаа уншуулахгүй бол болохгүй байна. Ингээд хэлэлцэх асуудлын 9 дээр байгаа Хадгаламжийн даатгалын корпорацийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаар Монголбанкны мэдээллийг сонсох асуудлыг хэлэлцэх асуудлаас хасахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд Лодойсамбуу гишүүн. Өөр саналтай гишүүд алга байна.

Хэлэлцэх асуудалд оръё.

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсгийг танилцуулъя. Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Эрхэмбаяр Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга, Нямсүрэн Эрчим хүчний яамны Гэрээ эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, Нямаа эрчим хүчний сайдын орон тооны зөвлөх Лхамжав Эрчим хүчний сайдын орон тооны бус зөвлөх.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төсөл тус бүрийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Мөн зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй

холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрээ өгье. Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Энэ асуудал маань бол хүч түрэн орж ирэхээс өөр аргагүй болоод л орж ирж байх шиг байна. Тэгээд ер нь Эрчим хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулга ч биш бүр зүгээр Эрчим хүчний тухай хуульдаа бид нар сэглэсэн байдлаар худалдан авах ажиллагаа дээр нь ингэж өөрчлөлт оруулж ирж байгаа маань бол буруу байгаад байгаа юм. Тэгээд уг нь бол 11 сард байгуулагдсан Эрчим хүчний тухай хуулиудын шинэчилсэн найруулгын ажлын хэсэг байж байгаа. Энхцэцэг гишүүн ахлаад ажиллаж байгаа юм. Гэтэл тэр ажлын хэсгийнхээ саналуудыг харахгүйгээр, тэр дээр ямар үзэл баримтлалтай явж байгааг нь бид бүхэнд танилцуулаагүй юм байж ийм зарчимгүй байдлаар ингэж хуульдаа гар хүрч байгаа нь бол үнэхээр харамсалтай санагдаж байна.

Тэгээд яалт ч үгүй бусад чуулган дээр ч тэр, Эдийн засгийн байнгын хороо дээр ч тэр гишүүд дэмжээд яваад байгаа юман дээр бол хүчин мөхөстөж байна. Тэгээд зарчмын зөрүүтэй саналтай байгаа гишүүдээ бас ингээд бөөрөлхдөг баймааргүй байна гэж бас хэлмээр байгаа юм. Жишээ нь Монголын эдийн засгийн форум дээр бол үг хэлэх байсан чинь энэ асуудал дээр эсрэг байр суурьтай байснаас болоод миний нэрийг хасуулсан байна лээ Чойжилсүрэн сайд аа. Одоо мэдэхгүй, ямар байдлаар хасуулсан байгаа юм. Тэгэхээр ингээд иймэрхүү байдлуудаар бол дарамтууд ороод ирж байна. Тэгээд бас энийг ч гэсэн олон нийт, гишүүд бас мэддэг байгаасай гэж хүсэж байгаа болохоор өнөөдөр Байнгын хороо дээр бас хэлье гэж бодлоо.

Тэгээд энэ Эрчим хүчний тухай хууль ингээд энүүгээрээ явах юм бол өнөөдөр миний гарт байгаа 30-аад хуулийн төсөл явж төслүүд бол явагдаж байгаа юм шиг байна. Энэ дундаас бол дамжуулах төслүүд бол зайлшгүй хийгдэх шаардлагатай. Дамжуулах дээр бол ямар нэгэн санал байхгүйгээр дамжуулахын агаарын шугамуудаа бол хийгээд яваасай гэж хүсэж байгаа юм.

Харин энэ шинэ эх үүсвэрүүдтэй холбоотой асуудал дээр бол бид нар хувийн хөрөнгө оруулагч нарыг уг нь оруулж ирэх шаардлагатай байгаа юм. Тэгээд энэ дээр бас Чойжилсүрэн сайд бусад гишүүдийн асуултад хариулахдаа ч гэсэн тэгэх боломжгүйгээр ер нь төр л авна. Төрд авах эрхтэй гэдэг байр суурь баримталж байгаа юм байна лээ. Тэгэхээр бас энийг Ерөнхий сайдаас илүү асуух шаардлагатай гэж харж байна л даа. Занданшатар Ерөнхий сайд өөрөө энэ эрчим хүчний либералчлал гэдэг үгийг хэлээд байгаа. Гэхдээ либералчлал гэдэг үгийг ингэж хамаа намаагүй ашиглаад байж болохгүй. Төрд бид нар хэрвээ шинэ станцууд нэмж барьж л байгаа бол тэнд бол ямар ч либералчлал хийгдээгүй. Төрийн өмчийг бид нар нэмж л байгаа бол тэнд ямар ч либералчлал хийгдэхгүй ийм асуудал үүсэж байгаа юм. Тэгэхээр яг үнэндээ бол бид нар энийг яг одоо ингэж баталж явахын эсрэг байр суурьтай байгаа гэдгээ бас энэ ташрамд бас хэлье л гэж бодож байна.

Р.Сэддорж: 3 номер.

Б.Чойжилсүрэн: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Цэнгүүн гишүүн бүрэн ойлгосон юм шиг байна. Тэр эдийн засгийн формыг зохион байгуулж байгаа улсуудтай би ямар ч холбоогүй байгаа гэдгээ 1 дүгээрт хэлье.

2 дугаарт би жишээлбэл Улаанбаатар хотын дулаан хангамжийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийнхэнд хариуцуулахаас үнэндээ болгоомжилж байгаа юм. Манай улсад жишээ байна. Зарим аймгийн төвүүд дээр хувийн хэвшлийнхэн явж байгаад яг хүйтний оргил, өвлийн оргил ачаалал болоод ирэхээр үнээ 40, 50 хувь нэмээд, ийм үнээр нийлүүлбэл нийлүүлнэ, нийлүүлэхгүй бол зогсоно гэдэг ийм төвөгтэй байдал байгаа учраас нэлээн тийм сэлгэн залгаж, орлуулж болох ийм юмыг хувийн салбарынханд хариуцна гэхээс биш яг Улаанбаатар хотын дулаан хангамжтай холбоотой хэсгийг бол дийлэнх хэсгийг нь сэлгэн холбох бололцоотой газруудад хувийн салбар орж болох, сэлгэн холбож болохгүй газарт бол төрд байгаасай гэсэн ийм байр суурьтай байгаа. Манай нийгэм 35 жил хөгжиж байна, урагшаа ахиж байна, чамлахааргүй явж байна. Гэхдээ хувийн салбарынхан бас тодорхой хэмжээний тийм эрсдэл үүрэх дархлаа үүсээгүй учраас ийм байр сууриа илэрхийлсэн. Уучлаарай. Энэ миний хувийн байр суурь.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Ганхуяг гишүүдийг нэмье. Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг асуулт асууж, үг хэлнэ. Жаргалан гишүүнийг нэмье.

М.Энхцэцэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд эрчим хүчний төслүүдийг яаралтай явуулахын тулд эрчим хүчний хууль дээр Улсын Их Хурал дээр байгуулагдсан Улсын Их Хурлын Эрчим хүчний хуулиудыг шинэчлэх ажлын хэсгээр боловсруулж байгаа тэр бол нэлээн том өөрчлөлт орж ирэх ийм дулаан, цахилгаан хангамжийн бие даасан хууль болж орж ирэх ийм хуулиуд байгаа. Энэ маань намар өргөн баригдана. Тэгэхээр энэ хуулиудыг хүлээхгүйгээр төслөө яаралтай явуулах шаардлагатай байгаа учраас ийм өөрчлөлт оруулж ирье гээд орж ирсэн. Тэгээд энийг бол 1 дүгээрт зарчмын хувьд дэмжиж байгаа.

2 дугаарт болохоор энэ өөрчлөлттэй холбоотой нэлээн сөрөг үр дагаврууд гарах шаардлагатай харагдаад байгаа учраас энийг хаах хаалтуудыг, заалтуудыг хууль дээр оруулж өгөх шаардлагатай байна. Тухайлбал тэр 1 дүгээрт нь эрчим хүчний төслүүд гэдэг энэ тодорхойлолтыг харахаар ер нь бараг эрчим хүчний бүх төслүүд энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр явагдчихаар юм шиг харагдаад байгаа. Тэгэхээр энэ тодорхойлолтыг бас өөрчлөх шаардлагатай байгаа.

2 дугаарт нь болохоор эх үүсвэрүүдийг бол төрд шилжүүлэх шаардлагагүй. Харин цахилгаан дамжуулах шугамуудыг бол бариад төрд шилжүүлэх боломжтой байдлаар өөрчлөх нь зүйтэй байх гэж бодож байгаа. Дээрээс нь би бас хэлсэн. Тэр эх үүсвэрийн хувьд дээд үнэ гэдгийг тендер зарлаж байгаа хүмүүс бас тавьж өгөх нь зүйтэй. Энэ хүнээс доошоо өрсөлдөх ёстой гэдгээр оруулбал зүйтэй гэсэн саналтай байгаа.

Мөн нөгөө тендер шалгаруулах хүмүүсийн доод тоо нь 5 гэсэн байсан. Тэгээд тэрийг бол доод тал нь 9 гэж зааж өгөх нь зүйтэй. Тэгээд Эдийн засгийн яам, Сангийн яам, бусад яамнуудаас хүн оруулах байдлаар тэр 5 хүний эрсдэлийг бууруулах нь зүйтэй гэсэн ийм нэлээн олон саналууд байгаа. Ерөнхийдөө энэ хуулийн төслийг сая амралтын өдрүүдэд манай хуульчид бас нэлээн сайн судалсан. Тэгэхээр жишээ нь, концессынхоо хуультай, тендерийнхээ хуультай нэлээн зөрчилдсөн заалтууд маш их байна лээ. Тэгэхээр энийг бол ажлын хэсэг

дээр ялангуяа хууль боловсруулсан 5 хүнтэй, Улсын Их Хурлын гишүүд болон Улсын Их Хурлын гишүүдийн хуулийн зөвлөхүүд бол нэлээн хамт сууж сайжруулах шаардлагатай юм байна гэсэн юм харагдсан. Яагаад гэхээр концессын хууль дээр бариад шууд төрд шилжүүлэх гэдгийг хориглосон байдаг. Яагаад гэвэл энэ нь тендерийн хуулиараа явах ёстой. Тендерийн шинж чанартай болчхож байгаа гэж хориглосон байдаг. Тэгэхээр энэ дээр энэ хуулиар энэ өөрчлөлтөөр энэ маань ингээд боломжтой болоод орж ирэх гээд байгаа учраас энэ бүгдийг бол засаж залруулах нь ажлынхаа хэсэг дээр хийх нь зүйтэй байх гэсэн ийм саналтай байна.

Р.Сэддорж: Санал юм уу. Хэн хариулах вэ. 3 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүн голдуу санал хэлчихлээ дээ. Ингээд анхны хэлэлцүүлгүүд явах учраас тухайн хөндөгдөх зүйлүүд дээр нь саналаа гаргаад явах юм байна гэж ойлголоо. Дэмжиж байгаад талархаж байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Бид хэд ч яах вэ ер нь зүгээр бодит үнэтэйгээ л тулж байгаа л даа. Тэгээд энийг шийдье гэдэг асуудал улс төрийн хувьд бас зориг гардаггүй. Өнөөдрийн энэ тендер худалдан авалтын хуулийг үнэхээр болохгүй байгаа аж ахуйн том төслүүдийг явуулахад зориулагдаж концепц үзэл баримтлалын хувьд боловсруулагдаагүй хууль байхгүй юу. Тэгээд энэ агуулгаар нь зүтгүүлэх юм бол бид нарын бүх худалдан авалт, хөрөнгө оруулалтын асуудлууд угаасаа гацах нь ойлгомжтой байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр сүүлдээ шүүхийн оролцоо орж ирээд би зүгээр Тавантолгойн төслийн тендер худалдан авалтыг л хэлье л дээ.

2 компани хоорондоо энэ худалдан авалтаас хойш маргаан үүсгэж явангуут чинь гуравдагч этгээдээр орж ирсэн этгээдийн эрх ашиг үйлчлээд, тэр нь бас гаднын компани. Ингээд л энэ Тавантолгой бүр эхнээс нь эхлүүлье гээд л явчхаж байгаа байхгүй юу. Юу хэлээд байна гэдэг бол энэ өөрөө эргээд зарим улс орнуудын эрх ашиг, тэндэх зах зээлийг хамгаалж өгөөд байгаа юм. Тэгээд энэ тендер худалдан авалтын хуулийг өөрчилье, энэ томоохон мега төслүүдийг явуулах болон бусад тэр асуудлуудаа маш зүйтэй зохицуулдаг болъё гэж байгаа юм. Дээрээс нь энэ ерөнхийдөө энэ төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхөөсөө эхлээд төлөвлөөд, энийг нь төр, хувийн хэвшил, энийг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэдэг асуудлыг заагладаг бас нэг төлөвлөлтийн хууль зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Энэ яах вэ Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын хуулиар явж байгаа. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиар явж байгаа боловч энэ нь өөрөө эргээд ямар ч баримжаагүй баахан хүслийн жагсаалт. Энэ дундаас олж эрэмбэлж, энийгээ шийднэ гэдэг бол бараг үндсэндээ бид хэд бие биеийгээ хуурч жүжиглэж тоглож байгаа юм. Баахан бичиг баримт боловсруулдаг. Хэнд ч хэрэгтэй, хэрэггүй нь мэдэгдэхгүй. Тэгээд энийгээ бид хэд шийдэхгүй л бол энэ улс эх орны асуудал чинь ерөөсөө шийдэгдэхгүй. Тэгээд энэ зургаараа харж байхад өнөөдөр 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр бид нар чинь 11 сая 629 сая киловатт/цаг эрчим хүч хэрэглэсэн байна. Энэ өмнөх оноос 6 хувиар өсөж байна. Яг эдийн засгийн энэ өсөлт тэлэлтийг дагаад, жилд эрчим хүчний хэрэглээ 8 хувьд хүрч байна. Энийгээ хангаж чадахгүй байна. Орон сууцад холбогдох гэхээр болохгүй байна. Энэ эрчим хүчний эх үүсвэрийн дутагдал, дамжуулах сүлжээний хомсдолоосоо болоод эндэх эрх ашиг авлигын юм чинь энэ орон сууц, үйлчилгээ, энэ нийтэд зориулж гаргаж байгаа үйлчилгээнүүдэд бараа бүтээгдэхүүний үнэ дээр шингэж орж ирээд байна.

Өнөөдөр Монгол улс ерөнхийдөө энэ дэд бүтцийн салбарыг дагасан авлигыг байхгүй болгоё гэвэл энэ дээр эрчим хүчний реформ хийж явах ёстой юм. Тэгээд энэ асуудлыг зориглоод нэг шийдэхээс өөр гарц байхгүй гэдэг зүйлийг би хэлмээр байна. Ажлын хэсэг ажиллаж байгаа гэж байгаа боловч бас яг бодлогын тодорхой юмнууд нь бас цаг хугацаа орох юм шиг байна. Тэгэхээр энэ асуудлуудаа бас Энхцэцэг гишүүн болон мэргэжлийн хүмүүс санал гаргах юм байна. Хэдүүлээ хэлэлцээд яваад, яг тодорхой төслүүдийг бол хэрэгжүүлбэ. Чойжоо дарга ч гэсэн тэгээд л хар толгойгоороо хариуцах юм байлгүй дээ. Ер нь энэ дээр бие биеэсээ айж эсвэл нэг айдсаар юмнуудыг хүлж байлгана гэдэг бол энэ улс эх орныг л..../минут дуусав/

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн 1 минут.

П.Сайнзориг: Тэгэхээр би зүгээр бас хэлж байгаа. Энхцэцэг гишүүн яг эрчим хүчний салбарын хэд хэдэн хуулийг боловсруулж байгаа. Би бас энэ тендер худалдан авалтын хуулийн шинэчилсэн найруулгыг гаргая гэж бодож байна. Ингэж байж энэ том төслүүд явдаг байхгүй бол өнөөдрийн ширээ сандал, бичгийн цаас авдаг хуулиар ийм орны эдийн засгийн тусгаар тогтнол болсон эрчим хүчний төслүүдийг шалгаруулна гэж байхгүй. Энэ тоглолтод бид хэд ерөөсөө энэ хуулиа сайжруулж чадахгүй явсаар энэ тоглолтыг дандаа ашигладаг. Сүүлдээ ингээд эдийн засгийн тусгаар тогтнол, эрчим хүчний тусгаар тогтнолыг саатуулж байгаа нь шүүх эрх мэдэл болчихоод байгаа байхгүй юу. Шүүхэд тэр барьж хэрэглэх шийдвэр гаргах хууль нь угаасаа болохгүй байна шүү дээ. Тэгэхээр би бас шүүхийг буруутгамааргүй байна. Энэ бас төр засаг бид нарын хийх ёстой ажлууд ерөөсөө хийгдэхгүй байна л гэсэн үг. Тэгээд өнөөдрийн асуудлыг хэдүүлээ бага улс төржөөд, гаргаж байгаа зарчмын зөрүүтэй саналуудаа маш үндэслэлтэй гаргаад, тэр гаргаж байгаа мэргэжлийн саналуудыг нь ингээд дэмжээд явъя л гэсэн ийм байр суурьтай байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын 1 номерт баримтлах зарчим бол хууль дээдлэх зарчим байгаа. Тэгэхээр одоо энэ тендерийн тухай хууль ерөөсөө болохгүй байгаад байна. Тийм учраас бид тодорхой салбар, тодорхой төслүүдэд зориулаад энэ хуулийг яаралтай өөрчлөх нь чухал гэж ярьж байгаа чинь бол ерөөсөө энэ зарчимтай чинь нийцэхгүй байгаад байна. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хуралд энэ тендерийн болохгүй байгаад байгаа хуулиа өөрчлөх боломж, бололцоо байсан. Гэтэл зөвхөн нэг салбар, тэр дундаа тодорхой тооны төслүүдэд зориулаад энэ чухал хуулийг 3, 4 хоногт өөрчлөх ийм төсөл оруулж ирээд, тэрийгээ бид нар ичих ч үгүй хэлэлцэх гээд сууж байна. Тэр хууль дээдлэх зарчим чинь хаана байгаа юм тэгвэл. Энхцэцэг гишүүн ч гэсэндээ битгий тийм гэнэн бай. Тэр ажлын хэсэг гаргаад, тэр хуулийн зөрчлүүдийг чинь яах цаг хугацаа наадуул чинь олгохгүй.

Өнөөдөр анхны хэлэлцүүлэг нь яваад, маргааш яаралтай энэ тэр гээд цохиод, наадмын өмнө энэ асуудлыг чинь шийдэх гээд байна. Тэгээд бид нар хардаа өнгөрсөн намар, сая хаврын чуулган эхлэхэд Улсын Их Хурал, Засгийн газрын нөгөө хуулийн тасаг болчихлоо гэж ярьж байсан бол энэ асуудлыг хэлэлцэж эхэлснээр Улсын Их Хурал ерөөсөө ийм тодорхой бизнесийн бүлэглэлүүдийн бизнесийн хэлэлцээрийг нь баталдаг ийм байгууллага болох гээд байна шүү та минь ээ.

Тэгээд тэрийгээ тэгээд илэн далангүй яахаараа ярьдаггүй юм. Яахаараа тэгээд чоно борооноор гэгчээр наадмын өмнө ийм заваарсан хуулийн төсөлд зүтгүүлж

байдаг юм. Тэгээд энэ жагсаалтаа хар л даа. Энэ жагсаалтыг чинь би анх удаа одоо л харж байна. Та тэр 4 дэх өдөр хуулиа хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дээр нэгдсэн чуулганаар хэлэлцсэний ар дээр 5 төсөл байгаа гэж байсан. Одоо тэгээд хэнтэйгээ юугаа тохирчхоод ийм 11 төсөл оруулж ирж байгаа юм. Орон нутгийн шинэ дулааны станц, дулааны станцын өргөтгөлийн төслүүд ийм олон тоон дээр тэгээд тэр бүх гэрээг байгуулах эрх нь Чойжилсүрэн гэдэг хүн дээр очих нь байна шүү дээ. Тэгээд хамгийн гол нь нөгөө нэг хууль руу бүх буруугаа чихээд байгаа юм. Тэгээд та бол 2022 оноос хойш Эрчим хүчний сайдаар ажиллаа шүү дээ. Тэрний өмнө 2016-2017 онд Сангийн сайдаар ажиллаж байсан. Тэр болохгүй байгаад байгаа Тендерийн хуулиа оруулж ирээд батлуулж байх нь яасан юм. Бүх л Засгийн газартаа сайдаар ажиллаж байна шүү дээ. Тэгээд одоо нэг мэдсэн чинь хууль нь болохоо байчихдаг. Тэгээд тэр болохоо байсан хуулийг нь ерөөсөө энэ мега төслүүдээ явуулахгүй бол болохгүй энэ тэр гээд л ямар нэгэн юмаар айлгаад л, гишүүдийг айдаст автуулаад, тэгээд нэг ийм ойлгомжгүй баахан жагсаалт оруулж ирээд өөр дээрээ эрх мэдэл овоолох гээд байгаа чинь зарчимгүй явдал мөн биз дээ. Тэгээд энэ мэтийн зүйл ярихаар ингээд ерөөсөө юм гацаалаа барилаа энэ тэр гэсэн юм ярих гээд байх юм. Хэдүүлээ хууль дээдлэх зарчмаа л барья л даа. Тэгээд 1 тийм зарчимдаа үнэнч байя л даа.

Эрчим хүчний салбар бол Монголын эдийн засгийн суурь салбар. Энэ дээр бид нар анхнаасаа ингээд баахан хувийн компаниудтай гэдэг юм уу, шинэ төслүүдтэй 8, 9 центээр үнэ тохироод яваад байж болохгүй гэдэг байр суурийг би аль намрын чуулганаас хойш л удаа дараалан тавьж байсан. Тэгээд та энэ бүтэн том салбарыг ингээд бүр самрах гээд байна шүү дээ. Тэгээд тэрийгээ 1 юу ч болоогүй юм шиг ингээд нэг юм гүлдийгээд, нэг ийм битүү хатуу байдлаар явуулах гээд байна гэдэг чинь бол .../минут дуусав/

Р.Сэддорж: Үг хэлсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг.

Х.Ганхуяг: Энэ парламент бол бид нар бас энэ тал талаас нь юмаа хардаг, зарим тохиолдолд Жаргалан гишүүнийг бухимдуулж байгаа юм шиг, бид нар бас зарим тохиолдолд бас хуулиуд нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагад үүсчхээд байгаа шалтгаанууд юу юм гэхээр бид нар анх удаагаа л 126-тай ийм парламент бий болсон байхгүй юу. Тийм учраас Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль эд нар тодорхой хэмжээний асуудлууд болохгүй бол бид нар засаад явах ёстой. Худалдан авах хууль бол манай эдийн засаг жижигхэн байсан. Тийм учраас ноднин жил Засаг бол худалдан авах хуулийг оруулж ирсэн. Гэхдээ тухайн үед Их Хурал ойлгоогүйгээс болоод дэмжээгүй, унагаасан. Төсвийн тогтвортой байдлын хууль, эсвэл Төсвийн хууль ч байдаг юм уу анх удаагаа бид нар Ерөнхийлөгч бүрэн хориг тавьж, бид нар бас төсвийг 2, 3 удаа хэлэлцээд явсан тохиолдол бий.

Төсвийн тогтвортой байдлын хууль гэх юм бол болж байгаа процесс яг анхны удаа л болж байгаа. Энэ 2025 оны 01 сарын 01-ээс хэрэгжиж байгаа зүйл заалтуудаас болоод бид нар нөгөө төсвийн хүрээний мэдэгдлийг нь буцаагаад, тодотголоо батлаад, одоо ингээд дахиад Төсвийн тогтвортой байдлын хуульд бас нэмэлт, өөрчлөлт хийх асуудал яригдаад явж байгаа. Би энэ бүхнийг яагаад ярина гэхээр Их Хурал гэдэг маань өөрөө байнгын ажиллагаатай болохоор бид нар зарим нэг болохгүй байгаа зүйл заалтуудыг нь бол ингээд дэмжээд явахаас, зарим нэг хуулийг нь дэмжээд явахаас өөр аргагүй нөхцөл байдалд байгаа юм. Тэгэхээр эрчим хүч гэдэг бол ерөөсөө өдөр, хоног алдах болгонд хэн хохирдог вэ гэхээр л ерөөсөө л ард иргэд, улс орон, эдийн засаг, бизнес эрхлэгч нар хохироод явж байдаг. Бид нар эдийн засгийн тусгаар тогтнолын асуудлыг ярьдаг мөртөө эрчим

хүчний тусгаар тогтнол нь өөрөө тэрний суурь гэдгээ бүгдээрээ мэддэг. Тэгээд тийм учраас энэ удаадаа зарим тохиолдолд бид нар бас нэг удаагийн үйлчилдэг хууль хүртэл батлах тийм шаардлага үүснэ. Одоо бид нар сарын өмнө тэр Гадаадын зээл ашиглалтын хуулийг бас ингээд л яриад л, санаачлаад л, бэлдээд, өргөн барих гээд л бэлдээд л явж байгаа. Энэ чинь асуудал юу байна гэхээр тэр бид нар 1 удаагийн хуулиар ч гэсэн хамаагүй 1 алхам урагшлаад явах асуудлуудаа шийдээд явахгүй бол энийг хойшлуулна гэх юм бол намрын чуулган хүртэл явчих байхгүй юу. Тэгээд тэр хооронд чинь эрчим хүч тасалдсан хэвээрээ л байна. Нөгөө асуудлуудаа шийдэж чадахгүй хэвээрээ л байна. Нөгөө гаднын хөрөнгө оруулалтаа татаж чадахгүй хэвээрээ л байна. Энэ асуудлуудыг бид нар өнөөдөр ингээд зоригтой шийдээд явсан нь зөв байх. Тэгээд хууль дээдэлж, баримталж гүйцэтгэх тэр ажлыг бол манай Эрчим хүчний яам өөрөө хариуцан хийгээд явна биз. Чойжилсүрэн сайд өөрөө толгойгоороо хариуцаад явна биз. Тэгээд энэ удаа бид нар бодлогын асуудлыг нь дэмжээд явах нь зүйтэй юм болов уу гэж харж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд хариулах юм уу. Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Хамгийн гол нь энэ төр хувийн хэвшлийн түншлэл болон Засгийн газраас өрийн баталгаа гаргах энэ асуудал дээр л болгоомжтой хандах хамгийн том асуудал байгаа. Түүнээс эрчим хүчний төслүүдийг бол мэдээж дэмжье гэж байгаа. Яагаад гэвэл өрсөлдөөн нэмэгдэж байж, үнэ хямдарна. Экспортын шинж чанартай эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлэх нь бол аль ч улсын хамгийн том бодлого. Тэгэхээр энэ дээр би бол өмнө нь ч бас хэлэлцэх эсэх дээр саналаа хэлсэн. Зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа. Өрийн удирдлагын тухай хууль бол энэ орж ирж байгаа Эрчим хүчний тухай хууль дээр дотоодын хэрэглээний цахилгаан эрчим хүчний хэрэглээний 40 хувиас илүүгүйд нь Засгийн газрын өрийн баталгаа болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах ийм таазыг л тогтоож өгөх ёстой гэж үзэж байгаа. Тэгэхгүй бол олон нийтээс ингээд 7, 8 центээр, 8, 9 центээр ийм тогтворжуулалтын өөрөөр хэлбэл Оюутолгойн гэрээ шиг гэрээ байгуулчихаад байна. Тэгээд энийг байгуулчихаар тэрнээсээ заавал авах үүргийг төр хүлээх гээд байна. 1-д.

2-т нь хувийн хэвшилд хэрэгжүүлэх боломжтой зүйл дээр төр тодорхой хувийг нь гаргаж, эргэж энийг төрд худалдаж авч, эх үүсвэрийг төр өөрөө ажиллуулах ийм эргэлзээтэй асуудал байна л гэж үзэж байгаа юм. Түүнээс биш энийг эрчим хүчний төслүүдийг дэмжих, хурдан хугацаанд хэрэгжүүлэх, энэ маргаантай байгаа асуудлуудыг цэгцлэх нь бол зөв. Тэгэхдээ ийм тодорхой таазыг тогтоож өгсөн тохиолдолд миний хувьд бол дэмжинэ гэдгээ илэрхийлж байгаа. Ингээгүй тохиолдолд бол дэмжих боломжгүй. Яагаад гэвэл энэний ард олон үр дагавар бас гарах гээд байгаа. Гишүүдийн хувьд ч тэр, ард олон нийтийн хувьд ч тэр, аж ахуйн нэгжийн хувьд ч тэр тодорхой хэмжээнд энэ дээр бол хардалт байна. Тийм учраас энэ нь эргэлзээг заавал энэ хууль дээр тодорхой тааз өгөх ёстой. Өөрөөр хэлбэл Монгол Улс ДНБ-ийхээ 60 хувиас илүүгүйд нь гадаад өр байж болно гэдэг ийм зохицуулалт байдагтай адилхан бид нар дотоодын хэрэглээ буюу одоогоор 1600-1700мвт Монгол Улсын дотоод хэрэглээний 40 хувь буюу 680 орчим мегаватт хүртэл эх үүсвэрт нь Засгийн газар баталгаа гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах энэ асуудлыг л шийдэж өгч ийм тааз хязгаар тогтоож өгөх ёстой л гэж үзэж байгаа. Энийг хангаагүй тохиолдолд бол ийм аймар олон жагсаалт байна шүү дээ. Энэ чинь одоо хэдэн жагсаалт юм бэ. Бараг 30 жагсаалт байгаа. Тэгээд энэ бол тийм оновчтой зүйл биш шүү дээ. Ийм жагсаалт бидэнд зөндөө байгаа. 14 мега төслөөсөө эхлээд жагсаалтууд зөндөө байгаа. Тэгээд энэ бол тийм ач холбогдолтой биш гэж үзэж байгаа. Хамгийн гол бид нарын шийдэх гээд

байгаа зүйл нь одоо энэ эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хараат байдлаас гаргах. Гэхдээ нэмэгдүүлэхдээ төр энэ дээр өр ард түмний өмнөөс тавихгүй байх гэдэг ийм л зүйл байгаа шүү дээ.

Р.Сэддорж: Тайлбарлая. 3 номер.

Б.Чойжилсүрэн: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Болгоомжилж байгаа нь зөв л дөө. Бадамсүрэн гишүүнтэй байнга би санал нэг байдаг хүн. Ямар нэгэн тооцоогүй, эргэн төлөх бололцоогүй ийм төслүүд дээр өр нэмээд, Монгол Улсыг дампууруулчих байдалд оруулчих вий гэж л санаа зовоод байх шиг байна. Тэгэхээр аргагүй энэ дээр зөв. Ийм шүү дээ, Бадамсүрэн гишүүн ээ. Жил жилийн Улсын Их Хурал төсвийн батлахдаа тодотголоор ч ялгаагүй, төсөв батлахдаа Монгол Улсын Засгийн газрын өрийн дээд хязгаарыг тодотголтой хамт батлаад өгдөг. Энийг Сангийн яам төсвийн төслийг боловсруулаад, бүх яамдаас саналыг нь аваад, нэгтгээд боловсруулаад Засгийн газарт танилцуулах үүрэг нь Сангийн яам дээр байдаг. Тэгэхээр энэ автоматаар нэн ялангуяа Монгол Ардын нам олонх Ерөнхий сайдаа томилоод хамтарсан байсан ч гэсэн Монгол Ардын намаас энэ 4 жилийн хугацаанд та бидний хувьд бол ийм тооцоогүй өрийг нэмэгдүүлэхгүй гэдэг нь ойлгомжтой. Ард түмэндээ ч бид нар амлачихсан зүйл. Тийм учраас та яриад байгаа зүйлийн чинь томъёоллыг санал гарга. Бид дэмжих талаар энэ томъёолол дээр нь ажиллая.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт. Зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт. Гишүүд санал хураалтад бэлдье.

Жаргалан гишүүний гаргасан саналын томъёолол.

Хуулийн төслийн 3.1.35-д нэмэлтээр оруулж буй дараах заалтаас Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс бусад” гэснийг хасах буюу тус заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:

“3.1.35.”Эрчим хүчний төсөл” гэж нэрлэгдсэн сүлжээнд холбогдон ажиллах эрчим хүчний эх үүсвэрийн зураг төсөл боловсруулах, эрчим хүчний барилга байгууламж барих, ашиглах, өмчлөх, шилжүүлэх, эрчим хүч үйлдвэрлэх цогц үйл ажиллагаа бүхий төслийг” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Санал тайлбарлах уу. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би Жаргалан гишүүнээс л асууя даа. Энэ чинь санал гаргаж байгаа гишүүн нь Жаргалан гишүүн. Сэргээгдэх эрчим хүчний төслийг би зүгээр өр нь дэмжинэ. Тэгэхдээ Монгол Улсын хувьд чинь энэ Сэргээгдэх эрчим хүчний хууль чинь тусдаа хуулиар явж байгаа 1 дүгээрт. Үүнтэйгээ яаж нийцэж байгаа юм бэ.

2 дугаарт Энэ сэргээгдэх эрчим хүчний өмнөх байгуулсан гэрээнүүд чинь дандаа завхрал байгаа шүү дээ. Завхрал. Асар өндөр үнэтэйгээр ямар ч нөөц хураагаагүйгээр ямар ч хэрэглээгүй үеэр эрчим хүчийг нийлүүлдэг. Оыргил ачааллын үед ямар ч дэмжлэг үзүүлдэггүй. Тэгсэн мөртөө энэ орж ирж байгаа эрчим хүчний салбар дахь орлогын хэдэн хувийг аваад явчхаж байгаа билээ. Энэ асуудал чинь маш хүнд тусаж байгаа.

Дээрээс нь гэрээ байгуулах маргаантай байгаа 30-аад төсөл байгаа. Гэрээ байгуулчихсан 9 төсөл явж байгаа. Энэ бүх асуудлууд чинь цэгцэлж байж бас энэ рүүгээ орохгүй бол ийм зуун задгай явчхаж болох юм уу. Тэгээд яг ямар асуудлаар ингэж орж ирж байгаа юм. Ер нь зүгээр яах вэ, сэргээгдэх эрчим хүч дээр бас барьж байгаа бодлого, энэ өөрөө эргээд яг тогтвортой, найдвартай эх үүсвэр биш шүү дээ. Энийг бас дэмждэг, магадгүй тэр найдвартай эх үүсвэрүүдтэй уялдуулж байж л энэ төслүүд хэрэгждэг. Тэгэхээр энэ сэргээгдэх эрчим хүчний хуулийн асуудал байна. Яагаад үүнтэй уялдаж орж ирж байгаа юм бэ.

2 дугаарт үүний үр дагавруудыг шийдээгүй байж ингэж орж ирж байгаа нь зөв юм уу л гэдэг зүйлийг хэлмээр байна.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Сайнзориг гишүүний асуултад хариулахад ер нь бол Монгол Улсын эрчим хүчний ирээдүйн 1 томоохон хэсэг бол сэргээгдэх эрчим хүч байгаа. Тэгээд ямарваа нэгэн байдлаар эрчим хүчний төслүүдээ явуулъя гэж үзэх юм бол бид сэргээгдэх эрчим хүчний төслүүдгүйгээр бас урагшаа явахад хүнд гэж харж байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд алдаа дутагдлууд гарсан зүйлүүд байгаа юу гэвэл байгаа. Гэхдээ сэргээгдэхийг ингэж тусад нь гаргаж байгаад бусад зүйл дээр өөр дүрэм журамтай явна гэдэг нь бол бас л яг энэ эрчим хүчнийхээ салбарыг бүхэлд нь хараагүй, тийм явцуурхсан байдал гэж харж байгаа учраас энэ саналыг гаргасан юм. Тэгээд нэгэнтээ энийг явуулъя гэж зорьж байгаа бол энэ салбараа бүхэлд нь хараад, энэ сэргээгдэх, ялангуяа тархмал эх үүсвэрүүд гэх мэтчилэн энэ зүйлүүдээ бас бариад явах ёстой. Тэгээд миний ойлгож байгаагаар 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд бол энэ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд дээр бол тодорхой зорилтууд Засгийн газрын зүгээс ч гэсэн тавигдсан байж байгаа. Тэгэнгүүт одоо жишээлбэл Засгийн газар бол тэр үйл ажиллагааны хөтөлбөрийг бол хэрэгжүүлэх үүрэг хүлээгээд явж байгаа гэж ойлгож байгаа. Гэтэл яг тэр хэсгээ ингэж хасаад, энэ хэсэг нь ийм дүрмээр явъя, нөгөө хэсэг нь ийм дүрмээр явъя гэдэг бол бас зарчимгүй зүйл гэдэг утгаар нь хэрэв нэгэнтээ энэ дүрмүүдээ өөрчлөх гэж байгаа бол л хамтарсан байдлаар тэгээд салбараа бүхэлд нь хараад, сэргээгдэхтэйгээ хамт хараад явах нь зүйтэй л гэсэн байдлаар энэ саналыг оруулж ирсэн шүү.

Р.Сэддорж: 3 номер Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Жаргалан гишүүний болгоомжлоод байгаа зүйлийг тайлбарлая. Энэ сэргээгдэх эрчим хүчнээс бусад гэдэг нь уламжлалт эрчим хүч гэдгээр оруулж ирсэн нь үнэн. Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль бол бүх хөнгөлөлттэй эх үүсвэрүүд нь тендер зарлах бүх бололцоо нь байгаа учраас хууль хоорондын зөрчил үүсгэхгүй л гэж л ярьж байгаа юм. Түүнээс биш Жаргалан гишүүний яриад байгаа сэргээгдэх эрчим хүчийг тодорхой хэмжээнд магадгүй тогтворжуулж чадах юм бол дийлэнх хэмжээнд нь сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх нь дэлхийн бүх улс орнуудын хандлага болж байна. Монгол Улс ч тийшээ явах байх. Тэгэхээр Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд яг асуудал байхгүй. Энэ хууль, эрх зүйн хувьд бүх хөнгөлөлтүүд нь явж байгаа. Байгаа учраас л энэ хууль хоорондын зөрчил үүсэхгүй гэж салаа утгатай ойлгуулахгүй гэж л бичсэн юм.

Р.Сэддорж: Ажлын албанаас энэ гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналуудыг тараасан уу. Дөнгөж сая ирсэн саналууд юм байна гишүүдээс. Цэнгүүн гишүүн Жаргалан гишүүнээс асуулт асууя гэж байна.

С.Цэнгүүн: Жаргалан гишүүнтэй бол би бас санал нэгдэж байгаа. Яагаад гэхээр энэ сэргээгдэх эрчим хүчний төслүүд бол гацаж байгаа шүү дээ. Ердөөсөө хөрөнгө оруулагч нараа бид нар дуудаад оруулаад ирчихсэн. Олон улсын хөрөнгө оруулагч, дотоодын хөрөнгө оруулагч нар ч байна. Энэ хүмүүс дээр тусдаг асуудал нь гэвэл тусгай зөвшөөрлөө хүлээгээд, ердөөсөө 1, 2 жилээ алдчихдаг. Арайхийж энэ тусгай зөвшөөрлөө авангуут дараагийнх нь сунгах шаардлагатай гээд ингээд маргаанууд нь ерөөсөө тасрахгүй яваад байдаг. Тэгэхээр чинь нэгэнтээ л саяын Чойжилсүрэн сайдын ярьж байгаагаар бол энэ эрчим хүчний төслүүдээ хурдан хөдөлгөө гэж байгаа юм бол бүх төслүүдээ гацаанаас нь гаргая л даа. Яагаад ганцхан нүүрсний эх үүсвэрүүдээ гаргачхаад, нөгөө талдаа сэргээгдэхүүдээ орхигдуулж хаяж байгаа юм бэ. Энэ дээр чинь бол маш олон талуудаас маш олон хөрөнгө оруулагч нар орж ирээд асуулт үүсгэж байгаа.

Дээрээс нь Монгол Улсын Засгийн газар ийм тодорхойгүй байдалтай байж болохгүй. Хэдхэн сарын өмнө л бид нар сэргээгдэх эрчим хүчийг дэмжинэ, тархмал эх үүсвэрийг дэмжинэ гээд олон хөрөнгө оруулалтын гэрээнүүд юмнууд хийгээд явж байсан. Доржханд сайд энэ дээр ажиллаад явж байсан. Гэтэл энэ асуудлууд чинь одоо яах юм. Бид нар ийм сонин салаа утгатай зүйлүүд яриад байж болохгүй. Тэгэхээр Занданшатар Ерөнхий сайд өөрөө энэ улсын бодлогоо үргэлжлүүлээд явна, тогтвортой байна гэж хэлсэн бол энэ дээрээ ч гэсэн ялгаагүй тогтвортойгоор, хурдтайгаар асуудлаа шийдэх гэж байгаа бол ямар нэгэн ялгаатай, ялгамжтайгаар байлгахгүй байсан нь дээр гэж бол харж байгаа шүү. Тэгээд Жаргалан гишүүний санал дээр бол анхнаасаа ер нь энэ төсөл дээрээ зөвөөр орж ирэх ёстой байтал чинь яагаад заавал энийг ийм сонин байдлаар утга учиргүйгээр оруулж ирсэн юм бол гэдгийг бас гайхаад л байна.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Горимын санал гаргая. Тэгэхээр маш олон гишүүд ч хэлээд байгаа шүү дээ. Энэ хууль дээр засах юмнууд зөндөө байна. Бид нар энэ хуулийг бол дэмжиж байгаа. Гэхдээ бид нар муу ч гэсэн, сайн ч гэсэн гишүүд шүү дээ. Хуульчид шүү дээ. Тэгэхээр энийгээ бид нар засаж залруулах юмаа хийе л дээ. Тэгэхээр ажлын хэсэг байгуулаад, 1 өдөр ч гэсэн сууя л даа. Тэгээд шууд зарчмын зөрүүтэй санал дээр санал хураана гэдэг чинь дэндүү хүчиндэж байгаа, дэндүү гишүүдийг доошоо хийж байгаа асуудал байна шүү дээ. Тэр ажлын хэсэг байгуулъя гээд түрүүн байгуулаад байх шиг байсан чинь одоо тэгээд ажлын хэсэггүй, шууд санал хураагаад яваад байх шиг байх юм.

Р.Сэддорж: Ажлын хэсэг байгуулъя гээд олон хурал дээр бас ярьсан л даа. Ярьж байсан боловч одоо тэгээд гишүүдээс яг тийм гаргасан горим санал алга байна шүү дээ. Өнөөдрийг хүртэл. Ингээд Энхцэцэг гишүүний гаргасан горимын саналаар ажлын хэсэг байгуулъя, гишүүд бас гаргасан зарчмын зөрүүтэй саналуудтай танилцах хугацаа хэрэгтэй байгаа учраас ажлын хэсэг гаргая. Өнөөдрийн хэлэлцэх асуудлаас ажлын хэсэг гаргаж ажиллах шаардлагатай байгаа учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас энэ асуудлыг хойшлуулж байна. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэгийн гаргасан горимын саналаар хэлэлцүүлгийг түр хойшлуулж, ажлын хэсэг байгуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Энхцэцэг гишүүн та өөрөө уншуулаач.

Батнайрамдал гишүүн горимын санал гаргая. *

О.Батнайрамдал: Байнгын хорооны дарга аа, төхөөрөмж ажилласангүй. Саналыг хүчингүй болгоод, дахин санал хурааж өгнө үү.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт санал хураалт. Санал хураалтад бэлдье гишүүд ээ. Батнайрамдал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн саналаар санал хураалт. 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Ингээд санал хураалтыг үргэлжлүүлье.

Ингээд Жаргалан гишүүний гаргасан саналаар санал хураалт. Дахин уншъя.

Хуулийн төслийн 3.1.35-д нэмэлтээр оруулж буй дараах заалтаас “сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс бусад” гэснийг хасах буюу тус заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:

“3.1.35. “Эрчим хүчний төсөл” гэж нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллах эрчим хүчний эх үүсвэрийн зураг төсөл боловсруулах, эрчим хүчний барилга байгууламж барих, ашиглах, өмчлөх, шилжүүлэх, эрчим хүч үйлдвэрлэх цогц үйл ажиллагаа бүхий төслийг” гэж өөрчлөн найруулах. санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргала. Санал хураалтад бэлдье. Жаргалан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгийн гаргасан саналын томъёолол. “6.20.эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ хуулийн 6.19-д заасан этгээдтэй төр хувийн хэвшлийн түншлэлээр эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх, түншлэлийн гэрээ байгуулах, холбогдох түншлэлд Өрийн удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 34.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд Засгийн газрын баталгаа гаргуулах саналыг Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Бадамсүрэн гишүүн өөрөө алга байна. Сайнзориг гишүүн санал дээр үг хэлье.

П.Сайнзориг: Би энэ Бадамсүрэн гишүүний санаа зовж байгааг бол бас дэмжиж байгаа юм. Тэгээд Чойжилсүрэн сайд бас хууль хэрэгжүүлэхдээ анхаарна биз. Хэрэвзээ Улсын Их Хурал энэ хуулийг дэмжээд, хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоол орох юм бол энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр байгаа 6.11.1 дээр байгаа. Энэ төсөл сонгон шалгаруулалттай холбоотойгоор эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлэх үнийн асуудал байж байгаа. Гэрээн дээр тусгах. Энэ үнийг 5 жил тутам авч үзэх ёстой. Авч үзнэ гэдэг нь шинэчлэх гэж байгаа асуудал нь бууруулж болно. Хэвээр хадгалж болно. Хэрэвзээ ийм хатуу байдлаар гар хүрч болохгүй ийм байдлаар гэрээ байгуулж сонгон шалгаруулах юм бол болохгүй. Түрүүчээсээ энэ гэрээ дээрээ энэ асуудлыг алдсан учраас өнөөдөр сэргээгдэх эрчим хүчний гарууд чинь яриа хэлэлцээрт орохгүй гээд үндсэндээ энэ төвийн эрчим хүчний системийг чинь татаж унагаахад бэлэн, маш өндөр үнэтэй ийм гэрээнүүдийг байгуулчхаад байгаа байхгүй юу. Би сэргээгдэх эрчим хүчийг дэмжинэ.

Хэрэвзээ сэргээгдэх эрчим хүчнийг дэмжих тэр найдвартай гэдэг юм уу, тогтвортой эрчим хүчний эх үүсвэрүүд бий болсны дараа үүнтэйгээ хослуулж балансруулж явдаг болохоос биш, түрүүлээд зэрэгцүүлээд явах юм бол үр ашгийн хувьд бие биеийгээ дэмжиж чадахгүй. Тэгэхээр энэ зарчмын хувьд байгаа. Тэгээд энэ тогтоол дээрээ нэмж орж ирэх 1 зүйлийг би зүгээр хэлж байгаа юм. Энэ хүрээн

дээрээ хуулийн төслийн 6.11.1-д заасан эрчим хүчний үнэ тарифыг 5 жил тутам хэлэлцээр хийж, зах зээлийн үнэ дээр тохируулга хийнэ. Энэ нь дандаа нэмнэ гэсэн үг биш шүү. Бууруулмаар байна. Эрчим хүчний өртгүүдийг төслүүд жоохон бас ашигтай ажиллаад, өртгөө нөхөөд ирэхээр бас энэ чинь бууруулдаг, зах зээл рүү нь өрсөлдөөний зарчим руу оруулдаг баймаар байна шүү. Тэгэхээр энийг бас Улсын Их Хурал яг энэ асуудал дээр яах юм бол хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолын 2 юм уу, 3 дахь заалт болгоод оруулмаар байна. Сэддорж дарга энийг анхаарч өгөөч ээ гэж хэлж байгаа юм.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд. 3 номер.

Б.Чойжилсүрэн: Бадамсүрэн гишүүний гаргасан санал дээр жоохон буруу яасан юм шиг байна. 35.35 дугаар зүйлийн 34.5 гэж бичсэн байна. Бадамсүрэн гишүүн ээ, энэ саналаа та харахгүй бол ийм заалт энэ хууль дээр байхгүй байна. 34.5 гэж бас байхгүй. 35.5 нь ийм байна. “Засгийн газрын өрийн баталгаа нь тухайн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт хамаарна.” гэсэн ийм заалт байна. Түр хойшлуулаад юу Бадамсүрэн гишүүн ээ, бид нар таныг санал гаргахад чинь туслах уу. Бадамсүрэн гишүүн.

Дараагийн санал С.Ганбаатар гишүүнээс гаргасан санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дах заалтын 6.3 дахь хэсгийн “эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” гэснийг “Эрчим хүчний зохицуулах хороо” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар. Мөн яг ийм ижилхэн санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Жаргалан гишүүний гаргасан санал. Тус хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг “Засгийн газрын шийдвэрийн дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран эрчим хүчний төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг тухай бүр байгуулна.” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. 2 ижилхэн санал байгаа учраас эхэлж дэмжигдсэн санал нь дэмжигдэнэ.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалан үг хэлье.

Б.Жаргалан: Энэ саналын гол санаа нь юу вэ гэхээр зөвхөн салбарын сайд буюу Эрчим хүчний сайд энэ төсөл төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг шийдвэрлэхгүй, давхар энэ түншлэлийн асуудал эрхэлсэн сайд буюу Хөгжлийн сайд энэ асуудалд оролцоно гэсэн илүү ийм хамтын шийдвэр гаргах ёстой л гэж хараад байгаа юм. Эс бөгөөс энэ чинь нэг хүн дээр хамаг эрх мэдлийг овоолоод байгаа ийм зүйл болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр түншлэлийн асуудал хариуцсан сайд нь бас энэ асуудал дээрээ хамтарч оролцоод ийм хамтын удирдлагаар хангаад явах ёстой л гэсэн санаа.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Сэддорж дарга аа. Жаргалан гишүүний гаргаж байгаа саналыг нь биелүүлэх бололцоотой. Хууль зүйн хувьд бололцоотой. Тийм учраас дэмжмээр байна. Нөгөө Эрчим хүчний зохицуулах хороо гэдэг маань төсвийн ерөнхийлөн захирагч биш, Ерөнхий сайдын захирамжаар баталдаг 3 гишүүнийг нь

Эрчим хүчний сайд санал болгодог, 2 гишүүнийг Худалдаа Аж Үйлдвэрийн танхим болон энэ хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс санал болгодог учраас тэр Эрчим хүчний зохицуулах хороо Эрчим хүчний хуультайгаа зөрчилдөнө. Үнэ тарифыг өөрсдөө баталдаг учраас түрүүчийн Ганбаатар гишүүний санал бол хууль зөрчигдөх ийм санал байгаа.

Гишүүд анхааралтай санал хураалтад оролцъё. Эхлээд Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт. Санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтад бэлдье. Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал эмжигдсэнгүй.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэгийн гаргасан зарчмын зөрүүтэй санал.

“6.3 эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг эдийн засаг, хөгжлийн, санхүү, төсвийн ба эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд томилно.

6.4.Энэ хуулийн 6.3-д заасан ажлын хэсэг 9-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дараах нэмэлт өөрчлөлтийг оруулах саналтай байна.

“1 дүгээр зүйл эрчим хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.35, 3.1.36 дахь заалт:

“3.1.35.“Эрчим хүчний төсөл гэж нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллах сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс бусад эрчим хүчний эх үүсвэрийн зураг төсөл боловсруулах, эрчим хүчний барилга байгууламж барих, ашиглах, өмчлөх, төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлсэн тохиолдолд шилжүүлэх ,эрчим хүч үйлдвэрлэх цогц үйл ажиллагаа бүхий төслийг;

3.1.36-г бүхэлд нь хасаж байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэгийн гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

33,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Одоо бид хэд бол яг ингээд олонхын саналаар л явж байгаа. Эхлээд хойшлуулъя гэсэн дэмжигдээгүй. Дараа нь ажлын хэсэг гаргая гэсэн бас дэмжигдээгүй. Ингээд л яг олонхынхоо зарчмаар л явж байна.

2.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дараах нэмэлт өөрчлөлтийг оруулах саналтай байна.

“6.3.эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

6.4.Энэ хуулийн 6.3-д заасан ажлын хэсэг 9-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

6.4.1.гишүүдийн 3-ыг нь эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон байх

6.4.2.гишүүдийн 2-ыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон байх

6.4.3.гишүүдийн 2-ыг нь эдийн засаг хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон байх

6.4.4.гишүүдийн 2-ыг нь тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн холбоод төрийн бус байгууллагын төлөөлөл байх

6.11.Сонгон шалгаруулалтын баримт бичигт эрчим хүчний төслийн онцлогтой уялдуулан доор дурдсан нөхцөлийг харгалзан үзнэ.

6.11.1.эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх үнэ

6.11.2.эрчим хүчний төслийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэх тохиолдолд төрд шилжүүлэх нөхцөл хугацаа

6.11.3.Төслийн хугацаанд нийлүүлэх эрчим хүчний хэмжээ

6.11.4.төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийн хэмжээ

6.11.5.санхүүжилтийн зардал

6.11.6.туслан гүйцэтгэгчийн чадавх болон туршлагын шаардлага

6.11.7.төслийн эрсдэл, хариуцлага хүлээх чадамж, баталгаа

6.11.8.төслийн үйл ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл

6.12.эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах урилгад дараах мэдээллийг тусгана.

6.12.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр төсөл хэрэгжүүлэх тохиолдолд түншлэлийн төрөл

6.12.2.Санхүүжилтийн эх үүсвэрийн тодорхой хэсгийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлэх эсэх

6.12.3.Сонгон шалгаруулалт зохион байгуулах хэл

6.12.4.Дэнчингийн хэмжээ

6.12.5.энэ хуулийн 6.11 дэх заасан нөхцөл

6.12.6.гүйцэтгэлийн баталгааны хэмжээ

6.12.7.сонгон шалгаруулалтын үе шат

6.12.8.эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх дээд үнэ. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг. Энхцэцэг гишүүн саналаа тайлбарлая.

М.Энхцэцэг: 1 дүгээр санал болохоор нөгөө 5-аас дээш хүн гэгчихсэн байсан, тэрийг 9-өөс дээш болгоё. Тэгэхгүй бол 5 хүн эрсдэлд орно гээд. Тэгээд 3-ыг нь болохоор Эрчим хүчний яамнаас, 2-ыг нь Сангийн яамнаас, 2-ыг нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2-ыг нь, төрийн бус байгууллага гээд энэ бол тэр 5 хүнээ хамгаалж байгаа чухал заалт. Энийг дэмжих нь зүйтэй байх.

2-т нь болохоор тэр эрчим хүчний төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлсэн тохиолдол гэж ингэж тодотгож өгөхгүй бол бүх л төсөл үүгээр явчхаж байгаа юм шиг харагдаад байгаа юм. Тэр 6.11.2 дээр.

6.12.1 дээр мөн адилхан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр төсөл хэрэгжүүлэх тохиолдолд түншлэлийн төрөл гэж бас яг ингэж тодотгож өгье гэж заалт орж байгаа.

Дараа нь болохоор тэр 6.12.8 дээр болохоор эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлэх дээд үнийг өөрөөр хэлбэл та нар юу гэдэг юм 8 центээс доошоо өрсөлдөөрэй, 7 центээс доошоо өрсөлдөөрэй гэж нөгөө гап үнэ тавьж өгдөг энэ бол олон улсын туршлага юм байна лээ. Энэ дээр дэмжиж өгөөрэй гээд. Тэгээд түрүүний өмнөх санал дээр болохоор миний тайлбарыг сонсохгүй санал хураачихсан. Энэ дээр жаахан тиймэрхүү байна.

Р.Сэддорж: 3 номер.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүн ээ, энэ саналаа та 2 хуваагаад гаргаж болохгүй юу. Тэр дээд үнэ гэдгийг чинь шууд хүлээж авъя. 2 дугаарт тэр 9-өөс доошгүй гэхэд зарим том тендерүүд чинь 21, 23 гишүүнтэй болно шүү дээ. Тэгэхээр бусдыг нь яах вэ гэдгийг нөгөө процентлохгүй бол 23 гишүүнтэй ч байгуулж байгаа шүү дээ. Тэгэхээр чинь нөгөө тэр дээд үнээ тавиад, процентлохгүй бол энэ чинь .../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгээс гаргасан санал хураалт байна. Саналын томъёолол.

“6.20 эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ хуулийн 6.19-д заасан этгээдтэй төр, хувийн хэвшлийн түншлэлээр эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх түншлэлийн гэрээ байгуулах, холбогдох түншлэлд Өрийн удирдлагын тухай хууль хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд Засгийн газрын баталгаа гаргуулах саналыг Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Саналаа тайлбарлая Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Дараалал нь бол нөгөө зарчмын зөрүүтэй саналаасаа эхэлбэл логикийн дараалал нь бол зөв болно. Тэгэхдээ нэгэнт Байнгын хорооны дарга уншихсан учраас ер нь түрүүн би асуулт асуухдаа хэлсэн. Ер нь гол болгоомжлол маань Засгийн газар баталгаа гаргах, энэ төслүүд хэтэрхий их болчих вий.

2 дугаарт Оюутолгой шиг тогтворжуулалтын гэрээ байгуулаад Бөөрөлжүүтийн цахилгаан станц шиг энд нь төр үүрэг хүлээгээд, тэгээд дотоодын цахилгаан станцууд үндсэндээ зах зээлгүй болох вий гэдэг болгоомжлол байгаа. Тийм учраас

нийт Монгол Улсын хэрэглээний 40-өөс илүүгүй хувьд нь Засгийн газар баталгаа гаргах, 40-өөс илүүгүй эх үүсвэрийнх нь хүчин чадлынх нь 40-өөс илүүгүй хувьд нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах гэдэг ийм л тааз тогтоож өгвөл яг нөгөө ДНБ-ий тэдэн хувиас дээшгүйд гадаад өр байж болохгүй гэдэг шиг Засгийн газрын төсвөөс хариуцах, татвар төлөгчдийн мөнгөнөөс хариуцах энэ асуудал дээр тааз тавьж өгнө л гэж үзэж байгаа юм. Тэгэхгүй бол одоо ийм байгаа байхгүй юу, энэ танилцуулга дээр 5 мянга гаруй мегаваттын тусгай зөвшөөрөл олгочихсон байгаа. Бүгд дээр нь Засгийн газар баталгаа гаргавал яах вэ. Бүгд дээр нь төр хувийн хэвшлийн гэрээ байгуулбал яах вэ. Тэгвэл энэ дотоодын бүх цахилгаан станцууд чинь борлуулалтгүй болох уу. Тийм учраас энэ бол том сэдэв болно шүү. Ялангуяа улс төрийн сэдэв болно шүү.

Тийм учраас миний хэлээд байгаа санал нь энэ зүйлийг нухацтайгаар хэлэлцээд, энэ хуулийг баталж, эрчим хүчний салбараа хурдан эх үүсвэрээ нэмэгдүүлэх эрчим хүчний энэ өөрсдийн үүсээд байгаа ачааллыг бүрэн хангах нь зөв. Тэгэхдээ энийгээ дэмжих нь зөв гэж үзэж байгаа юм. Энд тодорхой тааз тавьж өгөөд. Тэгэхгүй бол ийм л эрсдэл үүсгэх вий. Өөрөөр хэлбэл ямар ч хяналтгүйгээр 4, 5мвт цахилгаан станц барих энэ зүйлийг энэ жагсаалтад байгаа шиг гэрээ байгуулаад явчихвал яах юм бэ л гэдэг асуудал байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас бид нар энийг нэгэнт хууль тогтоогчид юм бол энэ дээрээ нухацтай хандаж, нухацтай ажиллаж энийг зөвөөр гаргах ёстой шүү. Зөвөөр гаргах ёстой. Тийм учраас та бүхнийгээ бас дэмжиж өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Бадамсүрэн гишүүн ээ, ингэж болохгүй юу. Ингээд хууль батлагдсантай холбогдуулаад Улсын Их Хурлын тогтоол гарна. Энэ таны энэ яриад байгаа болгоомжлолыг Сангийн яамныхантай бас зөвшилцье. Ямар нэг байдлаар ер нь хэтрүүлэн өр тавих асуудлыг бол хаах. Тэгэхгүйгээр одоо энэ хөндөөгүй заалт дээр ийм заалт оруулахаар юу 40 хувь гэхэд төвөгтэй байна. Жишээлбэл дамжуулах шугамыг бараг 100 хувь төр баталгаа гаргаж бариулахгүй бол дамжуулах шугам руу хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч бараг олдохгүй. Дамжуулах шугам барихгүй бол бид нар эх үүсвэр, хэрэглэгч 2-ыг хооронд нь холбож чадахгүй. Тэгэхээр тэр Улсын Их Хурлын дагаж гарах тогтоол дээр бүр сайн суувал яасан юм бэ.

Р.Сэддорж: Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд ээ, санал хураалтад санал хураалт. Батчимэг гишүүн ороогүй байна. Ганхуяг, Жаргалан гишүүн, Лодойсамбуу гишүүн.

Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 6.18 дахь заалтын “сонгон шалгаруулахдаа” гэсний дараа “төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу” гэж нэмэх. Энэ техникийн шинжтэй саналуудыг гаргаж байна. Улсын Их Хурлын гишүүн миний бие гаргаж байна. Дахин уншъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дугаар заалтын 6.18 дахь заалтын “сонгон шалгаруулахдаа” гэсний дараа “төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу” гэж санал нэмэх. Техникийн шинжтэй, редакцын засварууд. Ингээд санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Дараагийн хуулийн төсөл.

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригоор тасалъя. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Өнөөдөр чинь бид нар бараг бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлээд, тангараг өргөөд 1 жилийн ой болж байгаа. Яг нэг жилийн өмнө л энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль хэрэгжихгүй байгаа шүү, Монгол Улсын эдийн засгийг тэлэх дэмжих гэхээсээ илүүтэй чөдөрлөөд зогсчихсон байгаа гэдэг зүйлийг би хэлж байсан. Эдийн засаг, хөгжлийн яам дээр анхаараач гэдэг зүйлийг удаа дараа хэлсэн. Төсөв батлагдаж байхад дагаж байгаа тогтоолуудаа яаралтай өргөн барихыг шаардсан ийм л зүйл байгаа. Тэгээд энэ ажлууд ерөөсөө явахгүй байна.

Тийм учраас ер нь цаашдаа энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль гээд түншлэл хэрэгжүүлэхгүй гэсэн хууль шүү. Монголд битгий хөрөнгө оруулалт орж ирээрэй гэсэн үзэл санаагаар энэ хууль батлагдсан. Энэ үе дээр нь тухайн үедээ ийм хариуцлагагүй хууль болж байна гэдэг зүйлийг хэлсэн. Тэгээд өнөөдрийн бүх зүйлүүдийг ингээд чөдөрлөөд зогсчихсон, төрд байгаа эдийн засгийн нөөц бага байгаа хувийн хэвшилтэйгээ хамтарч, хувийн хэвшил ажлын байр бий болгодог энэ томоохон мега төслүүдийг Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нь хамгийн том хяналт юм. Хувийн хэвшил энэ орж ирж байгаа төслүүд дээрээ бид нараас илүү, төрийн институтээс илүү хяналт тавина. Төрийн институтээс илүү үр ашигтай байх зүйлийг тавина. Бид нар харин тэгэхдээ энэ дээрх ашиг сонирхол янз бүрийн юм дээр нь бас хяналтаа тавих ёстой юм. Тэгээд энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль Засгийн газар хаана явдаг юм бол доо. Би бол жил нэхэж байгаа. Яагаад гэхээр энэ зовлонг нь нийслэлд байж байхдаа энэ томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж гээд энэ бүх юмыг гацаачихсан байсан байхгүй юу. Нийслэлийн хэмжээнд бас Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхэд 6 чиглэлээр гарц нээсэн юм. Зөвхөн нийслэл биш, хүн ам нь 100 мянгаас дээшээ болон улсын төсвөөс татаас авдаггүй аймгууд 6 чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэл хэрэгжүүлж болохоор байгаа. Тэгээд өнөөдрийн энэ процессоор бол төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх юм бол жилийн хөгжлийн төлөвлөгөөнд оруулах, бичиг баримтууд ингээд явах юм бол нэг жижигхэн асуудал байсан ч 2 жил, 3 жил үргэлжилж хийх юм байгаа юм. Тэгээд энэ ингээд боломжгүй. Тэгээд ийм зүйлүүдийг бид нар өөрсдөө парламент, эдийн засгаа чөдөрлөөд зогсоочихсон хуулийг баталдаг. Тэгээд бид хэд бас алдаагаа шуурхай засах ёстой байгаа юм. Тэгэхдээ засах энэ процессыг нь Засгийн газар бас санаачилгатай оруулж ирээч ээ. Тэгээд яах вэ энэ удаагийн Чойжилсүрэн сайдын оруулж ирж байгааг зарчмын хувьд дэмжээд явна.

Цааш цаашдаа салбарууд ингэж авч явахгүйн тулд нэгдмэл байдлаар энэ дээрээ асуудлуудаа цэгцлээд ороод ирээч ээ гэдэг зүйлийг хүсмээр байгаа юм. Тэгээд орон нутагт эрх мэдлийг нь өг. Солонгос жишээ нь 500 тэрбум вон хүртэлхийг орон нутагт өгдөг байхгүй юу. Тэгэхдээ мэдээж орон нутгийн тэр төсөв санхүүгийн сахилга бат, эргээд тэр тухайн улсын ДНБ-д бүс нутгийн бас эдийн засгийн чадавх, онцлогийг нь харгалзалгүй яах вэ. Энэ бүх зүйлүүдийг бас цэгцтэй авч яваад, орон

нутгууддаа бас итгэдэг баймаар байна. Тэнд ажил хиймээр байна шүү дээ. Тэнд чинь хүн амьдарч байгаа байхгүй юу. Тэнд бас эдийн засаг, зах зээл өсмөөр байна, тэлмээр байна, шинээр нээгдмээр байна. Тэгээд бүх зүйлүүдийгээ аваачаад төвлөрүүлээд, гацаачхаад, тэгээд бие бие рүүгээ уянгалаад л яваад байдаг ийм зүйлүүд манай төрийн хэвшмэл ойлголт боллоо. Хэвшмэл .../минут дуусав/

Р.Сэддорж: Гишүүдийн гаргаж байгаа саналуудыг хуулийн зөвлөхүүд, сайдын зөвлөхүүд, Эрчим хүчний яамныхан сайн ойлгож байгаа биз дээ. Та хэд 1 л юмыг чадахгүй байгаа шүү дээ. Тийм ээ. Сэргээгдэх эрчим хүчээ хослуулж хэрэглэж чадахгүй байгаа. Тэгээд бүх гадаадын одоо 8, 9-нд болох эдийн засгийн форум дээр энэ их яригдана. Сэргээгдэх эрчим хүч, нар салхины эрчим хүчний төслүүдийн талаар. Тэгээд даанч та хэд маань энэ гарц гаргалгааг бол өнөөдрийн байдлаар сайн шийдэж чадахгүй байгаа. Тэгээд сумууд нь бол гадаад улсаас аймаг, сумууд эрчим хүчээ аваад л ингээд явж байгаа.

Ингээд дараагийн санал хураалтыг явуулъя. 2 Их Хурлын гишүүний санал байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр уг хуулийн төслийн 2.15 дахь зүйлийн 15.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Мөн яг ижилхэн Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэгээс энэ хуулийн төслийн 15.4.1-д менежментийн үйлчилгээ санхүүжүүлэх болон зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх гэсэн заалтыг хэвээр үлдээж, 15.4, 15.4.2-ыг хасах гэсэн ийм санал гаргасан байна. Ингээд түрүүлж Улсын Их Хурлын гишүүн Жаргалан санал гаргасан байна. Саналаа тайлбарлая. Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Би бол энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль өөрчлөгдөөд, дотоод гадаадын хөрөнгө оруулалт илүү нээлттэй байх ёстой гэдэг асуудлыг бол зарчмын хувьд бүх талаараа дэмждэг. Тэгээд сая Сайнзориг гишүүний хэлсэнчлэн өнгөрсөн 1 жилийн хугацаанд харамсалтай нь Засгийн газар бол энэ хуулиа оруулж ирээгүй. Бид нар бол бас зөндөө олон байдлаар нэхсэн. Тэгэнгүүт энэ Эрчим хүчний тухай хуулийг эсэргүүцээд байгаа нь юу вэ гэхээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль маш олон зүйл тэр чөдөр тушаа болоод байна гэж хэлээд, зөвхөн 1 салбар дээр аваачаад ийм exception гаргаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь нөгөө хууль дээдлэх зарчим энэ тэртэй чинь харшлаад байна гэдэг тийм л зарчмын шүүмжийг хэлээд байгаа. Яагаад вэ гэхээр өнөөдөр магадгүй энэ эрчим хүчний салбар маш хүнд байгаа гээд асар олон төслүүдийг энэ хөнгөлөлт, чөлөөлөлт рүү оруулчихлаа гэж үзэхэд дараа нь маргааш нь мэдэхгүй ямар салбар байх юм. Банкны салбар нь байх юм уу, эсвэл харилцаа холбооны салбар нь байх юм уу гэх мэтчилэн бид нар аливаа зүйлийг бүхэлд нь авч үзэхгүй ийм хэсэгчилсэн хэсэгчилсэн байдлаар зэрэмдэглээд байх юм бол бүр л асуудалтай болно гэсэн үг. Тэгэхээр энэ Эрчим хүчний тухай хуулийн төсөлтэй хамт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль 2-т өөрчлөлт орж байгаа. Тэгэнгүүт энэ өөрчлөлт оруулж байгаа заалтууд нь болохоор тухайн яг хуулийнхаа үндсэн үзэл баримтлалтай нь зөрчилдөж байгаа заалтууд орж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бол жишээлбэл энэ 15.4-ийг хасах нь бол ерөөсөө энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д заасан энэ хуулийн хүрээнд барих шилжүүлэх төрлөөр барьж байгуулаад, шууд шилжүүлэх нөхцөлтэй, богино хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтаас үл ялгах төрлийн гэрээг байгуулах болон түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглоно гэсэн заалтыг хамаарахгүй болгох нь бол уг хуулийнхаа үзэл баримтлалтай зөрчилдөөд байна гэж

үзээд, хасах заалт оруулж ирж байгаа юм. Тэгэхгүй бол бид нар зэрэмдэглээд л байна гэсэн үг.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн саналаа тайлбарлая.

М.Энхцэцэг: Би ямар санал гаргасан гэхээр 15.4, 15.4.2, 21.11-ийг хасаад, тэгээд 15.1.14 дээр менежментийн үйлчилгээг санхүүжүүлэх болон зураг төсөл боловсруулах, ашиглах, шилжүүлэх гэснийг үлдээж байгаа юм.

Тэгээд үндэслэл нь болохоор одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай болон Эрчим хүчний тухай хуулиудаар эрчим хүчний салбарт хэрэгжих төслийг түншлэлийн хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд тухайн төслийн онцлог, хэрэгцээ шаардлагад тулгуурлан хувийн хэвшлийн түншлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр түншлэлийн аль ч хэлбэрээр зохион байгуулах боломжтой бөгөөд түншлэлийн тодорхой нэр төрөл заах нь хууль зүйн үндэслэлгүй байна. Иймд 15.4 дэх заалтыг 15.1.14 болгон өөрчилж, түншлэлийн төрөлд хамааруулах нь үндэслэлтэй юм. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15.3-д энэ хуулийн хүрээнд барих, шилжүүлэх, төрлөөр барьж байгуулаад, шууд шилжүүлэх нөхцөлтэй, богино хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтаас үл ялгагдах төрлийн гэрээг байгуулах болон түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглоно гэж заасан байдаг тул бариад шууд шилжүүлэх нөхцөл тусгасан заалтыг энэ хуульд оруулах боломжгүй байна. Учир нь төрийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээр төсөл хэрэгжүүлэх байгаагаас ялгаагүй зүйл болох бөгөөд энэ талаар нарийвчлан зохицуулсан төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хамрах хүрээний асуудал байх тул ийм төрлийн түншлэл байхыг хуулиар хориглодог. Харин менежментийн үйлчилгээ нь зөвхөн төрийн өмчлөлийн төсөлд хийгддэг үйлчилгээ тул үүнийг барих, шилжүүлэх харилцаанд хамт оруулсан нь барих шилжүүлэхэд үйл явцад ямар нэгэн ялгаатай байдал үүсэхгүй бөгөөд бариад шууд шилжүүлэх эрх зүйн үр дагаварт хүргэсэн хэвээр байх тул дээр дурдсан 15.3-д заасан хоригт хамаарахгүй байна. Үүнээс гадна энэхүү заалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-д тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх, 29.1.4-д тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх, 29 9.1.5-д зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх гэж тус тус заасныг зөрчиж байна. Иймд тухайн заалтыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөс хасах үндэслэлтэй байна.

Р.Сэддорж: 3 номер Чойжилсүрэн сайд тайлбарлая.

Б.Чойжилсүрэн: Энэ амьдрал ийм байхгүй юу Энхцэцэг гишүүн ээ, Тавантолгойн тендерийг бид нар яасан гэхээр 30 хувийг нь төр санхүүжүүлбэ. 30 хувийг нь и пи си контрактор нь зээлээ босгоод ирье гэсэн байхгүй юу. 70 хувийг нь. Тэгээд яах вэ гэхээр ингээд станц босчихно. Энэ станц босоод сая таны санал гаргаж байгаа санал дэмжигдэх юм бол тэр 70 хувийг босгож ирсэн и пи си контрактор тодорхой хугацаанд энэ станцыг эзэмших гээд байгаа байхгүй юу. Бид бол шууд бариад л төрд авахаар төр өөрөө 100 хувь эзэмшээд явахаар энэ заалтыг оруулж ирсэн байхгүй юу. Тэгэхээр та дутуу ойлгосон шиг байна. Энэ саналыг яахгүй бол магадгүй тодорхой хугацаанд заавал нөгөө и пи си хэрэгжүүлсэн нөхөр нь тэр станцыг барих гээд байгаа юм. Энэ бид нар богинохон хугацаанд 5 жилийн дотор зээлээ төлчих ийм техник, эдийн засгийн тооцоолол гарч байгаа нөхцөлд

заавал тэр хөрөнгө оруулагчид эзэмшүүлээд байх шаардлагагүй, шууд авчихсан нь дээр шүү дээ. Таны хараад байгаа эрсдэлийг хаахын тулд энэ төсөл нь өөрөө мөнгөн урсгалаараа санхүүгийнхээ тооцооллоороо эргэн төлөгддөг нөхцөлд энэ төслийг явуулна гээд Өрийн удирдлагын тухай хуульд хашилт хийчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхгүй таны саналыг дэмжчих юм бол энэ юу яана. Тэгэхээр аягүй бол төрд шууд авчих байсан юмыг яагаад тодорхой хугацаанд хувийн хэвшлийнхэнд эзэмшүүлэх гээд байгаа юм бэ гэдэг асуултууд гарч ирэх байхгүй юу. Амьдрал дээр л гарч ирсэн санал.

Р.Сэддорж: Эхлээд санал хураалтыг явуулъя. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 33,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ингээд санал дэмжигдээгүй учраас одоо Энхцэцэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Энхцэцэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 33,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэгийн гаргасан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дэх хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлтийн санал.

“1 дүгээр зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.1.14, 10.1.15 дахь заалт:

10.1.14.Түншлэлийн төсөлд төсвөөс санхүүжүүлэх санхүүжилт хийх тохиолдолд хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусгуулах санал хүргүүлэх.

10.1.15 дах хэсгийг бүхэлд нь хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг.

Энхцэцэг гишүүн тайлбарлах уу. Энхцэцэг гишүүн тайлбарлая.

М.Энхцэцэг: Саналын үндэслэл нь болохоор 10.1.4-д санхүүжилт хийх тохиолдолд гэсэн нэмэлт оруулахгүй тохиолдолд энэ заалт нь бүх түншлэл заавал төсвийн санхүүжилт байх шаардлагатай байх эрх зүйн дагаврыг үүсгэж байгаа тул ийнхүү нарийвчилсан заах шаардлагатай байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 33.3-д түншлэлийн гэрээнд төрийн түншлэгч талыг төлөөлж Засгийн газрын эрх олгосноор төсөл хэрэгжүүлэх салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсөл хэрэгжих орон нутгийг төлөөлж аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга гарын үсэг зурж баталгаажуулна гэж заасан байдаг бөгөөд энэ нь хэн түншлэлийн гэрээг байгуулах эрхтэй талаарх тодорхой заасан зохицуулалт юм. Иймд 10.1.15 дахь заалтыг нэмэх нь ямар нэгэн үндэслэл хэрэгцээ шаардлагагүй байна.

Р.Сэддорж: Ингээд Энхцэцэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 3 номер. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүн ээ, та бас дутуу ойлгосон байна. Бид нар дутуу тай тайлбарласан буруугаа хүлцэл өчиж байна. Энэ заалтыг хасаад хаячих юм бол гэрээ байгуулах эрхгүй болно. Өнөөдрөөс хойш, өнөөдрийг хүртэл хийсэн бүх ажил утгагүй болно гэсэн үг. Гэрээ байгуулахгүй болно.

Р.Сэддорж: Санал хураалт явуулъя. Энхцэцэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 22,2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Редакцын шинжтэй 2 санал хураалт явуулъя.

Нэг.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 39.1 дэх хэсгийн “зөвшөөрөлд үндэслэн” гэсний дараа “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг “төрийн захиргааны төв” гэсний дараа “байгууллага, хуульд заасан тохиолдолд түншлэлийн гэрээ байгуулсан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж. Санал хураалт. Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Найруулгын шинжтэй саналууд. Төслийн 2 дугаар зүйлийн “мөн хэсгийн “гаргаж” гэсний өмнө “ , хуульд заасан тохиолдолд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт 61,1 хувийн саналаар санал хураалт явуулъя.

Дараагийн хуулийн төсөл.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Дараагийн хуулийн төсөл.

3.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн нэрээ өгье. Асуулт алга. Санал ирсэн байна.

Саналын томъёолол.

“1 дүгээр зүйл.2.34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

34.5.Төр,хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15.4-д заасан эрчим хүчний төсөлд санхүүгийн үр ашигтай байх, мөн төслийн ирээдүйн мөнгөн урсгалаар баталгаа гаргуулж байгаа зээл үнэт цаасыг эргэн төлөх чадвартай тохиолдолд энэ хуулийн 34.2.1-д заасан шаардлага хамаарахгүй бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх болон Засгийн газрын өрийн баталгаа гаргах цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн чадлыг дотоодын нийт хэрэглээний 40 хувиас илүүгүй байх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн.

Бадамсүрэн гишүүн саналаа тайлбарлая.

М.Бадамсүрэн: Баярлалаа. Түрүүн нөгөө Эрчим хүчний тухай хууль дээр дэмжигдсэн саналтай энэ яг уялдана. Тэгээд бид нарын нөгөө болгоомжлоод байгаа зүйл дээр л энэ маань үндсэндээ дээд тааз болж өгөх юм. Тэгэхээр энэ бол хамгийн чухал ийм заалт байгаа шүү. Дахин дахин тайлбарлаад яах вэ, гишүүд маань ойлгож байгаа учраас тэгээд замбараагүй байдал үүсгэхгүй, өрийн баталгааг хамаагүй гаргахгүй, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг дураараа байгуулахгүй энэ таазыг л тогтоож өгч байгаагаараа л ач холбогдолтой. Түүнээс бусдаар бол эрчим хүчний шинэчлэлийг бол дэмжих ийм агуулгатай заалт байгаа юм. Тэгээд та бүхнийгээ дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгийн гаргасан зарчмын дүр зөрөөтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Түрүүн Энхцэцэг гишүүний гаргасан 1 санал орхигдсон байна. Санал хураалт явуулъя.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлтийн санал.

“2 дугаар зүйл.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хувийн хэвшлийн” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “гэрээний талууд нь” гэсний дараа, мөн зүйлийн 33.3 дахь хэсгийн “түншлэгч талыг төлөөлж” гэсний дараа, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “түншлэлийн асуудал эрхэлсэн” гэсний өмнө 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “зөвшөөрөлд үндэслэн” гэсний дараа гэж, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “21.7” гэсний дараа “21.11” гэж, мөн хэсгийн “гаргаж” гэсний өмнө гэж тус тус нэмснийг хасах” саналтай байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг. Энхцэцэг гишүүн саналаа тайлбарлах уу.

Ер нь энэ саяын уншсанаас энэ дарсан 2 мөрийг л хасах саналтай байгаа юм. хуульд өөрөөр заагаагүй бол гэснийг, мөн хуульд заасан тохиолдолд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэсэн энэ 2 мөрийг хасах санал гаргасан байна. Найруулгын санал бол түрүүн дэмжигдсэн байгаа. Энхцэцэг гишүүн энийг хураалгах уу. Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 33,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хороо санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн унших вэ. Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн танилцуулна.

15.58 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 2.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Г.Лувсанжамц: Эдийн засгийн байнгын хорооны дарга, Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн 2025 оны 5 сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 8 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн миний бие болон гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Р.Батболд, О.Батнайрамдал, Ч.Лодойсамбуу, П.Сайнзориг, А.Ундраа нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр хуралдсан бөгөөд хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг дэмжиж, анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй хамтатган явуулах горимын санал гарган хураалгах нь зүйтэй гэж үзсэн болно.

Хууль санаачлагч албан бичиг ирүүлсэн тул Хот байгуулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд /шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж, уг хуулийн төслийг буцаан татсанд тооцсон болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 35.5-д энэ хуулийн 31.1, 31.2, 31.4-д заасан этгээд хуулийн төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатанд оролцох үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулна гэж заасан. Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан хууль санаачлагч өөрийн биеэр Байнгын хороонд мэдэгдсэн. Ингээд хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзэж байгаа учраас хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төсөл тус бүрийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Мөн зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

Нэг.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгье. Санал гаргасан гишүүн алга байна. Асуулт асуусан гишүүн алга байна. Ажлын хэсгийн гаргасан горимын саналын дагуу анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтээ нэгтгэн явуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье.

Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц танилцуулна.

16.03 цаг.

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцэх асуудал 3.

Нийтийн өмчийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

Засгийн газрын хуралдаантай байгаа учраас сайдыг иртэл дараагийн асуудал руугаа орж байя. Сайдыг иртэл дараагийн асуудлыг хэлэлцэж байя.

Дараагийн асуудлыг хэлэлцэж байя. Хэлэлцэх асуудал 4.

“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболдыг ажлын хэсгээс дахин боловсруулсан тогтоолын төслөө танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Эдийн засгийн байнгын хорооныхоо гишүүдийн өнөөдрийн амрыг эрье.

Өнгөрсөн 7 хоногт Улсын Их Хурлын хэлэлцүүлсэн “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл дээр Монголбанкны

хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээтэй холбоотой зарим нэгэн заалтууд шаардлага хангахгүй байна гэдэг асуудал яригдсан. Энэ асуудлаар ажлын хэсгээс Монголбанкны зохих удирдлагуудтай уулзаж, төслийг дахин хэлэлцээд тодорхой саналуудыг, саналын өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнийгээ уншиж танилцуулъя гэж бодож байна.

Ингээд “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Зээлийн хүүг бууруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанканд даалгасугай.

1/банкны системийн тухайн хугацааны дундаж хүүгээс өндөр хүүтэй, хугацаатай хадгаламж нь банкнуудын эх үүсвэрийн өртөг зээлийн хүүг тогтооход хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийж, саналаа танилцуулах;

2/банкнаас эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүгийн мэдээллийг ил тод нээлттэй зарладаг болох зохицуулалтыг холбогдох журамд тусгах;

3/Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд гадаадын банкны салбар байгуулах, үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шалгуурыг шинэчлэх, боловсронгуй болгох;

2.Зээлийн хүүг бууруулж, банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороонд даалгасугай.

1/банк болон банк бус санхүүгийн байгууллага хөрөнгийн зах зээлээр дамжуулан эх үүсвэр татахад дэд бүтцийн байгууллагатай холбогдох зардал, хугацааг бууруулах;

2/банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг тогтоохтой холбоотой шаардлага, шалгуурыг төв болон орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн ялгамжтай тогтоох;

3.Зээлийн хүүгийн дээд хязгаарыг бизнесийн хэрэглээний болон бусад зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр төрөлжүүлэн судалж, санал боловсруулан танилцуулахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд, банк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг үл хөдлөх эд хөрөнгийн барьцаанд тулгуурлан тооцох журмыг зээлжих чадварын зэрэглэлтэй уялдуулан боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж танилцуулахыг, энэ тогтоолын биелэлтийн явцыг 2025 оны 12 дугаар сард багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудлаар хэлсэн Засгийн газрын гишүүнд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл боловсруулаад байна.

Р.Сэддорж: Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Мандхай гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Мандхай.

М.Мандхай: Соронзонболд гишүүнээс энэ эх үүсвэрийн өртгийг бууруулах зорилгоор банкны системийн тухайн хугацааны дундаж хүүгээс өндөр хүүтэй татсан хугацаатай хадгаламжийн заавал байлгах нөөцийн хэмжээг өсгөх, зохистой харьцааг тогтоох асуудлыг судлан шаардлагатай зохицуулалт хийх гэдгийг хассан байгаад байгаа юм. Энэ дээр ийм эрсдэл харагдаад байгаа. Нөгөө жижиг банкнуудад илүү нөлөө үзүүлэх ийм заалт байна л даа. Жишээлбэл жижиг банкнуудын хувьд эх үүсвэр өөрөө татах өндөр зардалтай байдаг. Тэгээд ер нь илүү голцуу эх үүсвэрээ татахын тулд том банкнуудтай харьцуулахад илүү өндөр хүү тавьж, амладаг. Тэгэхээр энэ зохицуулалтыг хийснээр жижиг банкнууд эх үүсвэр татахад хүндрэл учрах уу гэдэг асуултыг асууя гэж бодож байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Дараа нь Соронзонболд гишүүн үг хэлнэ.

Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Энхтайван Монголбанкны Дэд Ерөнхийлөгч, Мөнх-Ундарга Монголбанкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал. Итгэлсүрэн.

М.Мандхай: Уучлаарай. Би нөгөө 2 дахь асуултаа асууж дуусаагүй байгаа шүү. Минут яваад байдаг.

Арилжааны банкнууд дундаж хүү яг хэдтэй байгаа вэ. Ажиглаад байхад банкнууд өндөр хадгаламжийн хүү амлах байдлаар хоорондоо өрсөлддөг. Тэгэхээр энэ хөрөнгийн зах зээл дээр гарч байгаа бондын хүү бараг 20 хувьд хүрээд байгаа. Тэгэхээр энэ өндөр хадгаламжийн хүү давсан зээл олголтын орлоготой байж л мэдээж банкнууд болон бусад санхүүгийн байгууллага ашигтай ажилладаг. Тэгэхээр энэ банкнууд дээр эх үүсвэрийн зардлыг ийм байдлаар их нэмэгдүүлж байгаа. Тэгэхээр энэ байдлыг зохицуулах боломж ер нь Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд ер нь байгаа юу. Ямар ийм арга хэмжээг авч хэрэгжүүлэх вэ гэдэг 2 асуулт.

Р.Сэддорж: Үргэлжлүүлж танилцуулъя. Итгэлсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Банк, санхүүгийн байгууллагын газрын дарга, Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Соронзонболд гишүүний асуултад хариулна.

Л.Соронзонболд: Мандхай гишүүний асуултад хариулъя. Сая Мандхай гишүүний асууж байгаа нь болохоор бол тогтоолын төслийн өмнөх хувилбарын тухай яригдаж байна гэж ойлголоо. Яагаад гэвэл одоогийн энэ танилцуулж байгаа тогтоолын төсөл дээр бол бид заавал байлгах нөөцтэй холбоотой хэсгийг бол хассан байгаа. Учир нь юу вэ гэвэл Монголбанкнаас бас Төв банкны тухай хуулиараа мөнгөний бодлогын шийдвэр гаргахад ялангуяа мөнгөний бодлогын хэрэгсэл нь заавал байлгах нөөц ордог. Тийм учраас болохоор Монголбанкны өөрийнх нь бие даасан байдал, мөнгөний бодлогоор бие дааж шийдвэр гаргахтай

холбоотой заалт учраас заавал байлгах нөөцтэй хэсгийг тогтоолын төслөөс хасаж өгөөч гэдэг ийм хүсэлт тавигдсан. Үүнийг ажлын хэсэг дээр ярилцаад, хассан.

Эрсдэлийн хувьд болохоор ер нь бол жижиг банкнууд бол арилжааны бусад системийн томоохон банкнуудыгаа бодох юм бол арай өндөр хүү зарладаг ийм асуудал бол байгаа. Гэхдээ нөгөө талдаа бас яг олон нийтэд зарласан хадгаламжийн хүүгээсээ өндрөөр гэрээ тохирч, хадгаламж авдаг асуудал бол арилжааны банкны системд бол нийтлэг байгаа юм. Ялангуяа зах зээлд их хувьтай банканд хэрвээ тийм байдлаар хүү тогтоочихоор нөгөө банкнууд нь шууд тэр хүүг бол зах зээлийн хүү гээд аваад байгаа ийм асуудал байгаа учраас энэ дээр ер нь цаашдаа Монголбанк анхаарч ажиллах ёстой гэдэг утгаар нь бид нар бол энэ эхний төсөл дээр оруулсан байсан. Энэ дээр бол цаашдаа Монголбанк өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд шийдвэр гаргахдаа заавал байлгах нөөц дээрээ тодорхой хэмжээний шийдвэрээ гаргаад явах боломжтой гэж үзэж байгаа учраас ажлын хэсгээс тэр саналыг авсан байгаа.

Мөн бизнесийн зээл дээр бас ашиглагдаж байгаа эх үүсвэрийн заавал байлгах нөөц дээр ялгаатай тогтоох боломжийг судлах тухай бол байсан. Өмнөх тогтоол дээр. өн энэ заалтыг бол хассан байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь болохоор энэ гадаад валютаар эх үүсвэр татаад, тэрийгээ Монголбанканд төгрөг болгож хөрвүүлэхтэй холбоотой зардлыг бууруулах талын заалт байсан. Энэ болохоор нөгөө талдаа Монголбанкны өөрийнх нь үндсэн үйл ажиллагаанд нэлээн хүндрэл учруулах ийм заалт байгаа учраас энэ дээр бас харж үзэх нь зүйтэй гэж ажлын хэсгээс үзээд тус тус хассан байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Монголбанкнаас хариулъя. 4 номер.

Г.Энхтайван: Мандхай гишүүний асуултад хариулъя. Төгрөгийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хүү бол 17,5 хувьтай, гадаад валютын жигнэсэн дундаж хүү бол 11,3 хувьтай байна. Сектороор нь хариулах юм бол иргэдийн зээлийн хувьд бол 17,9 хувьтай, гадаад валютынх нь 13,7 хувьтай байна. Тэгээд нийт төгрөгийн энгийн зээл бол дундаж хугацаанд мажорити нь бол 2 жилийн хугацаатай эргэн төлөгдөж дуусаж байгаа. Тэгээд гадаад зах зээл дээр бондын хүү бол зээлийн дундаж хүүгээс өндөр байгаа. Энэ нь эргээд зээлийн хүүд нөлөөлж байгаа талаар бол гишүүн хөндөж байна. Мэдээж ОТС маркет дээр гарч байгаа бондын хүү бол хадгаламжийн хүүгээс ч тэр, зээлийн дундаж хүүгээс ч өндөр 20 гаруй хувьтай бас гараад байгаа. Энэ нь бол юуг илтгэж байгаа вэ гэхээр эх үүсвэрийн дутагдалтай байгааг л илтгэж байгаа.

Р.Сэддорж: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Тэгэхээр нөгөө бондын хүү өөрөө өндөр байгаа. Тэгээд яах вэ, ойлгож байна. Эх үүсвэр өөрөө бага учраас яг иргэдийн хүү өөрөө бондын хүүтэй харьцуулахад бол бага байна. Тэгэхдээ ер нь бид нар хадгаламжийн хүү, ер нь хүүг бууруулах тохиолдол ярьж байгаа үед банк дээрх эх үүсвэрийн зардлыг яг ийм байдлаар бол угаасаа хадгаламжийн хүүг нэмэгдүүлэх байдлаар ингээд явна. Тэгэхээр энийг зохицуулах тал дээр Монголбанкны зүгээс Санхүүгийн зохицуулах хорооноос ирээгүй байх шиг байна. Монголбанкны зүгээс болон Санхүүгийн зохицуулах хороонд зохицуулах ямар боломжууд байгаа вэ. Ер нь цаашдаа бас яг энэ асуудал ийм эрсдэлүүд үүсэхээр ямар арга хэмжээ авах вэ гэдэг асуулт асууя.

Р.Сэддорж: Хаанаас хариулах вэ. 4 номер өөрийгөө танилцуулаад.

Г.Энхтайван: Ер нь бол гишүүний хөндөж байгаа асуудлыг бол бид хэд ойлгож байна. Яг энэ дээр бол төв банкны зүгээс ямар бодлогын арга хэмжээ авах вэ гэхээр бондын хүү илүүтэйгээр өндөр байгаа шалтгаан нь инфляцтай л 100 хувь холбоотой байгаад байгаа. Тэгэхээр инфляцыг нам доор түвшинд тогтворжуулсны хүрээнд бол энэ эх үүсвэрийн зардал бол тодорхой хэмжээгээр буурах боломжтой. Яг богино хугацаандаа шууд механик аргаар бондын зах зээл дээр арилжаалж байгаа мөнгөн бонд гаргаж байгаа хэлцлүүдийг шууд хүчээр, механикаар хүүг нь бууруулах бол учир дутагдалтай. Хэрвээ ингэх юм бол далд эдийн засаг, зохицуулалтгүй зээлүүд цэцэглэх учраас төв банк бол энэ дээр бас болгоомжтой хандаж байгаа.

Банк бусууд бол энэ дээр ямар арга хэмжээ авч байгаа талаар бол Санхүүгийн зохицуулах хороо дэлгэрэнгүй хариулах байх.

Р.Сэддорж: Санхүүг зохицуулаарай хэдэн номер вэ. 1 номер.

Б.Дөлгөөн: Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Дөлгөөн. Мандхай гишүүний асуултад хариулъя. Одоо яг хөрөнгийн зах зээл дээр бол мэдээж бондын өгөөж нэлээдгүй хүү өндөртэй байгаа. 18-20 хувийн хооронд хэлбэлзэж байгаа. Мөн түүнээс ч өндөр гарах нь бол сүүлийн үед бол ажиглагдсан. Энэ агуулгын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс ялангуяа үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах, цаг хугацаа болон зардлыг бууруулах хүрээнд бол тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байгаа. Нэн ялангуяа Топ-100 аж ахуйн нэгжүүдийг бас хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргахад шаардлагатай санхүүжилтийн зардлыг бууруулахаар ажиллаж байгаа. Мөн энэхүү бас Их Хурлын тогтоолын төсөл дээр бас дурдсаны дагуу хөрөнгийн зах зээлээр дамжуулан эх үүсвэр татахад гарч байгаа дэд бүтцийн байгууллагатай холбоотой зардлуудыг бууруулах ийм чиглэл өгчихсөн. Үүний хүрээнд ажиллана гэж харж байгаа. Ялангуяа ер нь аж ахуйн нэгж санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд бондын зардал бол 1-3 хувьтай ерөнхийдөө босож байдаг ../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. 1 номер.

Б.Дөлгөөн: Бондын хувьд бол яг зах зээл дээр татан төвлөрүүлэх зардал бол 1-3 хувьтай ер нь байгаа. Эцсийн дүндээ. Үүнийг бол бид бүхэн тодорхой хэмжээнд шаардлагатай цаг хугацааны болон бусад нэмэлт санхүүжилтийн зардлыг бууруулах замаар буурах боломжтой буюу компаниудын хувьд бол санхүүжилт татан төвлөрүүлэх зардлыг бууруулах боломжтой гэж харж байгаа. Нөгөө талдаа дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл хураамжийг бууруулснаараа зах зээлд оролцогч оролцогчийн тоо нэмэгдүүлэх буюу өөрөөр хэлбэл энэ санхүүжилтийн бас өртөгт нөлөөлөх ийм бүрэн боломжтойг гэж харж байгаа. Энэ хүрээндээ бас дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг шаардлагатай хэмжээгээр өөрчлөх, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаанд бас тодорхой хэмжээнд бас үр дүнгээ үзүүлнэ гэж харж байгаа. Тэгэхээр энэ тоог бол бид бүхэн бас бууруулах бүрэн боломжтой гэж.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байна уу. Ажлын хэсгээс. Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Мандхай гишүүн. Лхагвасүрэн ерөнхийлөгч 3 номер.

Б.Лхагвасүрэн: Мандхай гишүүний асуултад нэмж хариулъя. Тэгэхээр өнөөдөр манай хувийн сектор олон улсын захаас хөрөнгө мөнгө босгоход бол бас 2

оронтой тоогоор явж байгаа. Хамгийн сүүлд Хөгжлийн банк сая хамгийн сүүлд босгосон бонд 9 хувийн хүүтэй. Тэгэхээр доллароор орж ирээд, эргээд төгрөгтэй своп хэлэлцээрт хөрвүүлэхэд Монголбанкны төгрөгийн хүү 12 хувь бодлогын хүү, тэгэхээр зөрөөд 8 хувийн зөрүү хүү гарч ирж байгаа юм. Тэгэхээр угаасаа 9 хувиар авчирсан юун дээр дахиад 8 хувийн зөрүү гээд бодохоор ингээд бүр 17, 18. Саяын ярьж байгаа дотоодын бондын 20 хувь руу бас адилхан очоод ирчхэж байгаа юм. Тэгэхээр нэгэнт ийм нөхцөлд зээлийн хүүг бууруулах, эх үүсвэрийн хүүг бууруулах гол юу нь инфляц доошоо орж байж, бодлогын хүү доошоо явж байж л орон зай нь бий болох юм. Тэгэхээр ер нь бол 2027 онд инфляцыг 5 хувьд явуулахаар өнөөдөр явуулж байгаа Монголбанкны мөнгөний хатуу бодлогоор/минут дуусав/

Р.Сэддорж: Мандхай гишүүн хариулт хангалтгүй гэж үзэж, тодруулж асууя.

М.Мандхай: Яах вэ би бол ингэж хараад байгаа байхгүй юу. Төсөв хэлэлцэж байх үед манайх чинь орлогоо их өөдрөг төсөөлж тавьсан. Одоо оны эцсээр бас нүүрсний борлуулалт илүү буурах ийм эрсдэл үүсэж байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт санхүүгийн байгууллагын хувьд бас яг та өөрөө хэллээ шүү дээ. Гадаад эх үүсвэрээс голцуу эх үүсвэрээ татдаг. Үүнээс болоод нөгөө ханшийн эрсдэл үүрэх магадлалтай. Тэгээд энэ ханшийн зөрүүнээс болоод өндөр хүүтэй эх үүсвэр татахаар чинь эсрэгээрээ бид нар зээлийн хүүг бууруулж чадахгүй юм биш үү. Энэ ер нь яг одоо нөхцөл байдалд хэр бодитой юм бэ гэдгийг би асуумаар байгаа байхгүй юу. Тэгээд инфляцыг хүчээр барих нь бас ямар эрсдэлтэй юм эдийн засагт. Гэтэл яг одоо оны сүүлээр бид нар орлого буурна гэж ярьж байгаа. Гэтэл Монголбанк хүчээр хатуу бодлого баримтлаад байдаг. Яг бодитой эх үүсвэрийг бууруулъя гээд зардлаа бууруул гэхээр гадаадын эх үүсвэрээс ихэнх нь банкнууд, санхүүгийн байгууллагууд мөнгө татаж байгаа. Ханшийн эрсдэл үүсээд байдаг.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн ахлагч хариулах уу. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Ерөнхий бол Монголбанкны Ерөнхийлөгч хариулбал зүгээр байх. Тэгэхдээ би хариулъя. Ер нь бол экспортын орлого багасаад ирэхээр чинь манай орж ирж байгаа гадаад валютын урсгал маань багасаж байна гэсэн үг. Тэгэхээр яг энэ гадаад валютын урсгал маань багасахаар ханш дээрээ бол нэлээн дарамт өгнө. Энэ ханшийн дарамтыг төгрөгийн ханшийг сулруулахгүй нь хэрвээ Монголбанк интервенц хийгээд, ханшаа бариад байвал бас бид нар гадаад валютын албан нөөцөө бууруулна. Ийм сул талтай учраас ер нь бол Монголбанк мөнгөний хатуу бодлого баримталж байгаа нь бол зөв гэж би харж байгаа.

Зээлийн хүүг буур бууруулах ерөнхий суурь нөхцөл маань бол ер нь бол бид нар энэ эдийн засгаа солонгоруулахтай холбоотой асуудал байгаад байгаа шүү дээ. Өнөөдөр Монгол Улс маань хэтэрхий уул уурхайн салбараас хамаарсан байгаад байна. Уул уурхайн салбарын циклийг дагаад, манай эдийн засаг өөрөө унаад байгаа нь бол сул тал байна. Бид нар уул уурхайн салбарын экспорт өндөр үед нь гадаад валютын албан нөөцөө сайн хуримтлуулж чаддаг, төсвийнхөө сахилга батыг барьж чаддаг болсон тохиолдолд ер нь зээлийн хүү буурах суурь нөхцөл маань бол бүрдэнэ.

Р.Сэддорж: Монголбанкнаас 4 номер.

Г.Энхтайван: Мандхай гишүүний асуултад тодруулъя. Ер нь бол яг өнөөдрийн нөхцөл байдалд зээлийн хүү бууруулна гэдэг энэ тогтоол баталж байна. Өнөөдөр

буурчих юм шиг хүлээлт үүсгээд байгаа. Энэ бол яг тийм бол биш. Хүү бол өнөөдрийн түвшинд яг одоо байгаа эдийн засгийн нөхцөл байдлын хувьд бол хүү буурахад бол орон зай байхгүй. Түрүүн та хэллээ. Инфляцыг бас нам доор түвшинд хүчээр барих, хадгаламжийн хүүг бас хүчээр бууруулах нь бол маш эрсдэлтэй. Хэрвээ бид бүхэн хадгаламжийн хүүг хүчээр доор түвшинд барих юм бол бодлогын хүүг барих юм бол нөгөө талдаа инфляц шууд явна. Нөгөө талдаа бас иргэдийн монгол төгрөгт итгэх итгэл байхгүй болоод, бүх хүн америк доллар луу явах буюу зах зээл дээр долларжилт гэдэг үзэгдэл маш эрчтэй явна. Долларжилт эрчтэй яваад, төгрөгөөс өгөөж авахгүй бол бүх хүн доллар худалдаад авна шүү дээ. Долларын хүү тэртээ тэргүй өгөөж нь өндөр байгаа үед. Тэгээд гарах урсгал нэмэгдэнэ. Үүний хүрээнд. Тэгээд эдийн засаг маш эмзэг болно. Тэгэхээр бид бүхний хамгийн гол баримталж байгаа бодлого бол төгрөгийн худалдан авах чадварыг буюу инфляцтай тэмцэх гол үндсэн арга механизмаараа хамгаалах ийм л зорилготой байгаад байгаа юм. Тэгэхээр яг өнөөдрийн нөхцөл байдалд бол яг бодлогын хүү бууруулах орон зай, эх үүсвэрийн зардлыг бууруулах орон зай ерөөсөө харагдахгүй байгаа.

Гэхдээ бид бүхэн энэ зээлийн хүү бууруулах тогтоолыг дунд хугацааных гэж үзэж байгаа. Дунд хугацаандаа бид бүхэн энд хүрнэ гэж зорьж байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлахыг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа анхааралтай оролцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэгт заасныг үндэслэн “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулна.

16.33 цаг.

3 дугаар асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 3.

Нийтийн өмчийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан, төрийн нийтийн өмч байх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх эрхтэй гэж зарчмыг хуульчлан баталгаажуулсан. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.2-т төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчил гэж заасан.

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдуулан 1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг анх баталсан бөгөөд уг хууль нь шилжилтийн үеийн төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоон өмч хувьчлалыг зохицуулахад чиглэсэн байдаг.

Уг хууль батлагдсанаас хойш хуулийн нийт зүйлийн 80 орчим хувьд 39 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд дийлэнх нь хуулийн гол зохицуулалттай холбоотой тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд бус харин салбарын бусад хууль шинэчлэгдсэн тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Ийнхүү Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалтын хийдэлтэй болон эрх зүйн шинэчлэлээс хоцорсон, хуульд цаг үеийн шинжтэй бусад салбарын хуулийн өргөтгөлтэй уялдуулсан нэмэлт, өөрчлөлтийг удаа дараа оруулсан зэрэг нь хуулийн зохицуулалтын нэгдмэл цогц байдлыг алдагдуулахад хүргэсэн.

Иймд эрх зүйн шинэчлэл бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд нийтийн өмч түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах, төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, хэлбэрийг зохистой тогтоож, өмчийн удирдлага, бүртгэл, ашиглалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулсан.

Хуулийн нэрийг Иргэний хуульд заасан өмчийн төрөлд нийцүүлэн өргөжүүлж, нийтийн өмчийн суурь харилцааг зохицуулах хүрээнд нийтийн өмчийн хууль гэж өөрчилж, төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тус хуулиар, харин олон нийтийн болон шашны өмчийн харилцааг уг хуульд нийцүүлэн тухайлсан хуулиар зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

Хуулийн төсөл нь 9 бүлэг 81 зүйлтэй бөгөөд дараах зарчмын өөрчлөлтийг тусгалаа.

1.Нийтийн өмч түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт, хяналтын нэгдмэл байдлыг хангах зорилгоор хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ хуулийн үйлчлэл хамаарахгүй боловч тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулах харилцааг бусад хууль тогтоомж болон эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан тодорхойлсон. Төрийн болон орон нутгийн өмчит

компанийн өмчийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудлыг төрийн болон орон нутгийн өмчийн бие даасан хуулиар зохицуулахаар тусгасан.

2.Хуулийн нэр томъёог Монгол Улсын Үндсэн хууль болон иргэний хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд баримтлах зарчимд өмчийн удирдлага нэгдмэл байх, өмчийн удирдлагыг хуулиар тогтоосон хязгаарлалтын хүрээнд хэрэгжүүлэх, тооцоо судалгаанд үндэслэсэн, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх зэрэг тусгай зарчмыг шинээр тусгасан.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн өмчийн өмчлөгч нь Монгол Улсын Их Хурал, орон нутгийн өмчийн өмчлөгч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх зарчим хэвээр хадгалж өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдүүдийн эрх хэмжээний давхцал, ойлгомжгүй байдлыг арилгаж, харилцан уялдаатай байхаар тусгасан. Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмших этгээдийн эрх зүйн байдлыг хөрөнгийн эрхийн байдалтай нь уялдуулан оновчилж тогтоосон.

4.Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн газрын хяналт чиг үүргийг тодруулан хуульчилж, Төрийн өмчийн хорооны бүрэлдэхүүнд хөрөнгийн удирдлага, хөрөнгийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн иргэнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилж, ажиллуулах боломжийг бүрдүүлээ.

5.Төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгө олж авах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх асуудлыг үр ашигтай, нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлэх журам, аргыг нарийвчлан тусгасан. Энэ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор өмчийг ашиглуулах, шилжүүлэх үндэслэл, зорилго, гэрээний нөхцөл, талуудын хүлээх эрх, үүргийг тодорхой хуульчилж, өмчийг бусдын өмчид шилжүүлсний дараа хэрэгжүүлэх хяналтын зохицуулалтыг шинээр тусгасан.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо, түүний бүрдэл хэсгийг тодорхойлж хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан. Төрийн өмчийн нэгдсэн бүртгэл, тооллого, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн дагнасан бүртгэлийг хийх, хөрөнгийн өөрчлөх хөдөлгөөн, хөрөнгө эзэмшигчийн мэдээллийг нээлттэй байлгах зохицуулалтуудыг бий болгосон.

7.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалтын хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, өмчлөгч болон төрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан зохицуулж Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн газраас хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэслэл журмыг тодорхойлсон.

8.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого, үнэлгээ, өмчийн хөдөлгөөн, тайлан, хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн цахим систем мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, эрхлэн хөтлөх, хөгжүүлэх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг тодорхой хуульчилсан.

Хууль батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, хөрөнгийн ангилал, өмчлөх эрх болон өмчийн удирдлага хэрэгжүүлэх субъектийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндэслэл, журам тодорхой болж, төрийн болон орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашиг, үнэлгээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль хоорондын хийдэл, зөрчил арилж, төрийн нийтийн өмчид хамаарах газар, байгалийн баялаг болон бусад өмч хөрөнгийн удирдлагын нэгдмэл тогтолцоо хангагдаж, Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитой хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой шийдвэр хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ, түргэн шуурхай хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үнэлэх, бүртгэх, бусдад ашиглуулах, шилжүүлэх үйл ажиллагаа нийтийн эрх ашигт нийцсэн, үр ашигтай байх хууль зүйн үндэслэл бүрдэнэ.

Өөрөөр хэлбэл төрийн болон орон нутгийн өмчийн үр ашигтай байдлыг дээшлүүлж, хөрөнгийг бүрэн бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулснаар төрийн өмч нэрийн доор хэн нэгэн эрх мэдэлтэн, албан тушаалтан хувьдаа шамшигдуулах, хууль бус үйлдэл гаргахаас сэргийлэх улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан түүнчлэн хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалт, шилжилтийн үеийн бэлтгэл хангах, мөн хуульд заасан зарим нэр томъёог жигдлэх, зохицуулах, хоорондын уялдааг сайжруулах зорилгоор хуулийн төслийг дагалдуулан 41 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Р.Сэддорж: Хуулийн төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлтийг Тамгын газрын Хуулийн газрын дарга Дондогмаа танилцуулна. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ч.Дондогмаа: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн хуулийн төсөл болон дагалдах хууль, бусад хууль тогтоомжийн төслийн талаар Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн хууль зүйн дүн шинжилгээ хийж хууль зүйн дүгнэлт гаргасныг танилцуулж байна.

1.Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцсэн эсэх, хуулийн төслийн тодорхой зүйл хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдсөн эсэх, тухайн хуулийн төсөл, түүний зарим зүйл, хэсэг, заалтын зохицуулалтын хэрэгжих боломж харилцан уялдааны талаар.

1.1.Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон

хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох гэж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.2 дахь хэсэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ гэж тус тус заасан. Харин төслийн 4.1.3-д орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч гэж Засаг дарга, түүнээс эрх шилжүүлэн авсан орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрыг гэж, 17.2 дахь хэсэгт Засаг дарга нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх гэж тус тус тусгасан ба төслийн 18 дугаар зүйлд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах зарим эрхээ Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэхээр зохицуулсныг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дээрх зохицуулалтад нийцүүлж, эдгээр шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд гаргахаар өөрчлөн найруулах шаардлагатай байна.

Түүнчлэн төслийн 4.1.1-д бусдад ашиглуулах гэж Иргэний хууль, бусад хуульд заасан эд хөрөнгө хөлслөх, түрээслэх, эд хөрөнгийг үнэ төлбөргүй болон бусад гэрээ эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр төрийн болон орон нутгийн өмчийг бусдын эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг гэж, 4.1.2-т бусдад шилжүүлэх гэж Иргэний хууль, бусад хуульд заасан худалдах, худалдан авах, солилцох, бэлэглэх болон бусад гэрээний үндсэн дээр төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэж зааснаас үзэхэд бусдад шилжүүлэх гэсэн ойлголтод төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөх эрхийг шилжүүлэх асуудал хамаарч байна. Төслийн 17.1 дэх хэсэгт зааснаар орон нутгийн өмчлөгч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэдий ч өмчлөгчийн зөвшөөрлийг үндэслэхгүйгээр тухайн өмчийг шилжүүлэх, барьцаалуулах, тодорхой асуудлаар Засаг дарга бие даан шийдвэр гаргахаар төслийн 18.1-д заажээ. Орон нутгийн өмч нь тухайн орон нутгийн иргэдийн өмч тул орон нутгийн өмчийг шилжүүлэх, барьцаалах тохиолдолд тухайн орон нутгийн иргэдээс мандат авч байгуулагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зөвшөөрөл авах нь дээр дурдсан хуульд нийцэхээр байна.

1.2 Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан, төрийн нийтийн өмч байна гэж заасан бөгөөд төслийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал Монгол Улсын ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байна. Тодруулбал, Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газрыг Монгол Улсын иргэдээс өөр этгээдэд өмчлүүлэх боломжгүй. Харин төслийн 12.3.4-д төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргахаар заасныг тодруулан тусгах шаардлагатай байна.

1.3.Иргэний хуулийн 7.3 дахь хэсэгт төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, нийслэл, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно гэсэн бөгөөд тус хуулийн 104.1 дэх хэсэгт эзэнгүй эд юмсыг илээр, шударгаар, шударга аргаар олж авснаас хойш өөрийн өмчлөгчийн зүйлийн адил 5 жил тасралтгүй илээр эзэмшсэн этгээд тухайн эд хөрөнгийн өмчлөх эрхийг олж авна гэж, 115.1 дэх хэсэгт өмчлөгчгүй эсхүл өмчлөгч ь өмчлөх эрхээ дуусгавар болгох зорилгоор эзэмшлээсээ татгалзсан эд хөрөнгийг эзэнгүй эд юмс гэж үзнэ гэж тус тус заасан. Төсөлд төрийн өмчит хөрөнгө олж авах үндэслэлд 21.1.6

эзэнгүй болон дарагдмал үнэт зүйл гэсэн ба энэхүү үндэслэлээр эд хөрөнгө олж авах нөхцөл хуулиар тодорхой болгож холбогдох хуульд заасны дагуу гэснийг тодотгохыг зөвлөж байна.

Мөн Иргэний хуульд эзэнгүй эд юмс дарагдмал үнэт зүйл гэсэн ойлголтыг хэрэглэсэн ба эзэнгүй үнэт зүйл гэсэн ойлголт байхгүйг анхаарч, нэр томьёог ойлгомжтой болгох шаардлагатай.

1.4. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3.1.4-д эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл гэж өмчийн хэлбэр, өмчлөгчийн иргэний харьяалал харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийн эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагаа гэж, мөн хуулийн 4.1-д улсын бүртгэлийн үйл ажиллагаа нь дараах зарчмыг баримтална гээд 4.1.1-д нэгдмэл тогтолцоотой, арга зүйтэй байх, 4.1.2-т төвлөрсөн удирдлагатай байх гэж заасан. Мөн хуулийн 5.1-д бүртгэлийг улсын бүртгэл, төрөлжсөн бүртгэл гэж ангилна. 5.2 дахь хэсэгт улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо нь иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс бүрдэнэ. 5.3 дахь хэсэгт энэ хуулийн 5.2-т зааснаас бусад хуульд заасан бүртгэл нь төрөлжсөн бүртгэлд хамаарах бөгөөд төрөлжсөн бүртгэлийн жагсаалтыг Засгийн газар батална гэж заасан. Төслийн 59.1 дэх хэсэгт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг нэгдсэн болон дагнасан бүртгэл гэж ангилна гэж заасан. Энэхүү ангилал нь улсын бүртгэлийн улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дээрх зохицуулалттай зөрүүтэй байгааг анхаарах шаардлагатай байна.

1.5 дахь хэсэг төсөлд хууль зүйн техникийн шинжтэй дараах зүйлүүдийг анхаарах нь зүйтэй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1-д зааснаар хуулийн төслийн агуулгад Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцсэн байх шаардлага тавигдах ба энэхүү зохицуулалт ёсоор хуулийн төслийг боловсруулахдаа одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд нийцүүлэх шаардлагатай. Харин төслийн 15.6, 20.5 дахь хэсэгт Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийг гэж эцэслэн батлагдаагүй Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад байгаа нь төслийн нэр заан тусгажээ. Цаашид нийтийн өмчийн хуулийг хэлэлцэн батлах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг хамтад нь хэлэлцэх эсхүл хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нийцүүлэх шаардлагатай. Төслийн 8.4, 25.6 дахь хэсэг болон төслийн бусад зүйл, хэсэг заалтад дурдсан, хориглосон, үүрэг болгосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.2-т заасны дагуу холбогдох хуульд тодорхой тусгасан эсэхийг хэлэлцүүлгийн шатад нягтлахыг зөвлөж байна. Тодруулбал, төслийн 80.20 дахь хэсэгт энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэжээ. Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хууль, захиргааны хэмжээний актыг зөрчсөн энэ хуульд шийтгэл ногдуулахаар заасан үйлдэл эс үйлдэхгүйг зөрчил гэсэн ба нийтийн өмчийн хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх зөрчлийг холбогдох хуулийн төслүүдэд тусгаагүй байна.

Төслийн 13.1 дэх хэсэг 13.4.7, 13.4.8 дахь заалтад төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж гэснийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1.2-т заасан нэг нэр томьёог өөр өөр ойлголтоор илэрхийлэхгүй байх шаардлагын дагуу Нийтийн өмчийн хууль тогтоомж гэж жигдлэх.

2.Нийтийн өмчийн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиудын төслүүд нь тус хуулийн зохицуулалттай уялдсан эсэх, нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хуулийн төсөл нь хуулийн зорилго үндсэн зарчимтай нийцсэн эсэх талаар.

1.Хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйл Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 7.2 дахь хэсгийг бүхэлд нь буюу төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн хоол үйлдвэрлэлд хэрэглэх хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг орон нутгийн өмчид төсөвт үйлдвэрийн газар хариуцсан нийлүүлэгч болохоор заасныг хүчингүй болгохоор тусгасан боловч уг заалттай шууд хамаарал бүхий 7.3, 7.4 дэх хэсгийг төсөлд хөндөгдөөгүй орхигдуулсан байна.

2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 2 дугаар зүйл буюу .../минут дуусав/

Р.Сэддорж: 1 номер.

Ч.Дондогмаа: Төслийн 2 дугаар зүйлд тус хуулийн 4.1.9-ийг орон нутгийн өмч гэж орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой Нийтийн өмчийн хуулийн 10 дугаар зүйлд заасан хөрөнгийг ойлгоно гэж өөрчлөн найруулахаар тусгасан байна. Нийтийн өмчийн хуулийн төслийн 10 дугаар зүйл Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд заасан аймаг, нийслэл, сум, дүүргийн зарим чиг үүргийг сонгон авсан ба зөвхөн эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх бүхий өмчтэй байх мэтээр ойлгогдохоор тусгагдсан байна.

3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлд Засгийн газрын тусгай санг хуулийн этгээд гэж тооцохоор тусгажээ. Харин хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.5 дахь хэсэгт энэ хуулийн 7.1,8, 7.1.9-д Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй гэснийг өөрчлөхөөр тусгаагүй нь зөрчил үүсгэхээр байгааг хэлэлцүүлгийн шатад анхаарч, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангуулах.

4.Хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар:

Нийтийн өмчийн хууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болох талаар төслийн үзэл баримтлалд дурдсан тул хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн дагаж мөрдөх хугацааны зохицуулалтад хуулийн нэрийг нийтийн өмчийн хууль гэж нэг мөр болгон хууль зүйн техникийн шаардлагыг хангуулах нь зүйтэй байна.

Дүгнэлт, санал:

Хуулийн төслүүд болон холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд нийцүүлэн боловсронгуй болгох

зохицуулалт хоорондын зөрчлийг арилгах, Монгол Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх шатад Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нийцүүлж нэр томьёо хууль зүйн техникийн шаардлагыг хангуулах нь зүйтэй гэж үзэв. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Нарангэрэл Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зөвлөх, Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын референт, Оюунзул Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Дэлгэрмаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Нарангэрэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Бямбасүрэн гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг асуулт асууна.

П.Сайнзориг: Энэ хуулийн төслийг бол хэлэлцэхийг бол дэмжиж байгаа юм. Тэгэхдээ ерөөсөө яг хүлээж байсан шиг юм ерөөсөө орж ирсэнгүй. Нийтийн өмчийн тухай хууль гээд тэгэнгүүтээ Иргэний хуулийн 99.1-ийг давтаж бичиж байгаа юм. Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн төрөлтэй байна гэххээд энд ерөөсөө шашны бөгөөд олон нийтийн өмчийн асуудлаар 1 ч өгүүлбэр өөр алга. Тэгчхээд Нийтийн өмчийн тухай хууль гээд нэрлээд байгаа энэ үзэл баримтлал, зохицуулалтыг ерөөсөө ойлгохгүй байна. Хийвэл яг бүрэн хиймээр байна. Тэгээд ингээд төөрөгдөл эндээс яг үүсэх гэж байна. Одоо тэгээд Нийтийн өмчийн тухай хууль гэх юм бол олон нийтийн өмч дотор чинь өнөөдрийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагаас энэ сангийн асуудлууд чинь бүгд байгаа шүү. Өнөөдөр төрийн бус байгууллага нэртэй их дээд сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдийн асуудлыг энд зохицуулах гэж байгаа юм бол яаж уялдаж орж ирэх гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээрээсээ эхлээд бас энэ тооцоо судалгаа бүх юмыг ойлгомжтой болгохгүй бол нэр ингэж автоматаар өөрчлөөд их асуудлыг шийдэх гэж байгаа юм шиг ингэж орж ирж байгаад бас туйлын харамсалтай байна. Энэ 2 ангиллын асуудлыг 1 ч дурдаагүй мөртөө Иргэний хуулийн 99.1-ийг давтаж биччихээд би энэ дээрээс бүр хайгаад хайгаад юу ч олсонгүй. 1 дүгээрт ийм байгаа юм.

2 дугаарт Иргэний хуулиа мэдээж барина. Иргэний хууль дээрээ барихдаа Иргэний хуулийн суурь концепц анх Германы хуулийг дагаад гарчихсан учраас орон нутгийн өмчийг бие даалгаад гарчихсан юм. Уг нь бол төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улсын хувьд орон нутгийн өмч гэдэг бол төрийн өмчийн дэд ангилал юм байгаа юм. 1 хэлбэр нь юм байгаа юм. Тэгээд орон нутаг бол тэр өмчийг хариуцагч байдаг. Улсын Их Хурлынхаа өмнө ямар өмчүүдийг хүлээж авсан, тэрний үр өгөөж, ашиглалт бүх юмыг ингээд олгосон эрх хэмжээний хүрээнд явж байдаг. Гэтэл яах вэ, зүгээр Иргэний хуулиа бид нар хөндөөгүй гээд ингэж орж ирж байгаа юм шиг. Энэнээсээ эхлээд манай төрийн байгууламжийн хувьд цаашдаа нэгдмэл байх уу, үгүй юү гэдэг асуудал яригдах гэж байгаа юм. Уг нь бол асуудлуудыг ултай суурьтай шийдэх тэр концепцыг уг нь Хууль зүй, дотоод хэргийн яам дээр Бямбацогт сайдын үеэс эхлээд л уг нь судалж байсан юм даа. Тэгээд ерөөсөө энэ судалгаануудыг

аваагүй байна. Хэрэглээгүй байна. Асуудлыг сууриар нь ерөөсөө хараагүй байна. Ийм л зүйл байна.

Энд бас нэг ноцтой юм байгаа. Төрийн болон орон нутгийн өмчөөр эзэмшигчээс үүсгэн байгуулсан ашгийн төлөө сан гэж байгаа юм. Ингээд төрийн өмч дээр тулгуурлаж байгаад баахан олон нийтийн өмч болсон сан байгуулах нь л дээ. Ингэж бол болохгүй. Санг бол зөвхөн өнөөдрийн нөхцөл байдал, практикаар Улсын Их Хурал байгуулж байгаа шүү. Бид хэд төрийн өмчийн аж ахуйн нэгж дээр суурилж байгаад жишээ нь олон нийтийн радио телевиз гэдэг сан байгуулж байсан юм. Олон нийтийн өмчит. Тэгээд одоо энэ чинь ингээд дур дураараа юм руугаа нээгээд өгчихсөн байна шүү дээ. Тэгэхээр энэ ерөөсөө ойлгомжгүй. Эргээд энэ хуулийн жижиг сажиг техникийн зөрөөнүүд маш их байна. Уг нь нэлээн гайгүй ажиллаж байгаа байх гэсэн ч энд ерөөсөө юм шийдээгүй байна.

Тэгээд Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бол өмчит компанийн хувьцаа, хувьцаанд хамаарах/минут дуусав/

Р.Сэддорж: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Бид нар 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Сайнзориг гишүүн мэдэж байгаа байх. Тэр Үндсэн хуульдаа бид нар Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлийн баялаг, ой усны нөөц, бүгдээрээ төрийн нийтийн өмч байна гэж заасан. Нийтийн өмчийн ойлголт үндсэндээ бол Үндсэн хуульд орсноосоо эхлээд бий болсон. Иргэний хуульд бас нийтийн өмч нь төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн төрөлтэй байна гээд яг өнөөдөр бол нийтийн өмчийн ерөнхий зохицуулалттай холбоотой хууль, эрх зүйн орчин бас бүрдээгүй байж байгаа. Ийм учраас нийтийн өмчийн суурь харилцааг зохицуулах хүрээндээ бид төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн нэрийг Иргэний хуульд заасан энэ төрөлд нийцүүлээд, өргөжүүлээд Нийтийн өмчийн хууль болгож оруулж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол бид ингээд төрийн болон орон нутгийн өмчөө Үндсэн хуульд заасны дагуу нийтийн өмчийн асуудалтайгаа нэгтгээд оруулж ирж байгаа. Үүнээс гадна бидэнд тэр нөгөө таны ярьж байгаа шашны байгууллагын өмчийг яах юм, төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагуудын өмчийг яах юм гэдгийг бол тусгайлсан хуулиар хөгжүүлэх харилцааг зохицуулах ийм байдлаар шийднэ гэдэг агуулгаар өнөөдрийн хуулийн төсөл үзэл баримтлалыг оруулж ирсэн гэдгийг бас танд хэлье. Тэгээд энэ дээр үндсэндээ манай Хууль зүй, дотоод хэргийн яам, ер нь Энхбаяр сайд байх үед Сайнзориг Төрийн нарийн байх үеэс энэ ажил маань үндсэндээ эхэлсэн шүү дээ. Тийм болохоор энэ хүрээндээ энэ асуудал явж байгаа гэдгийг та бас зөв ойлгож байгаа байх. Тэгээд цаашдаа нөгөө Шинэчилсэн найруулга хэлэлцэх эсэх учраас үүнийг тойрсон нэлээн маргаан, мэтгэлцээн өрнөх байх. Анх 2019 онд ч энэ хуулийн бас өөрчлөлтийг ярьж байх үед нийтийн өмч төрийн өмч байх уу, төрийн нийтийн өмч байх уу гээд нэлээн асуудал дагуулдаг байсан. Энийг дагаад нэлээн хэлэлцүүлэг өрнөх байх. 1 давуу тал нь бол бид хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт өргөн бариагүй, шинэчилсэн найруулга учраас энэ дээр манай хуульчид, манай Их Хурлын гишүүд бас ярилцаад, ажлын хэсгийг нь байгуулаад нэлээн тодорхой шийдэл гарна байх гэдэгт найдаж байгаа.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн тодруулж асууна.

П.Сайнзориг: Тэгэхээр нөгөө хэлэлцэх эсэхийг нь шийдвэл Энхбаяр гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгтэй энийг хамтатгаж шийдмээр байна. Тэнд нөгөө

төрийн болон орон нутгийн өмчит компани байгаа юм. 1 ажлын хэсэг бараг аваад уялдаатай явах нь зөв байгаа юм. Тэгэхдээ үнэхээр энэ хууль дээр нэлээн олон асуудал байна шүү. Одоо ингээд 47.1.төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэх харилцааг гуравхан зүйлээр хязгаарлчихсан байна. Дуудлага худалдаа, уралдаан, сонгон шалгаруулалт гэрээ. Гэтэл өнөөдөр төрийн болон орон нутгийн өмчит компаниудыг бид нар хөрөнгийн зах зээл дээр гараад IPO хийх гээд байдаг. Үүгээр ингээд хаагаад хаячхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь орон нутаг төрийн өмчийг шилжүүлэх 1 хэлбэр шүү дээ. Тэгэхээр бид хэд юмнуудаа бас уялдуулж орж ирэхгүй бол болохгүй байгаа юм. Энд байна шүү дээ, түрүүн бас санал, дүгнэлт дээр байна лээ. Энэ дээр Засгийн газар орон нутагт шилжүүлснээс бусад бүх үл хөдлөх хөрөнгүүдийг шилжүүлэх асуудал Засгийн газрын бүр онцгой бүрэн эрхт орчихсон байна лээ. 12.3.4. Тэгэхээр ийм зүйлүүдийг бас ажлын хэсэг дээр анхааръя. Дээрээс нь 8.1.11 байгаа. Стратегийн ач холбогдол бүхий салбар .../минут дуусав/

Р.Сэддорж: Гараа өргөөрэй. 5 номер.

Д.Цолмон: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Цолмон. Энэ нийтийн өмчийн хуулийн зохицуулалт маань ер нь бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу нийтийн өмчийн тухай хууль гэж орж ирсэн. Иргэний хуульд заасан бас энэ өмчийн эрх зүйн 2 үндсэн ангилал төрөл байгаа. Хувийн өмч, нийтийн өмч гэж ангилал байгаа. Нийтийн өмч дээр бид нар яах вэ, Иргэний хуульд байгаа энэ хэлбэрүүд нь бол олон нийтийн өмч, төрийн өмч, орон нутгийн өмч, шашны өмч гэсэн ийм д үндсэн 4 хэлбэр байгаа юм. Энэ хэлбэрээ бид нар өмчийн хэрэгцээгээ хадгалж, хуулийнхаа концепцыг илүү өргөн хүрээндээ олон нийтийн өмчийн бас харилцаанд нийтийн өмчийн үндсэн нийтлэг зарчмуудыг бас авч, тухайлсан хуулиараа зохицуулах боломжтой юм гэдэг байдлаараа энэ 6, 7 дугаар зүйл хүртлээ энэ харилцаа маань явж байгаа. Түүнээсээ хойшоо 7, 8 дугаар зүйлээс хойшоо бол дандаа төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулах зохицуулалтууд илүү .../минут дуусав/

Р.Сэддорж: Өөр нэмж хариулах хүн байна уу. Гүйцээж хариулъя. 5 номер.

Д.Цолмон: Хуулийн үйлчлэх хүрээтэй холбоотой зохицуулалт бас байгаа. Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн эрх зүйн харилцааг бол ерөнхийдөө тухайлсан хуулиар зохицуулна гэдэг энэ 3 дугаар зүйл дээр бид оруулж өгсөн. Тэгэхээр нөгөө төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах, шилжүүлэх, захиран зарцуулах энэ хэлбэрүүд нь зөвхөн энэ 3 аргаар хязгаарлагдана гэхээсээ илүүтэй яг компанийн хуулиараа тусгайлан зохицуулсан байх юм бол тэр нөгөө хувьцаагаа бусдад, олон нийтэд нээлттэй арилжих энэ хэлбэрүүд үйлчлээд явна. Зөвхөн юу гэдэг юм, шууд гэрээ байгуулах, дуудлага худалдаа, уралдаан шалгаруулалт гэсэн энэ 3 аргаар хязгаарлагдана гэж бол ойлгохгүй. Ерөнхийдөө энэ төрийн болон төрийн нийтийн өмчийн энэ гол зарчмууд энэ хуулиараа илүү тодорхой болж өгөөд, дагалдах. Ойн тухай хууль, Усны тухай хууль ч гэдэг юм уу, Газрын хэвлийн баялгийн тухай хууль ч гэдэг юм уу, Ашигт малтмалын тухай хууль гээд энэ нийтийн өмчийн бүх төрлүүд дээр өмчөө захиран зарцуулах, өмчөө ашиглуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах энэ арга хэлбэрүүд нь бол тухайн хууль .../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд асуулт асууна.

Л.Соронзонболд: Төрийн болон орон нутгийн өмчийн гээд нийтдээ бүртгэлтэй 5484 этгээд байдаг юм байна. Тэгэхээр ер нь энэ хуулийн төсөл батлагдсан тохиолдолд цаашдаа энэ тоо ер нь хэд болж өснө гэж харж байгаа вэ гэдэг асуулт байгаад байгаа юм. Ялангуяа энэ нийтийн болон шашны өмчийн харилцаатай холбоотойгоор гэхэд энэ дээр ойролцоо тоо байна уу. Ер нь энийг өмнө нь зохицуулж байгаагүй харилцаа юу. Эсвэл шинээр зохицуулах гэж оруулж ирж байна уу гэдэг ийм 2 асуулт байна.

Р.Сэддорж: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Түрүүн хариулсан. Яг ингээд төрийн тусгайлсан өмчид хамаарах, нийтийн биш. Өнөөдөр бол 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тооллого хийсэн байдаг юм байна лээ. Үүгээр бол 6911 аж ахуйн нэгж хамрагдсан. Төрийн өмчит 1036 аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит 5875 аж ахуйн нэгж байдаг юм байна. Үүнийх нь нийт хөрөнгө нь үндсэндээ 112 их наяд орчим төгрөг байгаа. 112. Үүнээс 17 их наяд нь орон нутгийн өмчит компаниуд дээр, төрийн өмчийн компаниуд болон бас аж ахуйн нэгжүүд дээр 94 орчим их наядын хөрөнгө бүртгэлтэй байдаг юм байна лээ. Зүгээр яг түрүүн ярьсан нийтийн өмчөөс тусдаа, нөгөө төрийн бус байгууллага, шашны байгууллага гээд энэ хуулийн этгээдүүдийн бүртгэл УБЕГ дээр бүртгэлийн нэгдсэн багц хуулиар тэнд харьяалагдаж явж байгаа. Яг үүнтэй холбоотой тооллогуудыг бол яг статистик дээр хийдэг байх тийм үү. Үндэсний статистикийн газар дээр. Бусдаар яг хөрөнгийн бүртгэл нь бол УБЕГ дээр эд хөрөнгийн болон хөдлөх болон хөдлөх бус хөрөнгүүд бүх хөрөнгийн бүртгэл тэнд хийгдэж байгаа. Төр бол үндсэндээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, хуучин Төрийн өмчийн хороо бол энэ төрийн өмчтэй аж ахуйн нэгжүүдийнхээ бүртгэл, тооллогыг 5 жилд 1 удаа хийдэг. Яг хамгийн сүүлийн тооллого нэг иймэрхүү байдалтай тоо мэдээлэл гарсан байдаг юм байна лээ. Шашны байгууллагын тооллого хийсэн юм бол байхгүй биз дээ. Манайхан хариулчих даа.

Р.Сэддорж: 3 номер.

Б.Цэнгэл: Ер нь бид төрийн нийтийн өмч гэдэг ийм нэр томъёог хэрэглэж байгаа гол асуудал бол 8.1-8.1.11 хүртэл тухайлбал газрын хэвлий, түүний баялаг, ой, түүний нөөц, ус, түүний нөөц, ургамал, ан амьтан, агаар, агаарын орон зай, эрдэнэсийн сангийн хөрөнгө, үндэсний баялгийн сангийн хөрөнгө, палеонтологи, археологийн олдвор, төрийн архивын сан хөмрөг гээд ингээд ангилаад явчхаж байгаа юм. Соронзонболд гишүүний асуултад нэмэлтээр хэлэхэд бол бид энэ хуулиар бол ерөөсөө цахимжуулах асуудлыг бол нэлээн оруулж өгсөн. Ил тод байх. Тэгэхээр энийгээ хийж байгаад бид улсын хэмжээнд бүртгэлийн нэгдсэн ийм системтэй болох, өөрөөр хэлбэл бид нарын тоонууд их зөрөөд байдаг шүү дээ. Энэ тоог ерөөсөө дахиж зөрдөггүй болгох ийм юмнуудыг энэ хуулиараа бол үндсэндээ шийдэж өгье гэж зорьж байгаа. Тухайлбал, юу гэдэг юм орон нутгийн өмчит компани хэд байна .../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. 3 номер. Тухайлбал, иргэний бүртгэл мэдээллийн төв дээр гарч байгаа тоо, манай тоотой бол бас зөрдөг байхгүй юу. Тэгэхээр бид энд яагаад ингээд байна гээд судлаад үзэхээр бол иргэний бүртгэл мэдээллээр татан буугдсан аж ахуйн нэгж, энэ тэрийн бүртгэлүүдийг бас тэр болгон тэр дор нь хийдэггүй ийм юмнууд бас байдаг юм байна лээ. Тэгэхээр одоо манайх 4 жил тутам бол тооллого хийдэг. Энэ тооллогын дүнг бол үндсэндээ баримталж байгаа. Тэгэхээр цаашдаа ерөнхийдөө тоо бол таны хэлж байгаа тэр 5 мянга гаруй

тоо бол 2022 оны тоо байгаа. Гэхдээ энэ тоо бол нэг их айхтар бол хөдлөөд байхгүй. Ийм байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ундраа асуулт асууна.

А.Ундраа: Ер нь төрийн өмчийн, нийтийн өмчийн ашиглалтыг зөв зохистой болгох, үр өгөөжийг нэмэгдүүлэх энэ асуудал бол бас иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх тал дээрээ чухал ач холбогдолтой гэж харж байгаа. Тэгээд ер нь бол төрийн өмчийн зарцуулалт, зохицуулалт төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн дотоод менежменттэй холбоотой эргэлзээтэй, бас олон нийтийн дургүйцлийг төрүүлсэн зүй зохисгүй ашиглалттай холбоотой мэдээ бол тасралтгүй гардаг гэхэд хилсдэхгүй. Тэгэхээр энэ зохицуулалтыг, бүртгэлийг илүү сайжруулах, ил тод нээлттэй болгох, үр өгөөжийг сайжруулах чиглэлээр ингээд хууль, эрх зүйн орчин сайжирч гарч байгаа нь бол сайн хэрэг. Энд бас үзэл баримтлал дотор хэлсэн байна л даа. Хуульд заасан зорилго, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх гэхээр яг хуулиас харахад тодорхой тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр яг ийм ийм заалт орж ирсэн гэж илтэд харагдахгүй байна. Тэгэхээр яг энэ бүлэгт ийм заалтууд орчихсон учраас Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн юм гэдгийг илүү тодруулж хариулбал сайн байна. 1 дүгээрт.

2 дугаар асуулт бол ер нь төрийн өмчийн, нийтийн өмчийн барилга байгууламжийн ашиглалтын зардлыг бууруулах чиглэлээр ямар алхмууд авах гэж байна. Тэгэхээр улсын төсөв хэлэлцэх үед ашиглалтын зардал өндөртэй холбоотойгоор урсгал зардал байнга өндөр гардаг. Сайд бол яг сайн мэдэж байгаа. Жишээлбэл, 1 судалгаа харж байхад бол орон нутгийн өмчийн барилгын халаалтын зардал нь зөвхөн хэдэн жилийн халаалтын зардлыг нийлүүлэхэд хэрвээ тэр барилгыг эрчим хүчний хэмнэлттэй байдлаар барьсан бол тэр халаалтын зардлаас дахиад өөр барилга байгууламж барих, эсвэл магадгүй дахин шинэ төсөвт өртөгтэй дүйцэхүйц тийм их зардлыг гаргаж урсгал зардлаар гаргаж хийсгэж хаяж байгаа гэж хэлэх үү. Тэгэхээр ашиглалтын зардлыг бууруулах чиглэлээр энэ үр ашгийг нэмэгдүүлэх юу энэ хуульд туссан бэ.

Ер нь хөгжлийн чиг хандлагатай холбоотойгоор Тогтвортой хөгжлийн зорилт гэхээр зөвхөн энэ хүрээлэн буй орчин, ногоон байгууламж энэ тэрээс гадна барилга байшин чинь өөрөө ухаалаг болж хувираад байна шүү дээ. Тэгэхээр бид ингээд 21 дүгээр зуун гараад 20 хэдэн жил болж байхад нүүрсээр галлаад ингээд сууж баймааргүй байгаа юм. Манай гадаадад байгаа дипломат төлөөлөгчийн газруудын барилгуудын ашиглалтын зардал бас тэр засвар үйлчилгээг бол зүй зохистой хийхгүй бол бас төрийн өмч өөрөө үнэгүйдэх, тэгээд ашиглалт нь урт хугацаандаа бол маш ашиггүй байдлаар хохирох тийм нөхцөл байдал үүсээд байгаа хэд хэдэн жишээ байдаг. Цаг хугацаа бага байгаа болохоор бас дурдахгүй, нарийн хэлэхгүй. Ганцхан жишээ ярихад Нью-Йорк дахь төлөөлөгчийн газар бол бүр дипломаттай төлөөлөгчийн газрууд бүгдээрээ мэддэг жишээ шүү дээ. Тэгэхээр олон Элчин сайдын яамны талаар яг ийм юмыг хэлж болно.

Р.Сэддорж: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Энэ одоо мөрдөгдөж байгаа, хүчин төгөлдөр байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль бол 1996 онд батлагдсан. Тэгээд бид нар 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжсэн. Түүнтэй холбоотойгоор төрийн өмчит компаниудаа, төрийн өмчүүдээ хэрхэн яаж зохицуулах вэ гээд шилжилтийн хүнд цаг үе байсан. Тэр үед бол үндсэндээ энэ шилжилтийн үеийг төрийн өмч яаж удирдаж

зохион байгуулах вэ гэдэг асуудал, дээрээс нь яг тэр үеэс өмч хувьчлал маш эрчимтэй явагдаж эхэлсэн. Тийм болохоор 1996 онд батлагдсан хуулиар бол үндсэндээ тэр шилжилтийн үеийг хэрхэн даван туулах вэ, дээрээс нь өмч хувьчлалаар яаж төсвийн орлого бүрдүүлэх вэ гэдэг зохицуулалтуудыг хүчин төгөлдөр хуульд бас оруулж өгсөн байдаг юм байна лээ.

Тэгээд үүнээс хойш нийт зүйлийнх нь 80 орчим хувьд нь 39 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байгаа. Энэ нь хуулийн гол зохицуулалттай холбоотой тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд биш, ганцхан салбарын бусад хууль шинэчлэгдсэн, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор л өөрчлөлт ороод байдаг. Яг энэ төрийн өмчит компани, төрийн өмчийн бодлого зохицуулалт дээр бас орох өөрчлөлт нь орж чадаагүй.

2019 онд бид нар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийсэн. Үүнтэй холбоотойгоор 2020 онд Монгол Улсын Их Хурлын тогтоол баталсан. 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хууль баталсан. Энэ хүрээндээ бид нар үндсэндээ төрийн өмчит компанийн үр өгөөжийг яаж нэмэгдүүлэх вэ, энэ төрийн өмч, төрийн нийтийн өмчөөс Монголын ард түмэн бас яаж хувь хишиг хүртдэг болох вэ гэдэг бас томоохон асуудлыг хөндөж эхэлсэн. Яг үүнтэй зэрэгцээд төрийн өмчит компаниуд дээр тэр нүүрсний хулгайгаас авхуулаад, томоохон томоохон олон нийтийн анхаарал татсан иргэдийг бухимдуулсан асуудлууд үүсэж эхэлсэн. Энэ цаг үеэс бас үндсэндээ бид төрийн өмчит компаниуд хэн нэгэн дарга цэргийн халаасны хүн байдаг. Түүгээрээ дамжуулж түүнээс нь саадаг саалийн үнээ болгож ашигладаг энэ байдлыг цэгцлэх асуудал бол тулгамдсан том асуудал болж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор энэ төрийн өмчийн, төрийн нийтийн өмчийн тухай энэ хуулийг бас өргөн мэдүүлж, энэ хүрээндээ үндсэндээ төрийн өмчит компани, орон нутгийн өмчит компани төрийн нийтийн өмч, төрийн өмчийг хэрхэн үр өгөөжтэй болгох вэ гэдэг дээр анхаарал тавьж ажиллаж эхэлсэн. Тэгээд энэ хүрээндээ энэ хууль маань орж ирж байгаа.

Мэдээж төрийн өмчит компаниудын засаглал, үйл ажиллагаа үр өгөөж нэмэгдээд давхардал, хийдэл, үр ашиггүй бүтэц зохион байгуулалт зардал энэ бүхэн буураад эхлэхээр цаад талд нь бас энэ компаниудад тавьдаг шаардлага, шалгуур, бодлого, зорилтууд, энэ дотроо бас Тогтвортой хөгжлийн зорилтуудыг бас тусгаад өгье. Энэ дотор компанийн нийгмийн хариуцлага гэдэг юм байх ёстой. Ялангуяа төрийн өмчит компанийн бол энэ талдаа илүү бас манлайлах ёстой гэдэг үүднээс үзэл баримтлалын хүрээнд энэ зохицуулалтыг тусгаж оруулж өгч .../минут дуусав/

Р.Сэддорж: Бямбацогт сай. 2 номер.

Д.Нарангэрэл: Өмч хөрөнгийн ашиглалт өгөөжийг нэмэгдүүлэх тал дээр бас энэ хууль дээр нэлээд зохицуулалтууд орж өгсөн байгаа. Тэр дээр жишээлэх юм бол ашиглуулах, шилжүүлэх үнэ төлбөртэй, төлбөргүй байсан солилцоо хийх зэрэг одоогийн хуульд байхгүй олон зохицуулалтууд нэмж орж ирснээс гадна энэ өмчийн үр өгөөж, ашиглалттай холбоотой нэлээд заалтууд орж ирсэн. Тухайлах юм бол, орон нутгийн өмчийн газруудтай төрийн өмчийн хорооны ажлын уялдааг нэлээн сайжруулж удирдлагаар хангахаас гадна төрийн өмчит хохирол учруулсан эрсдэл бүхий үйлдэл, эс үйлдэхүйг таслан зогсоох, шаардлага гаргах, төрд учирсан хохирлыг барагдуулах чиглэлээр бас нэлээд хуулийн заалтууд орж ирсэн байгаа. Барилга байгууламжийн ашиглалттай холбоотой асуудлууд дээр одоогийн хуулийн зохицуулалт дээр байхгүй магадлах ажиллагаануудыг оруулж ирсэн. Энэ магадлах

ажиллагаа бол шийдвэр гаргахын өмнө ашиглалттай холбоотой дүгнэлтүүдийг гаргах, шийдвэр гаргалтад үндэслэл болохуйц нотлох .../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг асуулт асууна.

О.Номинчимэг: Өдрийн мэнд хүргэе. Яах вэ, ганц 2 бас асуултууд өмнөх хүмүүстэй давхцаж байх шиг байна. Гэхдээ би бүр ингээд нарийвчлаад ажлын хэсгийнхнээс асуумаар байгаа юм. Та хэд маань Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулгыг оруулж ирэхдээ Нийтийн өмчийн тухай хууль гэж нэршиж орж ирсэн. Тэгээд энэ дээр түрүүн хэлсэн Иргэний хууль дээр байгаа нийтийн өмч чинь юу юунд хуваагддаг юм бэ гэдгийг хэлчихсэн байгаа. Тэгээд энэ дээрээ олон нийтийн өмч гэдэг хэлбэртэй байна гээд Иргэний хуулийнхаа концепцыг давтчихсан байгаа. Олон нийтийн өмч гэдгийг Иргэний хуульд заасан олон нийтийн өмч гэдгийг яг та нар юу гэж ойлгоод энэ хуульд зохицуулаагүй үлдээсэн юм бэ. Ямар өөр зохицуулалт хэрэгтэй гэж үзээд олон нийтийн өмчийг үүнээс гаргаад хаячхав.Тэгэхээр 1 дүгээрт олон нийтийн өмч гэж яг юуг хэлээд байна. Тэгээд яагаад энэ хуульдаа багтаагаагүй гэдгийг нарийвчилсан тайлбар авчихъя.

2 дугаарт ер нь бол манай энэ өмчийн асуудал чинь төрийн болон орон нутгийн өмч, ер нь орон нутгийн өмч гэж яг юуг хэлэх юм гээд олон асуудлууд байгаа. Орон нутгийн өмчтэй холбоотойгоор би энэ листүүдийг нь харж л байна л даа. Тэгээд дүүргийн, сумын өмчөөр бүтээсэн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж гээд байна. Энэ маань өөрөө сумын, дүүргийн өмч байх юм уу эсвэл нөгөө нэг коммуниал проперти буюу олон нийтэд нээлттэй бид нарын энэ концепцоор бол уг нь төрийн нийтийн өмч л байх л ёстой л байх л даа. Бусад хүмүүст нээлттэй хэрэглэгдэх ёстой. Тэгэхээр эндээ болохоор сум, дүүргийн өмч гэхчхсэн. Ер нь тэгээд өмчийн харилцаагаа бид нар бодох юм бол нөгөө нийтийн өмчийн эмгэнэл гэдэг үзэгдэл байдаг. Эдийн засгийн ойлголт. Нийтийн өмч эзэнгүйд нь тэр чиг чинээгээрээ нөгөө нөөц бололцоо, ресорс маань байхгүй болдог эмгэнэлт тражиди болдог гэдэг. Тэгэхээр энэ яг удирдлага менежментийг ялангуяа би төрийн нийтийн өмч дээр одоо та бүхний хувааснаар сум, дүүргийн, олон нийтэд нээлттэй байгууламжуудын энэ өмчийн удирдлага менежментийг тэгвэл ямар зохион байгуулалтаар хийхээр энэ хуульдаа тусгасан юм бол гэдгийг эхлээд сонирхоод асууя. Гэхдээ хамгийн гол нь эхлээд олон нийтийн өмч гэж яг юуг тодорхойлоод байна. Яагаад энэ хуулиараа зохицуулах шаардлагагүй гэж үзсэн гэдэг тодорхойлолт ойлголтыг чинь эхлээд сонсоодохъя.

Р.Сэддорж: Хариулт 5 номер.

Д.Цолмон: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Цолмон. Иргэний хуулийн яг энэ ангилал дээр нийтийн өмчийн төрөл ангилал хэлбэр дотор бол олон нийтийн өмч гэдэг ийм өмчийн хэлбэр бол байгаа. Гэхдээ нарийвчилсан зохицуулалт бол байхгүй байгаа. Гэхдээ тухайлсан Их Хурлаас баталсан хуулиуд дээр олон нийтийн өмчтэй байгууллагууд бол байдаг. Энэ дээр бол Үндэсний Радио Телевиз тухайлбал хамаараад явна. Тэгэхээр ер нь энэ олон нийтийн өмчийг яг олж авах, олон нийтийн өмчөөрөө яг ямар байдлаар удирдах энэ асуудал бол ерөнхийдөө нийтлэг зарчмыг нь энэ Нийтийн өмчийн тухай хуулиараа бариад яваач ээ. Энд тогтоосон энэ хэдэн зарчмууд байгаа. Энэ төрийн болон орон нутгийн өмчийн нэгдмэл тогтолцоондоо баригдаач ээ. Тэгээд гол нь өмчийг удирдах этгээдүүдийн эрх мэдлийн хуваарилалтыг нь бас яг ялгаа заагийг

нь бас энэ хуульд нийцүүлж, тухайлсан хуулиар зохицуулах боломжийг нь бол нээлттэй үлдээгээд ингээд явсан байгаа юм.

Хэрвээ яг энэ олон нийтийн өмчийг бид энэ хуулиараа бол зохицуулах бол боломжгүй болчхоод байгаа юм. Тэгэхээр бүх л дагасан юу гэдэг юм, тусгайлсан хуулиар өмчтэй байгууллагуудын харилцааг тухайлсан хуулиар нь л явъя. Гэхдээ нийтлэг зарчмыг нь энэ хууль дээрээ үндэслэж явъя гэдэг ийм зарчим баримтлаад байгаа байхгүй юу.

Олон нийтийн өмч гэдэг бол ерөөсөө л энэ улсын төсвөөс хуваарилж өгсөн, үгүй бол юу гэдэг юм, нийгэм, эдийн засгийн ашиг сонирхлоо хангах зорилгоор бүлэг хүмүүсийн цуглуулсан. Одоо ингээд шашны байгууллагууд ч гэсэндээ олон нийтийн өмчтэй бас хамаарах бол хамаарчих гээд байгаа юм.

Р.Сэддорж: Номинчимэг гишүүн тодруулж асууна.

О.Номинчимэг: Тэгэхээр бүгдээрээ нөгөө олон нийтийн өмч гэдгээ яг юуг ойлгож байна гэдгийг онолын түвшинд бас та хэд уг нь эрдэмтэн судлаачидтай зөвлөлдсөн үү. Би чинь ойлгоод байгаа шүү дээ. Олон нийтийн өмч гэдэг чинь олон нийтэд нээлттэй л өмчийг хэлээд байгаа шүү дээ. Уг нь бол нөгөө та хэдийн энэ төрийн нийтийн өмч дотор орчихсон байгаа зарим асуудал, нийтийн зориулалтаар ашиглахаар хуульд заасан бусад гэдэг чинь уг нь бол миний ойлгож байгаагаар олон нийтийн өмч байхгүй юу. Тусдаа хүмүүсийн хамтраад байдаг юм шиг бол хамтын өмч, дундын өмч ч гэд гэдэг юм уу. Коммунел проперти буюу яг юу гэдэг юм, бэлчээрийн газрыг чинь тухайн тэр сумын иргэдэд ингээд хамтдаа эдэлнэ гээд заачихсан юм бол коммунел буюу хамтын өмчийн хэлбэр эд нар луу болчхоод байгаа юм. Олон нийт гэхээрээ манай Иргэний хууль дээр нарийвчилсан зохицуулалт байхгүй. Гэхдээ ойлголт нь уг нь нийтийн өмчийн 1 хэлбэр гэж ойлгоод байгаа байхгүй юу. Тэгээд эндээсээ яахгүй бол зөвхөн олон нийтийн өмчийг төсвөөс гаргаж өгөөд, тухайн хүмүүст л яана гэх юм бол тэр нөгөө нийтийн бэлчээрээс энэ хэсгийг л хамтын өмчлөлөөр гэдэг болчих гээд байгаа байхгүй юу.

Р.Сэддорж: Хэн хариулах вэ. Товч тодорхой хариулъя. 2 номер.

Д.Нарангэрэл: Төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн нийтийн өмч гэдэг дээр бид нар бас хуулийн хүмүүсийн тайлбар харж байгаад одоо бол яг тусгайлсан өмчийн ангилал дотор байгаа өмчийг түрүүн гишүүн хэлж байна л даа. Жишээлбэл, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн зориулалттай явган зам, ногоон байгууламж гээд. Энийг бол татвар төлөгчдийн мөнгөөр бий болгож байгаа. Орон нутгийн хөгжлийн сангийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болгож байгаа юм. Тэгэхээр энийг бид нар төрийн нийтийн гэдэг ангилал руу оруулахгүй, нийтийн зориулалттай тусгайлсан өмч дотроо орон нутгийн өмч дотроо нийтийн зориулалттай өмч гэж оруулж байгаа юм. Тэгэхээр нөгөө нэгжийн тухай хуулиар тухайн сумын иргэдийн Хурал, Засаг дарга энэ нийтийн зориулалттай өмчийг бий болгох, арчилж тордох эрх, үүрэг нь байгаад байгаа учраас бий болгож байгаа этгээд дээрээ сумын Тамгын газар дээрээ тохижилт үйлчилгээнийхээ байгууллага дээр байгаад, шинээр бий болгох энд зохицуулалтыг нь аваад явж байгаа асуудал байгаад байгаа юм. Түрүүн Цэнгэл даргын хэлдэг 8.1 дээр заасан өмч нь болохоороо манай Засгийн газрын өмчид бүртгэлгүй, төрийн нийтийн өмч гээд. Ой доторх баялаг гэдэг юм уу, тэр агуулгаараа салбар хуулиудаараа бүртгэх соёлын өв энэ тэрнээс авхуулаад бүртгэх зохицуулалт бүх зүйлүүд нь явж байгаа. Тэгэхээр нийтийн зориулалттай өмч бол яг манай төрийн болон орон нутгийн өөрийнх нь ангилалд орж ирж байгаа..

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Мандхай асуулт асууна.

М.Мандхай: Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ төвлөрсөн эрх мэдэл яг энэ хуулиар бас суллаж өгөөгүй харагдаад байгаа. Жишээлбэл, энэ төрийн өмчийг бүртгэх, тайлагнах, үнэлэх, хяналт тавих гээд функцүүд байна л даа. Тэгээд энэ Засгийн газрын байгууллагад бол илүү даатгачихсан. Жишээлбэл өмчийн асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ гэж заасан байх юм бол орон нутгийн оролцоог нь илүү хязгаарлачихсан. Өмчийг шилжүүлэхэд заавал Засгийн газрын шийдвэр шаарддаг нь энэ хуулиараа бол илүү төвлөрсөн эрх мэдэл байгаа юм биш үү гэдэг асуулт байна. Энэ дээр яг нарийн зохицуулалтыг нь хэлж өгөөч.

2 дугаарт орон нутгийн оролцоо их сайн хангагдаагүй харагдаж байна энэ хууль дээр. Жишээлбэл, энэ орон нутгийн өмчийн эрх мэдлийг аймаг, нийслэл, сумын иргэдийн Хурлаар дамжуулсан боловч бодит шийдвэр гаргах функцүүдийг нь төрийн түвшинд нь илүү төвлөрүүлчихсэн харагдаж байна. Тийм ээ. Ялангуяа нөгөө шилжүүлэх, хувьчлах асуудалд бол илүү зүгээр тухайн шатны байгууллага санал өгөх эрхтэйгээр орж байгаа харагдаад байна. Мөн олон улсын яг энэ нийтийн өмчийг хамгаалах асуудал дээр илүү ил тод байдлыг сахина гэхчхэн байгаа. Түрүүн бас Хэрэг эрхлэхийн сайд маань хэлж байна лээ. Ил тод байдлыг бид нар ингэж хангана гээд. Гэхдээ энэ гэрээний ил тод байдлыг хангах тухай дурдсан ч гэсэн цахим мэдээллийн өөрөө энэ платформ, хяналтын хэрэгсэл, ялангуяа энэ иргэдийн оролцооны талаар заалтууд нь ер нь тодорхойгүй байна. Нарийн ер нь яаж санхүүжигдэж, яаж хэрэгжих юм бэ гэдэг нь бас их ийм ил тод хяналтын механизм дутуу харагдаж байна.

Дараа нь төрийн өмчийн жишээлбэл Японы кэйс дээр л ярихад Японд бол жишээлбэл төмөр замын энэ компаниудыг тухайн бүсээс нь ялгаатай үзээд, менежментийг нь хувьчлах, магадгүй тодорхой хувьцааг нь хувийн хэвшилд олгоод, тэгээд ингэснээрээ болоод энэ чинь нөгөө орлого төвлөрөлт сайжирч байгаа. Нөгөө төрийн дарамт буурна. Ашигт ажиллагаа сайжирна гээд маш олон давуу талууд үүсэж байгаа. Тэгэхээр яг энэ шинэчилсэн найруулгын хуулиар бид нар төрийн өмчид баахан ашиггүй, алдагдалтай, төсвөөс санхүүжээд явдаг энэ компаниудыг энэ төрийн өмчит компанийн хувьцааг зах зээлд илүү алхам алхмаар гаргах ямар механизм зохицуулалтуудыг оруулж өгсөн бэ. Магадгүй менежментийг нь ч гэсэн бид нар удирдлагын тэр эрхийг нь хувийн хэвшилд илүү шилжүүлэх, гэхдээ гол нь зарчмын хувьд нөгөө стратегийн бас гол аюулгүй байдлыг хангах зүйлд нь бид нар өөрөө төр нь хяналт тавьдаг ч гэдэг юм уу ийм боловсронгуй арай дараагийн олон улсын шатад хүрсэн ямар шинэчлэл, өөрчлөлтүүд хийсэн юм бэ.

Мөн ашиглагдахгүй газар гэж байгаа. Орон нутагт. Өөрөө удирдах байгууллага, хувийн хэвшилд түрээслэх, худалдах шийдвэрийг орон нутгийн нөхцөлд нь илүү гаргаж өгдөг..../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Мандхай гишүүн яг л чухал асуудал хөндөөд байна л даа. Яг таны ярьж байгаа энэ асуудлыг зохицуулдаггүй, зөвхөн гэдэг юм, өөрийнхөө ашиг сонирхлоор, өөрийнхөө хүсэл сонирхолд байгууллага, албан тушаалтанд нийцсэн, өөрчлөлтийг, нийцсэн Засгийн газрын тогтоол шийдвэр, журмыг гаргаад ингээд л амь аргацаагаад явсаар байгаад өдий хүрчихсэн юм байна лээ. Тэгээд түүнийх нь үр дагаврыг ч гэсэн бол Монголын ард түмэн хангалттай амссан. Төрийн өмчит компаниудаас үр өгөөж хүртэж чаддаггүй, эрх мэдэлтэн, албан тушаалтныг дагасан

нөхдүүд нь хулгай хийдэг. Энэ нь ил тод болоод ард иргэдийг бухимдуулдаг, энэ рүү очих гэж ерөөсөө л төрийн өмчит компанийн захирлаар оччих юм бол амьдрал сайжирна гээд бодчихдог. Төрийн өмчит тэр компанийг удирдах, ТУЗ-д нь орох, түүнийх нь өмчлөх, төлөөлөх эрхийг нь хэрэгжүүлэхийн тулд яамнууд нь, сайд нар нь, агентлагууд нь хоорондоо булаацалддаг, өрсөлддөг ийм болчихсон. Тэр хэдхэн том ашигтай ажилладаг, үндсэндээ байгалийн баялаг уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэдэн компаниуд нь ашигтай ажилладаг. Үлдсэн хэсэг нь амиа аргацаадаг. Тэгээд ард талд нь нэг хэсэг нь нөгөө алдагдалтай, тэгээд байх ч хэцүү, байхгүй ч хэцүү. Тийм компаниас нь хүмүүс нь зугтаадаг. Гэхдээ л нөгөө эрх мэдэлтэй болчих юм бол хүн томилдог томилгооны эрх мэдэл, мөнгөн дээр гарын үсэг зурдаг мөнгөний, санхүүгийн эрх мэдэл, түүний төлөө л бүгдээрээ л үхэн хатан тэмүүлдэг. Тэгээд энэ төрийн өмчит компанийн үр өгөөж, ил тод байдал энэ бүх юм чинь алга болчихсон. Тэгээд үүнийг л цэгцэлье гээд сайндаа ч биш бас олон нийтийн шахалтаар энэ нүүрсний хулгайнаас хойш л үндсэндээ төрийн өмчит компаниудыг цэгцэлье гэдэг олон нийтийн шахалтаар энэ хуулийг өөрчлөх асуудал орж ирж байгаа.

Би энэ хуулийн төслийг яг үзэл баримтлалыг нь батлаагүй. Өмнөх сайд нар маань батлаад явсан. Засгаас Их Хуралд өргөн барьчихсан учраас араас нь хэлэлцүүлгийг хийж байгаа юм. Ингээд өргөн барих үзэл баримтлалыг нь харж байхад бол зайлшгүй анхаарах, сайжруулах асуудлууд байна. Дахиад л нөгөө эрх мэдлээ булаацалдсан, дахиад л юу гэдэг юм өөрсдөдөө давуу байдал бий болгох гэсэн байгууллага албан тушаалтнуудын амбиц энэ хуулийн төслөөс харагдаж байгаа юм. Тийм болохоор би юу гэж хэлэх гээд байна гэвэл хэлэлцэх эсэхийг нь хийчихье. Олон нийтийн хэлэлцүүлэг хангалттай явуулъя. Тэгээд энэ хуулийн жинхэнэ тэр бөөсийг нь түүж байгаад, үнэхээр ямар хууль байвал зохистой юм бэ энэ хуулийг л бүгдээрээ баталъя. Тэгэхгүй Засгийн газрын өргөн барьсан хуулийг энэ чигээр нь дэмжээд өгөөч, энэ чигээр нь батлаад өгөөч гэж би хэзээ ч хэлэхгүй. Яагаад гэвэл энэ хууль хангалттай сайн боловсруулагдаагүй байна. Гэхдээ нөгөө талаас ард түмэн бас хүсээд шахаад байна.

Р.Сэддорж: Мандхай гишүүн тодруулж асууя. Бадамсүрэн гишүүнийг нэмээрэй.

М.Мандхай: Тэгэхээр ер нь миний асуулт бол яг энэ үзэл баримтлалаар бол яг нарийн тайлбарлагдахгүй юм байна. Тийм учраас ер нь илүү гүйцээн боловсруулах бол шаардлагатай гэж үзэж байгаа юм байна гэж ойлголоо. Хэрэв шаардлагатай гэх юм бол Байнгын хороо дээр бараг ажлын хэсэг гараад, энэ дээр өөрсдийнхөө саналыг тусгаад явах тийм саналтай байна. Протоколд бас үлдээчихье.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүнийг нэмээрэй. Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн.

Ш.Бямбасүрэн: Байнгын хорооны гишүүддээ болон ажлын хэсгийн гишүүдэд энэ оройн мэнд хүргэе. Энэ хуулийн өөрчлөх практик шаардлагыг бол ойлгож байгаа. 1996 онд байгуулагдсан. Одоо ашиглаад явахад маш хүндрэлтэй асуудлууд гардаг. Гол нь энэ гишүүдийн хэлээд байгаатай би бас санал нэг байгаад байгаа юм. Энэ арай аятайхан ороод ирэх болов уу гээд бодсон чинь бүр ухруулаад ороод ирлээ гэж харж байна. Ялангуяа орон нутгийн өмчит компаниудын хувьд бол өнөөдөр маш хүндрэлтэй байгаа л даа. Нээлттэй биш, ил тод биш, тэгээд намын томилгоогоор тэнд чадваргүй хүмүүс очдог. Тэрийгээ дагаад ажлыг унагаадаг гээд.

Үүнээсээ болоод энэ төрд итгэх иргэдийн итгэл маань уначихсан байж байгаа юм. Уг нь манай Компанийн тухай хууль чинь бол тийм муу хууль бол биш. Тэгээд аль болох тэрнээс холдуулаад, тусад нь ингээд хууль гаргаад, хуульд хамааруулаад орон нутгийн өмчит компаниудыг авч явах гээд байдаг юм. Тэрнээсээ болоод л энэ олон ил тод биш юмнууд гараад байдаг юм. Тэгээд яг Мандхай гишүүний хэлээд байгаа энэ асуудал бол яалт ч байхгүй орон нутгийн эрх мэдлийг бол хумьж байна л даа. Яг одоо орж ирсэн байгаа төслөөр бол. Яагаад бид нар ер нь орон нутагтаа эрхийг нь өгөхгүй байгаа юм бэ. Энэ ингээд бүр БЭТ томилно гээд юмнууд ороод ирж байгаа байхгүй юу. Төрийн өмчийн хорооны чиг үүрэгт тэрийг нь тусгаад өгчихсөн. Бид нар орон нутгийн эрх мэдлийг нь өгөөд, тэрийг нь нээлттэй ил тод явуулах тэр Компанийн тухай хуулиа бариад яв гээд явахад уг нь олон асуудлууд шийдэгдэнэ дээ. Тэгэнгүүт тэд нар хийж чадахгүй байгаа учраас бид нар хийнэ гээд бүр эрх мэдлийг 1 тал руу төвлөрүүлж байгааг би бол эрс эсэргүүцэж байгаа юм.

Тэгээд асуулт байна. Энэ нэгжийн хууль дээр аймаг, сум, дүүрэг, нийслэлийн чиг үүргийг маш тодорхой заагаад өгчихсөн байгаа байхгүй юу. Тэгтэл тэрнийхээ хүрээнд зарцуулсан хөрөнгө нь тухайн тэр юундаа үлддэг байхаар зохицуулахгүй маш олон энэ нэгжийн хуультай зөрчилдөх юмнууд гарах гээд байгаа байхгүй юу. Төсөв ашиглах, зарцуулах 2 дээрээ дараа нь. Одоо энэ орж ирсэн төслөөс харахад. Тэгээд ер нь энэ Компанийн тухай хуулийг бид нар яаж энэ юмандаа барих вэ гэдэгтээ орохгүй бол уг нь маш тодорхой байгаа шүү дээ. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмших эрх, үүрэг үзүүлж байгаа нөхдүүд нь ТУЗ-ийн гишүүдээ сонгоно уу. Тэндээсээ жил бүрийн тайлангаа тавья. ТУЗ-ийн гишүүдээ тэр дээрээ хяналтаа тавиулъя. Тэгээд гүйцэтгэх захиралтайгаа гэрээ байгуулдаг юм. Тэгтэл Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах эрх мэдэлгүй ТУЗ гэж ер нь байгаад яах юм. Тэгээд 1 баахан ТУЗ-тэй, ажил хийдэггүй, эрх мэдэлгүй тийм ТУЗ-тэй болчихоод байгаа байхгүй юу.

Р.Сэддорж: Хариулт Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Ер нь бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын удирдлага, зохицуулалт, менежмент, энэ дээр нэлээн бас анхаарах цаг болсон. Бас энэ хуулийн төслийн үзэл баримтлалыг бид нар бас ярилцаж байх явцад харж байхад бол хангалттай сайн зохицуулалтууд алга. Заримдаа эрх мэдлийг нь төвлөрүүлэх гээд байгаа ч юм шиг, заримдаа тараах гээд байгаа ч юм шиг. Энийг бас хангалттай сайн зохицуулж чадаагүй байгаад байгаа юм. Энэ чинь уг нь бид нар чинь аль болох эрх мэдлийг тараана. Төвлөрлийг багасгана гээд аймаг, нийслэл, сум дүүрэгт тодорхой эрх мэдлийг шилжүүлээд, тэдгээрээ бас тодорхой бодлого, чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангаад, эргүүлээд уг нь хяналт тавиад явах ёстой л доо. Яг энэ чиг үүрэг бол бас энэ хууль дээр бол сайн зохицуулагдаж чадаагүй байна лээ. Нуугаад яах вэ дээ. Гэхдээ сая таны ярьж байгаа БЭТ томилно гэсэн заалт энэ хуульд байхгүй байгаа. Түрүүн Мандхай гишүүн бас ярьсан, Номинчимэг гишүүн бас асуусан. Тэр олон нийтийн өмчийн тухай ойлголт, түүнийг бас хэрхэн яаж удирдах вэ, дээрээс нь юу гэдэг юм сумд сумыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бий болсон цэцэрлэгт хүрээлэнг хаана, яаж бүртгэж авах вэ, түүнийг яаж хэн хяналт тавих вэ, яаж үр ашигтай байлгах вэ гэдэг асуудлуудыг хүртэл нарийвчилж зохицуулах хэрэгтэй. Гэтэл тэр нь бас тийм сайн зохицуулагдаагүй л харагдаад байх юм. Тэгээд яах вэ, нэгэнтээ Их Хурлын гишүүд маань бас ард иргэд шахаж байна, Их Хурлын гишүүд шахаж байна. Энэ төрийн өмчийн компаниудаа цэгцэл. Төрийн өмчийн компаниудын тоог цөөл. Үр ашигтай болго. Эргээд ард иргэдэд өгөөж нь өгдөг болго. Энэ аймаг, нийслэл, тэр сумд үр ашиггүй хөрөнгө, төсвийн хөрөнгө, төрийн өмчийн

хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж байна. Үүнийг цэгцлэхгүй бол үнэхээр бас төрийн мөнгө уйлдаггүй гэдэг чинь арай л хэтэрхий болж байна гэдгийг шаардаж байгаа.

Тийм болохоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Үүнийг дагуулаад Нийтийн өмчийн тухай хуулийг оруулаад, энэ 2-ыг нийлүүлж ажлын хэсэг байгуулаад, энэ зун нэлээд хугацаанд Их Хурал дээрх ажлын хэсэг анхаарч ажиллаад, ард иргэдийн санал бодлыг сонсоод, хэлэлцүүлэг зохион байгуулаад, үүнийх нь үр дүнд маш сайн хуулийг Их Хурлынхаа гишүүдийн ажлын хэсгээр хамтарч ажиллаж батлуулъя. Хэлэлцүүлж батлуулъя. Ингэж байж энэ асуудлыг хурдан шийдэхгүй бол болохгүй байна, бүтэхгүй байна, чадахгүй байна гээд суугаад байвал ингээд 1996 оноос хойш шинэчилсэн найруулга хийгдсэнгүй. Ингээд 30 .../минут дуусав/

Р.Сэддорж: Бямбасүрэн гишүүн тодруулж асууя.

Ш.Бямбасүрэн: Энэ нийтийн өмчийн тухай хуулийн төсөл дээр 13.4.5 дээр нь байгаа юм л даа. Төрийн нийтийн үйлчилгээний байгууллагын хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор төрийн өмчийн төлөөлөгчийг түр томилон ажиллуулах гээд. Тэгэхээр энийг болохоор Төрийн өмчийн хорооны чиг үүрэгт нь заачихсан байгаа юм. Тэгээд энэ чинь өөрөө яг БЭТ-ийг л ярьж байгаа юм л даа. БЭТ томилох эрх, үүргийг нь өгч байгаа юм. Тэгээд ер нь одоо хүчин төгөлдөр байгаа хуулиар ер нь яг энэ зохицуулалт ер нь ямар байсан юм бэ. Энэ талаар хариулаад өгөөч.

Р.Сэддорж: Хариулт 3 номер. Цэнгэл дарга хариулъя.

Б.Цэнгэл: Одоо мөрдөж байгаа хуулийн 11.6 дээр төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний ажиллагаанд хяналт тавина гэдэг ийм бол зохицуулалт явж байгаа. Энэ бол гэхдээ компани биш. Өөрөөр хэлбэл таны хэлж байгаа зүйл бол төрийн нийтийн үйлчилгээний байгууллагуудын хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор төрийн өмчийн төлөөллийг төр томилон ажиллуулаад, буруутай этгээд нь хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох байгууллагад санал хүргүүлнэ л гэж байгаа юм. Төрийн нийтийн үйлчилгээний байгууллага гэдэгт бол бид нар сургууль, цэцэрлэг гээд ийм байгууллагуудаа ярьж байгаа. Одоо энэ нийтийн өмчийн хууль дээр бол бид ер нь бол ангиллыг 4 авч үзэж байгаа шүү дээ. Албан байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага гэдэг юмыг оруулж ирж байна. Тэгээд компани, орон нутгийн байгууллага гэдэг ийм л ангиллаар оруулж ирж байгаа юм. Тэгэхээр ер нь таны хэлээд байгаа энэ асуудал бол нөгөө .../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя 3 номер.

Б.Цэнгэл: Сайнзориг гишүүн ч гэсэн хэлээд байгаа. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хууль, Нийтийн өмчийн тухай хууль гэж одоо энэ нэрлээд байгаа энэ хуулийг ер нь бол хэлэлцэх эсэхийг нь дэмжчих юм бол хамтад нь ажлын хэсэг гаргаад ажиллахаас өөр аргагүй юм байна лээ. Яагаад гэхээр таны түрүүн асуугаад байсан асуулт дотор бол Компанийн тухай, төрийн өмчит компанийн тухай хуулийн юмнууд чинь бас яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ялгаа салгааг нь сайн ойлгож өгөөд хэлэлцэх эсэх энэ дэмжигдэх юм бол ер нь бид нээлттэй хэлэлцүүлгүүдээ нэлээн сайн явуулаад, Их Хурлын гишүүддээ ч гэсэн бүрэн дүүрэн ойлголт өгөөд ажиллах зайлшгүй шаардлага байна л гэж харж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Энэ хуулийг хэлэлцэх нь зүйтэй гэдэг дээр саналтай байна. 1 дүгээр асуулт. Төр стратегийн ийм ийм салбарт юм уу, яг энэ салбарт л төрийн өмчит компани байгуулна. Төр өмчтэй байна гэдэг зохицуулалт байгаа юу.

2 дугаарт нь чиг үүргээ дагаад эрх нь тодорхой байгаа юу. Яг хэдийн ямар үнэлгээтэй хөрөнгийг хаана шийдэх юм. Жишээлбэл, Улсын Их Хурал ширээ сандлын асуудлыг шийдэх үү. Аймаг, сумын хурал яг юу шийдэх юм. Энийг яаж зохицуулсан бэ.

3-д нь төрийн нийтийн өмч бол газрын хэвлийн баялаг мөн. Үндсэн хуульд орсон хамгийн том өөрчлөлт. Тэгэхээр газрын хэвлийн баялаг буюу төрийн нийтийн өмчийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхай, газрын тос энэ компаниуд өмчлөлийн хэлбэрээс үл хамаараад худалдан авах ажиллагаагаа ил тод нээлттэй зарладаг болох зохицуулалтыг энд оруулах уу.

4-д нь өмч хувьчлалаар хувьчлагдсан барилга байгууламжуудын зориулалт, байршлын талаар судалгаа байгаа юу. Жишээлбэл, Дорнод аймагт гэхэд хуучин манай 1 дүгээр сургуулийн, бидний төгссөн сургуулийн дотуур байрны барилга нь явсаар байгаад шүүхэд оччихсон. Тэгээд сургууль, цэцэрлэгүүдийн дунд шүүхтэй. Энэ судалгааг ер нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар авсан уу. Энэ дээр жишээлбэл, энэ хүүхдүүдийн дунд хуулийн байгууллага байж болох уу. Бид нар Тагнуулын байгууллага, Прокурорын байгууллагад газар өгчихсөн барилгатай байсан. Шилжүүлээд хуулийн хотхон болгоод энэ барилгуудыг нь буцаагаад оршин суугчдын дунд байдаг учраас хүүхдийн зориулалтаар ашиглаж байгаа. Тэгээд яг ийм төрлийн зохицуулалт ер нь бусад аймаг болон нийслэл дээр хийгдэж байгаа юу. Үүний судалгаа байна уу. Бид нарт барилгаас илүү байршил нь чухал. Өөрөөр хэлбэл хот төлөвлөлтийн анхны бодлогод байсан энэ барилгуудыг, объектуудыг өмч хувьчлалын үед хамаа намаагүй хувьчилснаас болоод энэ чинь оршин суугчдын, эрх хүүхдийн эрхийг зөрчсөн ийм тохиолдлууд байгаа. Энэ дээр ямар судалгаа байгаа вэ. Энийг тодорхой сонсмоор байна. Орон нутгийг өмчтэй, төсөвтэй болгож, бие даалгаж итгэл үзүүлэх талаар Бямбасүрэн гишүүн сая санал хэллээ. Би 100 хувь санал нэг байгаа. Ер нь насанд хүрсэн хүүхдэд итгэл үзүүлж, өөрийг нь бие даалгаж амьдруулах энэ бодлогыг аав ээж нь боддогтой адил ингэхгүй бүх юмыг ингээд Засгийн газар, Улсын Их Хурал дээр хураагаад, тэгээд даахгүй нохой булуу хураана гэдэг шиг ингээд орон нутаг чинь ямар ч эрх мэдэл байхгүй болчихсон. Төсвийн болоод өмчийн. Тэгэхээр энэ зүйлийг яаж энэ дээр оруулж байгаа вэ. Энэ бол хамгийн чухал, амин чухал юм. 21 аймагтай, өргөн уудам нутагтай. Засгийн газар бүх аймаг, сумд, 330 сумд хүрч чадахгүй. 1 аймгийн нутаг дэвсгэр нь нэлээн олон улсаас том. Нутаг дэвсгэрийн хэмжээгээр аваад үзвэл бараг .../минут дуусав/

Р.Сэддорж: Сайд хариулъя. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Ерөнхийдөө бас төрийн өмчийг цэгцлэх шаардлагатай байгаа учраас төрийн өмчит компани угаасаа зайлшгүй байх ёстой юм байна лээ. Хувийн хэвшилтэй өрсөлдөх зорилгоор биш. Түрүүн өөрийн чинь ярьдаг газар, газрын хэвлийн баялаг, ой усны нөөц бол төрийн нийтийн өмч байна. Тэр нийтийн өмчөөсөө Монгол Улсын өнөөдөр амьдарч байгаа болон ирээдүйд амьдрах иргэд нь үр өгөөжийг нь хүртдэг байх ёстой. Ард иргэдийг бас эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоонд хангах ёстой гээд Үндсэн хуульд заасан энэ заалтыг

хэрэгжүүлэхэд төр оролцох ёстой. Мөн бас энэ заалтыг хэрэгжүүлэхэд Үндэсний баялгийн сан байгуулаад, уул уурхайн бүтээгдэхүүний орлогыг төвлөрүүлээд иргэддээ хувь хишиг., ноогдол ашиг хүртээх энэ асуудлыг шийдэхэд төрийн өмчит компани байж байж энэ байгалийн баялгийн өгөөжийг хүртэх, зохицуулах, хуримтлуулах, ирээдүй хойч үедээ хадгалж үлдээх, өнөөдөр бас улс орныхоо эдийн засаг, нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах энд менежмент хийх зорилгоор 1 төрийн өмчит компани байх шаардлага байгаад байгаа юм. Нөгөөдөр нь ингээд эрчим хүч, зам юу гэдэг юм, дэд бүтцийн онцгой чухал ажлууд, стратегийн ач холбогдол бүхий салбарууд, авто зам, төмөр зам, эрчим хүчний шугам, сүлжээ, харилцаа холбоо гэх мэтийн салбарууд дээр зайлшгүй төр оролцож, төр иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах эдийн засаг, нийгэм, аюулгүй байдлын баталгааг хангах энэ чиг үүргийг бас хэрэгжүүлэх учраас төрийн өмчит компаниуд эрчим хүчний компаниудаас авхуулаад байгаад байгаа юм.

Нөгөөдөр нь дахиад бас хувийн хэвшлийнхэн хийж чадах боломжгүй учраас зайлшгүй энэ дээр хувийн хэвшлийнхэн хийх боломжгүй ажлуудыг сонирхохгүй учраас иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах энэ нөхцөл бололцоог хангах үүднээсээ АЗЗА компаниуд гэх мэтийн тодорхой компаниуд ашиггүй ажилладаг. Хэн ч сонирхдоггүй хувийн хэвшлийнхэн. Тийм болохоор энийг ариутгах татуурга, усан хангамжийн асуудал, цэвэр, бохир ус гээд л нийтийн аж ахуйн компаниуд гээд энэ чиг үүрэг гээд иймэрхүү чиг үүргүүдийн үүднээс зайлшгүй төрийн өмчит компаниуд байх шаардлага бий болж байгаа. Яг хуучин байсан компаниуд нь яг энэ чиг үүргээ сайн хэрэгжүүлж чадахгүй, өнөөдөр хууль, эрх зүйн орчин болохгүй байгаа учраас энэ хуулийг өөрчилж гэж байгаа.

Өнөөдөр бас хувийн хэвшилтэй өрсөлдөөд үйл ажиллагаа явуулж байгаа компанийг хувийн хэвшилтэй өрсөлдүүлэхгүй байх энэ үүднээсээ энэ хуулийн төслийг ерөнхийдөө бол өргөн барьж байгаа юм. Зайлшгүй бас хэлэлцэж, энийг шийдүүлэх цаг нь болсон, тулсан, тулгамдсан асуудал болсон учраас хэлэлцээд ингээд явах ёстой болов уу гэж бодож байгаа юм. Орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын тэмцэлд байгаа тийм Хөдөлмөрийн .../минут дуусав/

Р.Сэддорж: Бямбацогт сайд гүйцээж хариулъя.

С.Бямбацогт: Тэнд хариулчихъя. Цэнгэл дарга хариулчих.

Р.Сэддорж: 3 номер.

Б.Цэнгэл: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Улсын Их Хурлын бүрэн эрхэд бол төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдсэн бодлогыг Их Хурал тодорхойлж, Засгийн газар хэрэгжүүлэхээр бол орж өгсөн байж байгаа. Түүнээс гадна төрийн өмчит компанийн талаарх баримтлах үндсэн чиглэлийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр хэлэлцэж батлахаар орсон байж байгаа. Таны түрүүн асуусан нөгөө стратегийн ямар салбарт ямар компаниудыг байгуулах тухай асуудал бол төрийн өмчит компанийн хуулийг бол хэлэлцэх эсэхийг нь дэмжчихсэн байж байгаа шүү дээ. Энэ хууль дээр бол жил болгон Засгийн газар өргөн бариад, Их Хурал жагсаалтыг нь батлахаар төсөлд тусгаж байгаа гишүүн ээ. Тийм учраас яг ямар салбарт ямар компаниуд байх юм бэ гэдгийг бүр жагсаалтаараа Их Хурал батлах юм. Ингээд явна. Тийм учраас энэ 2 хуулийг хамтад ярьж гээд байдаг чинь ийм учиртай байхгүй юу.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Тэгэхээр яах вэ ийм санал байна. Улсын болон орон нутгийн төсвийн тэдэн хувиас илүүгүй төсвөөр төрийн болон орон нутгийн өмчит компанийг санхүүжүүлнэ. Ийм хязгаар тавьж өгөхгүй бол энэ болохгүй 1.

2 дугаарт нь зарим улс орнууд төрд стратегийн тодорхой салбарт л Төрийн өмчит компани байгуулж байгаа юм. Бусдыг нь бол үндсэндээ хувийн хэвшилд шилжүүлж байгаа.Төсөвтэй. Тэгэхгүй бол ингээд төрийн төсвөөр хийж болж байгаа юмыг хувийн хэвшил бол хийж заавал чадна. Жишээлбэл, нийтийн тохижилт үйлчилгээтэй холбоотой. Энд бас ажлын байр гарна. Тэгэхгүй бол энэ дээр тийм шинэчлэлт өөрчлөлт гарахгүй байх гэж үзэж байгаа.

2-т нь хамгийн гол нь тэр газрын хэвлийн баялгийг буюу төрийн нийтийн өмчийг ашиглаж байгаа уул уурхайн компаниуд тендерээ заавал ил зарладаг болох ёстой. Ингэж байж энэ хууль бус төрийн албан хаагчдад нөлөөлдөг энэ байдал таслан зогсоно. Энийг хуулийн төсөлд заавал тусгаж өгөөч ээ гэсэн ийм санал .../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер.

Б.Цэнгэл: Манай орон нутагт бол ерөөсөө уул уурхайн чиглэлийн 3 л компани үйл ажиллагаа явуулж байгаа шүү дээ. Баян тээх, Могойн гол, Жижиг Тавантолгой. Түрүүн бас хуулийн танилцуулга дээр хэлж байсан. Монгол Улс нэгдмэл 1 улс гэж. Тэгэхээр ер нь бол энэ дээр энэ бодлогоо бол барина. Орон нутагт бол энэ хуулиар ерөнхийдөө эрхийг бол ерөнхий нэмэгдүүлж байгаа. Багасаж байгаа юм ерөөсөө огт байхгүй. Орон нутгийн өмчийн газар Засаг даргын эрхийг шилжүүлэн аваад, тодорхой орон нутгийн өмчийнхөө асуудлуудыг шийддэг байдлаар нь оруулж байгаа. Энэ хууль Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуультай бол нэлээн авцалдуулж бас оруулж ирж байгаа ийм хууль байгаа юм гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Бадамсүрэн гишүүн 1 минут.

М.Бадамсүрэн: Үгүй ээ, би ингэж хэлээд байгаа юм. Газрын хэвлийн баялаг бол төрийн нийтийн өмч мөн. Тэгэхээр энэ баялгийг ашиглаж байгаа буюу ашиглалтын үйл ажиллагаа, олборлолтын үйл ажиллагаа явж байгаа уул уурхайн компаниуд нь газрын тосны компаниуд нь хөрөнгө оруулалтын хэлбэрээс үл хамаараад хувийн хэвшлийг бүгд ил тод нээлттэй тендерийг зарладаг болъё. Туслан гүйцэтгэх ажлаа. Энэ ЖДҮ-лэлийг дэмжих, орон нутгийн хөгжлийг дэмжих, ил тод байдлыг хангах олон талын ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

2 дугаарт нь жишээлбэл газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ гэдэг бол Монгол Улс өөрөө баялгаараа хувь эзэмшиж байгаа. Өөрөөр хэлбэл зардал гаргаж олборлоод, борлуулсан бүтээгдэхүүнээ өртөг нөхөх зардлаа хасаад, үлдсэн ашгаа хувааж байгаа. Энэ төрийн оролцоо мөн үү. Мөн. Тэгэхээр заавал 50 хувиас дээшид нь тендер зарладаг гэдэг Худалдан авахын хууль дээр байгаа зүйлийг төрийн нийтийн өмчийн хууль дээр оруулаад өгчих. Тэгвэл их олон зүйл цэгцэрнэ. Ил тод болно. Зөвхөн төрийн өмчит компани дээр биш, хувийн хэвшлийн нийтийн газрын хэвлийн баялгийг ашиглаж байгаа бүх компанид оруулж өгөөч.

Р.Сэддорж: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Хувийн хэвшлийн үйл ажиллагаа руу төр оролцоод, хуульчлаад бас байх нь зохимжгүй байх. Нэгэнтээ л бизнесийн өрсөлдөөний зарчмаар тэр хувийн хэвшлийн компаниудын үйл ажиллагааных нь зорилго бол ашиг олох. Гэхдээ Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоо мөрдөөд явах ёстой. Төрийн болон орон нутгийн өмчит компани төрийн болон орон нутгийн өмч дээр энэ үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдийг яг таны хэлж байгаагаар ил тод, нээлттэй, үр ашигтай, өрсөлдөөний тэгш шударга өрсөлдөх боломжийг хангасан зарчмыг барьж, энийг бүр зайлшгүй хуульчилж өгөөд, таны хэлж байгаа тэр шаардлагуудыг тавиад явах нь зөв. Тийм болохоор Нийтийн өмчийн тухай хууль дээр бол ерөөсөө л бас хувийн хэвшлийнхэн ашгийн төлөө явж байхад төрийн өмчит компани удирдаж байгаа хүмүүс бас тэрийгээ л бодох ёстой.

2 дугаарт нийгмийн хариуцлага байх ёстой. Энэ нь өнөөдөр байхгүй. Ерөөсөө 1 л дутуу .../минут дуусав/

Р.Сэддорж: Бямбацогт сайд гүйцээгээд хариулчих.

С.Бямбацогт: Үзэл баримтлал дээр нэлээн ажиллах шаардлага байна лээ. Одоо энэ хуулийн төсөл дээр. Ерөөсөө л энэ байгууллага чинь үр ашигтай байх ёстой. Үр ашигтай ажиллуулж чадаж байгаа компанийн захирал, төрийн өмчит компанийн захирал байх юм бол тэр хүн ажлынхаа урамшууллаа аваад, өшөө цаашаа тогтвортой, ирээдүйдээ итгэлтэй, үйл ажиллагааг нь сайн удирдаад явах ёстой. Алдагдалтай ажиллуулж байгаа, хангалттай ашигтай ажиллуулж чадахгүй байгаа бол тэр хүн хариуцлагаа хүлээгээд л явдаг байх ёстой. Өнөөдөр яаж байна гэхээр ашигтай ажиллуулсан нэр зүүчхээд, тэр компанийн өөрийн хөрөнгийнх нь 1 хувьтай тэнцэх хэмжээнд ашигтай ажиллуулчихаад л би хангалттай ашигтай ажиллуулж байгаа гээд сууж л байдаг. Өнөөдөр Монголбанкны бодлогын хүү 12 хувь байж байгаа. Хамгийн багадаа 12 хувиас доошгүй өгөөжийг хүртдэг энэ компанийг удирдах хүмүүс ийм чадвартай хүмүүсийг томилох ёстой. Ийм л хүмүүсийг уралдуулахын тулд ингэж төрийн өмчийг үр ашигтай болгохын тулд бид нар өнөөдөр энэ хуульдаа ийм зорилгод нийцсэн өөрчлөлтийг л хийх ёстой. Гэтэл энэ хууль дээрээс одоо бол харагдах.../минут дуусав/

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Сайнзориг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Би хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгэхдээ дэмжиж байгаа гэдэг нь энэ хууль төгс сайхан болсон, боловсруулсан байна гэж ерөөсөө хэлээгүй шүү. Маш олон судалгаануудыг дандаа үр дүнгүй ашигласан байна. Ийм жонхуу шиг юм орж ирсэнд харин харамсаж байна. Би уг нь бас овоо юм хийгдэж байгаа юм байна гэж ойлгоод байсан чинь. Тийм учраас гарцаагүй 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг бас амилуулах хүрээндээ энэ хуулийг бол зайлшгүй хэлэлцээд явах ёстой. Өнөөдөр яг энэ хууль суурь асуудлаа зохицуулж байгаа гэж байгаа боловч төрийн байгууллага гэж юуг хэлэх гэж байгаа юм тодорхойлолт алга. Төрийн байгууллагад яам, агентлаг хэлэх байх. Төрийн нийтийн үйлчилгээний байгууллага гэж юу хэлэх гэж байгаа юм. Орон нутгийн байгууллага гэж юу хэлэх гэж байгаа нь ерөөсөө алга. Үндсэн хууль дээр жишээ нь албан газар гэж бий. Энийг бид нар яг энэ төрийн нийтийн үйлчилгээний байгууллага орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллага гэж ойлгох гээд байх шиг байгаа юм. Энэ нь өөрөө засаглалын хувьд ямар байх юм бэ гэдэг асуудлыг хамгийн сууриараа хийх

ёстой гээд би 2016 оноос хойш л шаардаж байгаа юм. Хэн нэг дарга, цэргээс үл хамаараад ингээд байгууллагуудын засаглал энэ бүх зүйлүүдийг ийм тодорхойгүй явж болохгүй гэсэн 1 өгүүлбэр ч алга. Яг нөгөө хуучнаараа. Зүгээр даргын карманаас гарч ирсэн хүн буцаад л энэ удирдлагууд нь тавигддаг. Энэ дээр сонгон шалгаруулалт байх юм уу, байхгүй юм уу бүр юу ч алга. Тэгээд энэ чинь өөрөө эргээд төрийн албаны ангилал чинь энэ дээрээс бас шууд уялдаатай байхгүй юу. Төрийн захиргаа, төрийн тусгай энэ албанууд чинь энэ төрийн өмчит байгууллагууд буюу энэ төрийн нийтийн үйлчилгээний байгууллагуудаас ангиллаас нь хамаарна. Тэгээд ийм суурь юмнууд дээрээ уялдуулж харах хэрэгтэй байгаа юм. Тэгээд яах вэ, зүгээр өмнө нь энэ чинь нэг өргөн баригдаад, буцаж байсан. Маш олон судалгаанууд хийлээ. Бараг л батлахад бэлэн болсон хууль гээд л баахан пи ар яваад байсан. Яг эцсийн дүндээ энэ дээр чинь бол өмнөх хуулиасаа ахисан юм 1 ширхэг ч алга. Тэгээд харамсалтай байгаа байхгүй юу. Тэгж байтал суурь реформын асуудлыг болохоор энэ хууль орж ирж байж, үүнтэй хамт хэлэлцэнэ гээд төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийг бариад байгаад байдаг. Тэр хуулийг хэлэлцүүлэхгүй 6 жил боллоо шүү дээ Асуудлууд энд ужгирчхаад байхад тэрийг барьж байгаа мөртөө энэ хуультай хамт явуулна гээд байдаг. Тэгээд энэ хууль нь яг үүнтэйгээ уялдахгүй байгаа байхгүй юу. Тэгээд хар л даа. Зүгээр энэ хуульд нийцүүлсэн тухайлсан хуулиар гэдэг чинь энэ хууль бүх хашилт байхгүй юу. Энэ хашаа дотор чинь жишээ нь төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой арга замыг заачхаад, тэр дээрээ та нар өнөөдрийн хамгийн дэвшилтэт буюу хөрөнгийн зах зээлд гаргах IPO-ыг л хийгээгүй байгаа байхгүй юу. Тэгээд энэ хууль дээр маш тийм чухал ажиллах ёстой шүү. Тэгээд энийг ямар нэгэн байдлаар би бол улс төржүүлмээргүй байна. Хэлэлцэх ёстой. Энийг харин Бямбацогт сайд уужуу тайван үз гэж байгаад би баяртай байна. Ажлын хэсэг гараад явъя. Шинэчилсэн найруулга учраас тал талаас нь бас сайн ярилцаж болох байх. Тэгээд энэ зүйлүүдийг бас хэлмээр байна.

Р.Сэддорж: Ажлын алба гишүүдээ дуудъя. Санал хураалт явагдана.

Тэгээд энэ гишүүдийн хэлсэн саналуудыг та бүхэн маань сайн сонсож, мэдэж байгаа байх. Одоо ер нь 30 орчим жилийн дараа л энэ хуульдаа өөрчлөлт оруулж, хүчтэйхэн орж ирж байна гэсэн үг мөн үү. 1996 он гэдэг чинь. Тэгээд энэ иргэний эрх зүйн харилцаанд ашиглагддаг нийтийн өмч гэсэн том ойлголт байгаа. Тэгээд энэ ойлголт дээр энэ хуулиар бол төрийн болон орон нутгийн өмчийг нийтийн өмч гэж хэлээд, тэгээд энэ тодорхойгүй юмнууд байгаа юм байна шүү дээ. Сангийн өмчүүд байна, сангууд байна. Шашны өмчүүд байна, хоршооны өмчүүд, хөрөнгүүд байна. Төрийн бус байгууллагын өмчүүд байна. Тэгээд энэ юмнууд чинь бол яг гишүүдэд тодорхойгүй байгаа юм биш үү гэсэн гишүүдээс олон саналууд ирж байна. Тэгээд яах вэ, орон нутгийн эрх мэдлийг багасгахгүй гэж бас хэлж байна. Сая Цэнгэл дарга хэллээ. Тэгээд өөрөө өөрийгөө авч явж байгаа аймаг, сумдууд тэгээд ашиг олж болоод байгаа тэр газруудыг дэмжиж байгаа байлгүй дээ энэ хууль. Дээрээс нь Халзан бүргэдэйн сонсгол явуулах эсэх талаар санал хураалт 2 Байнгын хороо сонсгол явуулах ийм цаг хугацааг томилох гэж байна. Тэгэхээр энэ орон нутаг нь уул уурхайгаа дэмжсэн аймгуудыг түрүүлж хөгжихөд нь, түрүүлж ч юм уу арай илүү тэр дэмжиж байгаа хэрээр нь хөгжих тэр боломж бололцоо энэ хуулиар нээгдэж байгаа байлгүй гэж найдаж байна. Тэгээд энэ дээр ажлын хэсгийн гишүүдэд энийг албан ёсоор зориуд хэлье. Тэгээд энэ аймгууд чинь бол жишээ нь Ховд аймаг яаж хөгжихөө мэдэхгүй байгаа шүү дээ. Энэ Халзан бүргэдэйгээс яг 10 жилийн дараа Ховд аймаг ямархуу хөгжих гээд байгаагаа л ард түмэнд тодорхой хууль, эрх зүйн

юугаараа л тодорхой болгочихвол иргэдийг бол дэмжихэд бэлэн байгаа байх гэж бодож байгаа юм.

Тэгээд аймаг болгонд ийм өөр өөрийн онцлогтой орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд байгуулаад хөгжчих тийм ашигт малтмалууд байгаа шүү дээ. Тэгээд аймгийн хяналт гэдэг бол маш чухал. Тэр хавьдаа л супер. Засгийн газраас илүү хянаана. Маш сайн хянадаг. Тэгээд орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг энд сайн дэмжиж өгөөрэй гэдгийг бас хэлье. Тэгээд их зах замбараагүйдээ биш, ямар ч байсан тэр орон нутаг, аймаг орон нутгаа аваад явчихдаг тэр бүтэц бололцоог нь та бүхэн маань сайн мэдэж байгаа байлгүй дээ. Тэгээд энэ дээр ингэж хэлье.

Санал хураалтыг нэгдсэн байдлаар явуулъя. Дараагийн үлдсэн асуудлууд санал хураалттай учраас ингээд гишүүдийг нэмэгдэж, хуралдаа оролцохыг хүсэж байна.

18.00 цаг.

Хэлэлцэх асуудал 5.

Монголбанкны бүтцийн талаар Монголбанкны мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэнг мэдээллээ танилцуулахыг урьж байна. 3 номер.

Б.Лхагвасүрэн: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Тэгээд өнөөдрийн Байнгын хорооны хурал дээр Монголбанкны бүтэц, орон тооны талаар танилцуулга хийхээр бэлдсэн байгаа. Ер нь бол танилцуулгыг PDF-ээр бэлдчихсэн байгаа. Тэгэхдээ бас цаасаар та бүхэнд тараачихсан байгаа. Би энэ цаасныхаа дагуу танилцуулгаа хийчихье.

Монголбанк 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар 13 газар, 1 төв, 1 хүрээлэн, 3 бие даасан алба, орон нутаг дахь 5 хэлтэс, 12 салбар, 2 төлөөлөгчийн газартай үйл ажиллагаа явуулж байна. Төв банкны аппаратад 574, орон нутагт 123 орон тоо байгаа. Нийтдээ 697 орон тоо батлагдсан. Гэхдээ өнөөдрийн байдлаар бол 641 хүн ажиллаж байна.

Та бүхэнд тараагдсан материалаас бол 639 гэж байж байгаа байх. Танилцуулга уг бол явж байвал манай бүх газар хэлтсээрээ хэчнээн орон тоотой ажиллаж байгаа нь бол байгаа. Хяналт шалгалтын газар, Эрсдэлийн удирдлагын газар, Мөнгөн тэмдэгтийн газар, Зөвшөөрлийн алба, Зээлийн мэдээллийн алба, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар гээд бүх газар хэлтсүүдээр нарийн мэдээлэл нь ингээд хуваагдаад явж байгаа.

Мөн өнөөдөр ажиллаж байгаагаас бас хүүхэд асрах чөлөө, гадаадад оюутан суралцаж ажиллаж байгаа бас ийм чөлөөтэй орон тоонууд байна. Хүүхэд асрах чөлөөтэй 26, гадаадад суралцаж байгаа 35 ийм ажилтан байгаа.

Мөн дараагийн хүснэгтээс та бүхэн Монголбанкны хүйсийн харьцааг бас харж болно. Нийт өнөөдөр Монголбанканд ажиллаж байгаа 627 ажилтны төвд байгаа 521-ийг үзэх юм бол 262 буюу 50,3 хувь нь эрэгтэй, 259 буюу 49,7 хувь нь эмэгтэй. Орон нутагт ажиллаж байгаа 118 ажилтны 60 нь эрэгтэй энэ бол 50,8 хувь, 58 нь эмэгтэй энэ нь 49,2 хувь болж байгаа. Жендерийн хувьд бол нэлээн ийм тэгш харьцаатай байгаа.

Монголбанкны ажилтнуудыг ажилласан жилээр нь өнөөдрийг хүртэл авч үзэх юм бол нэлээн ийм залуужсан байгаа. 0-5 жил буюу 5 жил хүртэл ажилласан ажилтнууд бол нийт ажилтны 41,2 хувь буюу 257 ажилтан байна. 6-10 жил ажиллаж байгаа ажилтан 129 буюу нийт ажилтны 20,7 хувь, дараа нь 11-15 жил ажиллаж байгаа 107 ажилтан энэ бол нийт ажилтны 17 хувь, 16-20 жил ажиллаж байгаа 65 ажилтан энэ бол нийт ажилтны 10,4 хувь, 21-25 жил ажиллаж байгаа 36 ажилтан энэ бол нийт ажилтны 5,8 хувь, 26-аас дээш жил ажиллаж байгаа 30 ажилтан энэ бол нийт ажилтны 4,8 хувь байгаа. Эндээс ингээд тооцоолоод үзэх юм бол ерөнхийдөө Монголбанкны ажилтны дундаж нас бол 40 хүрэхгүй байгаа. 38 орчим. Нийт ажилласан жил нь бол 11 жилтэй дундаж жил нь.

Орон нутагт бол бас үүнтэй төстэй байгаа. Нийт ажиллагсдын дундаж нь бол 40 жоохон гаруй байгаа. Нийт ажиллаж байгаа жил нь бол ерөнхийдөө 10 орчим жилтэй ийм байгаа.

Монголбанкны ажилтнуудын мэргэжил, мэргэжлийн зэрэг, сургалт хөгжүүлэлтийн талаар мэдээллийг та бүхэнд бас тараасан байгаа. Нийт ажилтны 260 ажилтан нь бол төв дээрээ бакалавр, орон нутагт бол 68 ажилтан бакалаврын зэрэгтэй. Нийт ажилтны 178 нь төв дээрээ магистр, 23 ажилтан орон нутагт магистрын зэрэгтэй. Мөн докторын зэрэгтэй төв дээрээ 8 ажилтан. Ер нь бол бүрэн дунд болон бүрэн бус дунд боловсролтой ажилтнууд бол их цөөхөн ажилладаг.

Ер нь бол мэдээж банкны ажилтнуудыг энэ орчин үеийнх нь техник технологи болон орчин үеийн энэ чиг хандлагатай нь нийцүүлж богино хугацааны гадаадын ОУВС, Дэлхийн банк, АХБ, мөн хамтын ажиллагаатай бусад төв банкнуудын хамтын ажиллагааны хүрээнд бас гадагшаа байнга 7 хоногоор бол мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулдаг. Ингээд хамгийн сүүлийн өнгөрсөн онд бол 2024 онд 265 ажилтан богино хугацааны сургалтад, 21 ажилтан урт хугацааны сургалт нь гадаадад хамрагдсан байгаа.

Мэдээж мэргэжлээрээ бол нэлээн олон ялгаатай байгаа. Эдийн засагч мэргэжил бол нийт ажилтны 117 нь эдийн засагч, 106 нь бизнесийн удирдлагын, 63 нь нягтлан бодогч, 42 санхүүгийн ажилтан гээд та бүхэнд бол мэдээлэл бол нэлээн дэлгэрэнгүй тараагдсан байгаа байх.

Би тэгээд та бүхний тодорхой нарийн асуултад бас хариулъя.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Пүрэвсүрэн Монголбанкны Тамгын газрын захирал, Ууганбаатар Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, Энхжаргал Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн, Эрдэнэбаяр Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн, Мөнх-Ундарга Монголбанкны Санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал.

Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Найдалаа гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Нэлээн дэлгэрэнгүй орон тоо, бүтцийнхээ талаар мэдээллийг ирүүлсэн байна. Баярлалаа. Ер нь Монголбанкны үйл ажиллагаанд бол сэтгэл хангалуун байдаг. Засгийн газрын уг нь нөлөөгүй байх ёстой. Улс төрөөс нөлөөгүй байх ёстой. Тэр талаа бас хангаж чадахгүй байгаа тал байгаа болов уу гэж хувь хүний хувьд бол боддог юм. Тэгээд бүтэц, орон тоог бол ойлголоо. Тэгээд энэ бүтцийн хувьд газруудын үнэлгээ гэх юм уу, ажлын үр дүн гэдгийг нь яаж үнэлдэг юм бол. Ямар аргачлалаар та хэд маань үнэлж байгаа вэ. Цаашдаа энэ газар орон тоо болгоноороо хаана, хэн нь юугаа хариуцаад, ямар үр дүн гаргасан бэ гэдэг зүйл нь яаж явдаг юм бол гэсэн ерөнхий үнэлгээний аргачлалын талаар асууя.

2 дугаарх нь болохоор Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаас асууя. Та бүхэн минь бүтэц орон тоон дээр дүгнэлт, үйл ажиллагааны тухай хийгээд ирүүлсэн байна. 4 сарын 1-ний өдөр та бүхнийг томилох хурал дээр би та бүхнээс асууж байсан. Үйл ажиллагааны төлөвлөгөө бол жилийн төлөвлөгөө байдаг. Дунд хугацааны төлөвлөгөөг үр дүнд суурилсан байдлаар боловсруулаад та хэд маань Эдийн засгийн байнгын хороо дээр өргөн бариач ээ гээд бичиг очсон болов уу гэж бодож байна. Энэ ажлын явц хэр байгаа вэ. Монголбанк сая хэлсэн өөрсдийгөө үнэлэх дотооддоо үнэлгээний аргачлал байх ёстой. Хяналтын зөвлөлөөс бас тухайн үнэлгээний аргачлалыг нь яаж хийж байгаа вэ гэдэг дээр нь хяналт тавиад, үр дүнд хүрэх нь гол зорилго байгаа учраас та бүхэн маань энэ дээр яаж төлөвлөгөө гаргасан бэ. Энэ төлөвлөгөө хэр явцтай байгаа вэ гэсэн асуулт.

Тэгээд буцаад Монголбанкнаас асууя. Ногоон санхүүжилтийн тогтолцоо дээр бас бий болох хэрэгтэй. Та хэд маань энэ тайлан дээрээ байна. Цахим валют гэх юм уу, тийм зүйлүүд бас судалж байгаа гэсэн зүйл байгаа. Ногоон санхүүжилтийн ногоон таксономын журам гэж боловсруулаад батлагдсан байгаа. Одоо та бүхэн маань Тогтвортой хөгжлийн журам гэж бас боловсруулж байгаа гэж сонссон. Энэ ажил маань хэр явцтай байгаа вэ. Тэгээд Улсын Их Хурлын даргын 85 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийг би ахалж ажиллаад, та бүхэнд 5 чиглэлийг өгсөн. Энэ дээр мэдээлэл очсон байгаа юу. Ер нь бэлтгэл ажил хэр хангагдаж байгаа вэ гэсэн 3 асуулт байна.

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Лхагвасүрэн: Асуултад хариулъя. Монголбанк бол яг төв банкны тухай хуулиар бол Монголбанк үндсэн зорилго нь бол үнийн тогтвортой байдал буюу мөнгөний бодлого байгаа. Тэгэхээр яг мөнгөний бодлого, мөнгөний бодлогыг дэмжих ийм хамт судалгааны газар, Санхүүгийн тогтвортой байдлын алба гэсэн ийм бүлэг цогцоороо 1 хэсэг байгаа. Мөн санхүүгийн тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлнэ гэсэн дараагийн зорилтын хүрээнд мөн Хяналт шалгалтын газар байж байгаа. Тэгээд үндсэн чиг үүрэг. Тэгээд Хяналт шалгалтын газар маань өөрөө дотроо яг газар дээр хяналт шалгалт хийдэг газраас гадна энэ хяналт шалгалттай холбоотой, санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой бодлого зохицуулалтыг хийдэг Банкны бодлого, бүтцийн өөрчлөлтийн газар гэсэн 2 томоохон газар бас байж байгаа. 3 дахь нь бол бас Төв банкны тухай хууль дээр байгаа. Монгол Улсад төлбөр тооцоог зохион байгуулах гэсэн үүрэг байгаа. Энэ үүргийн дагуу Төлбөр тооцооны газар, Мэдээлэл технологийн газар, Цахим гүйлгээний төв гэсэн ийм 3 бас үндсэн нэгж энэ дээр үйл ажиллагаагаа

явуулж байгаа. 4 дэх нь бол мэдээж ханшийн тогтвортой байдлыг хангах, ялангуяа ханш бол өөрөө хөвдөг ажилладаг гэдэг утгаараа Санхүүгийн зах зээлийн газар энэ дээр бол гол чиг үүрэгтэй. Тэгэхээр үндсэн чиг үүргээрээ энэ гол гол газрууд байгаа. Энэ гол газруудад хажуугаас нь хууль зүйн талаас нь зөвлөгөө өгөхөөр хамтран ажиллахаар Хууль, эрх зүйн газар, мөн Мэдээллийн технологийн газар нь мэдээж судалгаагаа бас мэдээллийн технологийн автоматжуулалтынхаа хэсгийг бас дэмжээд явна. Мөн Судалгаа, статистикийн газар бас энэ дээр нь хөндлөнгөөс нь дэмжлэг үзүүлээд явдаг. Тэгэхлээр, Тамгын газар бол мэдээж хүний нөөцийн бодлого энэ бүх юмаар бас дэмжлэг үзүүлэхээр. Тэгэхээр үндсэн босоо тэнхлэгийн 4 газар, хажуугаас нь хөндлөнгөөс нь дэмжлэг үзүүлэх ингээд бусад газруудад нь дэмжлэг үзүүлж явж байгаа юм. Тэгэхээр эдгээр газруудын үйл ажиллагааг нь яг макро эдийн засгийнхаа өнөөдрийн орчинтой нь нийцүүлээд улирлаар болон хагас жилээр дүнгээ гаргаад явдаг. Тэгэхээр өнөөдөр аль хэсэг дээрээ хаана, ямар ямар асуудал нь Монголбанкнаас хамааралтай юм уу, эсвэл Монголбанкнаас хамааралгүй байна гэдгээр дүнгээ гаргаад явдаг. Тэгэхээр хамгийн өндөр оноог нь 100 баллын системээр дүгнэж байгаа юм. Тэгэхээр бол ерөнхийдөө 100 балл байвал тухайн газар хамгийн сайн ажил хийж байна. 90 хувь руу гэх юм бол доошийгоо хаана хаана, ямар зорилго нь биелэгдээгүй буюу хагас биелж байгаа эсвэл тодорхой хэмжээнд зогсонги байдалд орчихсон гэдгээр ингээд дүнгээ гаргаад явж байгаа. Тэгэхээр ийм маягаар үнэлгээгээ хийгээд явж байгаа.

Таны дараагийн асуултад Монголбанк, Банкны холбоо банкнуудтайгаа хамтраад ногоон таксономыг 2019 онд бол анх гаргаж ирж, хэрэгжүүлж явж байгаа. Дараа нь ногоон таксономын маань НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлээд НҮБ-ын Тогтвортой тогтвортой санхүүжилтийн, үндэсний .../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Тэгээд Үндэсний газрын зураг бас рөүд мапыг хийсэн. тэгээд яг таны асууж байгаа асуултын хүрээнд бол Монголбанк өөрөө бодлогын хувьд бас ногоон санхүүжилт, ногоон хөгжлийг, ногоон шилжилтийг дэмжих тал руу бодлого зохицуулалтаа хийгээд явж байна. Тэгэхлээр своп хэлцэл буюу ногоон бондоор босож ир гэсэн гадаад эх үүсвэрийг төгрөгийн эх үүсвэрээр санхүүжүүлэхэд свопын зардлыг 1 нэгж хувиар доошлон бууруулаад явж байгаа. Тэгэхээр энэ маань өөрөө Төв банкны зүгээс үзүүлж болох хамгийн бодит дэмжлэг энэ гэж харж байгаа.

Р.Сэддорж: 5 номер нэмж хариулах юм уу. 5 номер.

Н.Ууганбаатар: Гишүүний асуултад хариулъя. Бидний өмнө ирэхэд үзүүлсэн төлөвлөлтийг бол үр дүнд суурилсан байдлаар дахин хийж ирэх ийм санал тавьсан. Бид энэ саналыг хүлээж авсан. Туршиж үзсэн. Тэгээд туршиж үзэхээр бид нар нөгөө хэрэгжүүлэлтэд суурилсан төлөвлөлт хийгээд сурчихсан, арга барил маань тийшээ явчихсан учраас шууд үр дүнд суурилсан төлөвлөлт рүү шилжинэ гэхээр хүмүүсийн гаргадаг нийтлэг алдааг бид нар бас гаргасан. Тэр нь юу байх вэ гэхээр гарцыгаа бид нар дандаа үр дүн гэж ялгаж үздэггүй, үр дүн гээд томьёолчихдог. Тэгээд бид нар тийм туршилт хийчхээд, гарсан бүтээгдэхүүн маань тиймэрхүү болчхонгуут энэ дээр бид нар дахиад илүү нарийвчилж судлах шаардлагатай юм байна. Энд суралцах хэрэгтэй юм байна гээд түр зуур хойшилчихсон. Энэ дээр бол ажлын хэсэг байгуулчихсан ажиллаж байгаа юм.

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүн тодруулж асууна.

Г.Лувсанжамц: Хяналтын зөвлөлд баярлалаа. Ямар ч байсан ажил явж байгаа юм байна. Та хэддээ амжилт хүсье. Бас таны хэлснээр яг тэгж шууд шилжихэд бас хүндрэлтэй талууд байдаг болохоор цаашдаа бас трайланд эрор хэлбэрээр явчих болов уу гэж бодож байна. Амжилт хүсье.

Монгол банкнаас сая та үнэлгээг улирал болон хагас жилээр 100 баллаар үнэлж байгаа гэсэн. Ер нь сүүлийн 2 жил ч юм уу эсвэл энэ жил ч байдаг юм уу та хэд маань Монголбанк тэр чигээрээ 100 баллаар үнэлэхэд ер нь хэдэн баллын оноо гарсан бэ. Тэгээд Road map гарсан гэж Ногоон таксономын тогтвортой санхүүжилтийн road map гарсан гэж байна. Тэр дээрээ ажлаа хийгээд дахиад боловсруулж байгаа гэсэн үе шат тийм үү. Тэр дээр нь бас боломжтой бол мэдээллүүд бас авах сонирхолтой байна.

Р.Сэддорж: Лхагвасүрэн Ерөнхийлөгч 3 номер.

Б.Лхагвасүрэн: Лувсанжамц гишүүний асуултад дэлгэрүүлж хариулья. Ер нь бол дундаж нь 91-92 хувьтай явж байгаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Найдалаа.

Б.Найдалаа: Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох талаар ярьж байгаа нь зөв гэж бодож байна. Энэ бол чухал асуудал. Харин зүгээр бид нар энэ дээр онцолж юм хэлмээр юм байгаа юм. Зөвхөн энэ удаагийн энэ тогтоолын төсөлдөө Монголбанкны бүтцийг орон тоог нь цөөрүүлэгчийн бүтцийг оновчтой болгох гэсэн тодорхой заачихсан тогтоолын төсөлтэй холбоотой биш. Зөвхөн үүнтэй холбоотой биш, ерөнхийд нь бас зарчмын юм хэлэхгүй бол болохгүй санагдаад байна.

Тэгэхээр Монголбанкны үндсэн үүрэг бол төрийн мөнгөний бодлогыг барих, төгрөгийн тогтвортой байдлыг хангах байгаа. Тэгээд Монголбанк хараат бус байх ёстой. Хараат бус. г хуулиараа жишээлбэл, Засгийн газраас ч байна уу, Ерөнхий сайд дээр дуудагдаад ялангуяа очиж мэдээлэл өгөх ч юм уу, эсвэл аль нэг сайд нь өөрийнхөө бодлоготой холбогдуулаад Монголбанкны ажилтай хэт хутгалдаад байгаа нь хараат бус байдлыг алдагдуулаад байна л даа. Жишээлбэл мөнгөний бодлого явуулахын тулд зарим зээлийг хязгаарлаж болно шүү дээ. Шимтгэлийг нь нэмж болно, хасаж болно, бодлогын хүүг нэмж болно, хасаж болно, тэрийг хэнээс ч хараат бусаар хийгээрэй гээд Монголбанкны хараат бус байдлыг гэж хуульд зааж байгаа. Тэгэхээр энэ бол үнэнийг хэлэхэд сүүлдээ бол алдагдаад байна. Тэгээд Засгийн газартай холбоотой тийм асуудал үүсэж байна.

Дээр нь Их Хурлын харьяа байгууллага гэж байгаа болохоос биш, хараат бус байлгаарай гээд Их Хуралд харьяалуулсан болохоос биш Их Хурал удирдаарай гэж Монголбанкныг өгөөгүй байхгүй юу. Санхүүгийн зохицуулах хороо, бусад Их Хурлын харьяа байгууллагууд. Тэгээд заримдаа ялангуяа энэ дээр гишүүд, зарим Байнгын хороод ер нь жоохон хэтрээд байна л даа. Яг удирдаж байгаа юм шиг авч хэлэлцээд, яг одоо энэ бүтэц, зохион байгуулалтын тухай тогтоол гарч байна. Энийг би бол эргэлзэж байна. Бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоод багасгах нь зөв. Харин яг багасга, бууруул гэж зааж байгаа нь өөрөө хуульд нийцэх үү. Байнгын хорооны гишүүд бодож үзээрэй. Төв банкны тухай хуулийн 28.6 ч байна уу зүйл дээр төв банкны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийнх нь 1 ажил нь удирдлага зохион байгуулалтаа өөрийнхөө зорилгодоо нийцүүлээд тогтоох байхгүй юу. Бид нар тэгэхэд тэр бүрэн эрхтнээ халдаад, одоо наадхаа цөөрүүл, олшруул, багасга, нэм,

хас гэж байгаа нь буруу байгаад байгаа юм. Мөнгөний бодлогын хүүг жишээлбэл бууруулчихлаа гэхэд, нэмчихлээ гэхэд наадах чинь буруу байна. Алив жоохон нэм, хас, эсвэл зээлийн хүүгийн тэр шимтгэлээ хас, бууруул гэж байгаатай адилхан зүйл болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр Их Хурлаас, Байнгын хорооноос иймэрхүү хууль зөрчсөн маягийн хараат бус байдалд халдсан ийм жишиг тогтоочих вий гэж санаа зовж байна л даа. Тэгэхээр зүгээр энэ дээр Монголбанкныхан маань ч гэсэндээ бас зарчмын юман дээр жоохон зоригтой, чанга дуугарч байхгүй бол захын гишүүн ч юм уу, захын байгууллага ямар нэгэн мэдээлэл хэтрүүлж шаарддаг. Мэдээлэл авлаа. Тэр бол болж байна. Дээр нь нэмээд ямар нэгэн үйлдэл хийхийг бүрэн эрхэд халдсан шийдвэр гаргахыг шаарддаг байж болохгүй гэж бодож байна. Тэгээд цаашдаа яг хараат бус байлгахын тулд ялангуяа Их Хурал, ялангуяа энэ Эдийн засгийн байнгын хороо сайн анхаарахгүй бол болохгүй нь. Тийм болохоор яг эрх зүйн талаас нь саяынхыг би шалгаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Би бол Эдийн засгийн байнгын хорооны эрх үүргийн хүрээнд Монголбанкны бүтэц, орон тоотой танилцаж байна, үйл ажиллагаагаа яаж зохион байгуулж байгаа юм бэ гэж ойлгож байгаа. Тийм учраас бас Монголбанкны Хяналтын зөвлөлийн тайлан гарсан байна. Одоо яах вэ, ингээд бүтэц дээр 697 батлагдсан орон тоотой гээд. Тэгэнгүүт ер нь Хадгаламжийн даатгалын корпорац гээд байгаа. Хадгаламж эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаална гээд тусдаа компани. Тэр хадгаламжийн даатгалын корпорац дээр бол ер нь бас арилжааны банкнууд дээр хяналт шалгалт үүрэг бүхий бас газар хэлтэс байгаа. Монголбанк маань өөрөө хяналт шалгалтын газартай. Ингээд бодоод үзэхээр 1 асуулт байгаад байна.

Хадгаламжийн даатгалын корпорац маань хэдэн хүнтэй болчихоод байгаа юм бэ гэдэг асуулт байгаад байхгүй юу. Энийг бол Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч удирдаж байгаа байх. Энэ талаар мэдээлэл авмаар байна.

2-т болохоор бол энэ татан буугдсан банкнуудын эрх хүлээн авагчид бол яг Монголбанкны харьяанд байгаад байна уу, эсвэл тэр тусдаа компанийн харьяанд яваад байна уу гэдэг нэг ийм асуулт байгаа.

3-д болохоор бол Монголбанкны санхүүгийн тайланг уншихаар үнэт цаасны санхүүжилтийн корпорац гээд бас нэг тусдаа компани байгаад байгаа. Тэр компани болохоор өөрөө бонд гаргаад, өөрөө тусдаа үл хөдлөх хөрөнгө худалдаж аваад, өөрийнхөө өр барагдуулахтай холбоотой хөрөнгүүдээ арилжаанд оруулах гээд ингээд бас хөрөнгө босгочихсон нэг ийм үйл ажиллагаа яваад байдаг. Энэ компанийн талаар мэдээлэл өгөөч гэдэг.

4 дүгээрт болохоор бол Монголбанк маань бол ер нь маш их үл хөдлөх хөрөнгө цуглуулж байна. Монголбанкныг тойроод байгаа бүх байшингаа өөрөө ингээд эзэмшээд эхэлчихлээ. Гэтэл энэ өр барагдуулах албаны компанид зориулаад үйлдвэрчний эвлэлийн ордноос байраа худалдаж авах хэрэгцээ шаардлага зайлшгүй байсан уу гээд ингээд иймэрхүү асуултууд байгаад байна л даа. Эдгээр асуултад хариулт авъя.

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Лхагвасүрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө арилжааны банкныг төлбөрийн чадваргүй болж татан буулгахад өнөөдөр бол манай

хууль, эрх зүйн орчны хувьд бол Монголбанк энэ ажлыг хийж байгаа. Шүүхээр бол арилжааны банкныг төлбөрийн чадваргүй боллоо, татан буулгалаа, хэрэг гүйцэтгэгч томиллоо гэдэг ийм шийдвэр гарахгүй байгаа юм. Дампуурлын хуулиар бол энэ арилжааны банкны дампуурал бол зохицуулагдахгүй байгаа юм. Тэгэхээр Монголбанкны Банкны тухай хуулиар энэ харилцаа зохицуулагдаж байгаа учраас татан буугдаж байгаа арилжааны банк дээр бол эрх хүлээн авагчийг томилдог. Эрх хүлээн авагч бол мэдээж өр авлагыг барагдуулах, ялангуяа банкны харилцагчийн төлбөр тооцоог нь түргэн шуурхай барагдуулахад ажиллаж байгаа. Тэр утгаараа өнөөдөр эрх хүлээн авагч бол Хадгаламжийн банкны эрх хүлээн авагч, Зоос банк дээр байгаа эрх хүлээн авагч, хамгийн сүүлд бас татан буугдсан Капитал банк дээр эрх хүлээн авах үйл ажиллагаа явуулаад, тус бүр дээр нь эрх хүлээн авагч ажиллаж байна. Зарим банк дээр эрх хүлээн авагчийн баг ажиллаж байгаа. Зарим банк дээр ганцхан эрх хүлээн авагч гэж ажиллаж байгаа. Мэдээж эрх хүлээн авагч өөрийнхөө зардал, үйл ажиллагааны зардал, орлогыг бол өөрөө удирдаж явахаар хуулийн зохицуулалттай. Тэр утгаараа өнөөдөр таны асууж байгаа тэр Үнэт цаасны компани бол Хадгаламжийн банкны эрх хүлээн авагчийн доор ажиллаж байгаа.

Яг өнөөдөр бас Монгол Улсад энэ актив хөрөнгийг удирдаж, муу активыг хурдан борлуулах энэ үйл ажиллагаа нь хууль, эрх зүйн бас зохицуулалтгүй байгаа. Активын удирдлагын компанийн тухай хууль бол төсөл нь Их Хуралд өргөн баригдаж байсан ч гэсэн энэ бол өнөөдөр батлагдаж гарч ирээгүй байгаа нэг ийм хуулийн төсөл явж байдаг. Яг ийм хууль, эрх зүйн орчин байхгүй тохиолдолд ялангуяа тэр эрх хүлээн авагчийн доор байгаа активын удирдлагын үнэт цаасны компани бол муу активыг аваад, үнэт цаасжуулаад эдийн засгийн эргэлтэд оруулж, өр авлагыг барагдуулахад энэ өнөөдөр байгаа хууль, эрх зүйн орчинд нь зохицож ажиллаж байгаа хэлбэр гэж төв банкны зүгээс харж байгаа. Тэр ч утгаараа Хадгаламжийн банктэй холбоотой бас нэлээн олон өр авлага бас барагдаад явж байгаа. Үйлдвэрчний эвлэлийн ордны ард талд байгаа тэр байшинд бас Монголбанкны өр авлагын хүрээнд бас үл хөдлөх хөрөнгө хураагдаж ирдэг. Тэгээд Худалдаа Хөгжлийн банктэй хийсэн төлбөр тооцоотой асуудлаар бас тодорхой үл хөдлөх хөрөнгүүд хураагдаж ирсэн. Мэдээж дуудлага худалдаагаар бол хуулийн дагуу бол зарах гэж хэд хэдэн дуудлага худалдаа хийдэг боловч тухайн дуудлага худалдаа дээр бол нөгөө хураагдсан үнийн дүнгээсээ доошоо буурах эрсдэлтэй байдаг учраас Төв банкны зүгээс бол энийг яг үнийн дүнгээр нь худалдан борлуулах, үнийн дүнгээс нь бууруулахгүй байхаар ипотекийн зээл биш бизнесийн моргеж маягаар бол компаниудад тодорхой хугацаанд өр төлбөрийг нь төлөхөөр бас гэрээ .../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар. 4 номер нэмж хариулъя.

Г.Энхтайван: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Хадгаламжийн даатгалын корпорац нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Арилжааны банкны активд бол бас актив болон пассив дээр хяналт шалгалт явуулах тийм зохицуулалттай болсон. Сүүлд орсон хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр. Яг одоогийн байдлаар Үндэсний хорооны дэргэдэх аудитын байгууллагын хороог оролцуулаад 62 хүн Хадгаламжийн даатгалын корпорацад ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд сүүлийн үед төсвийн асуудал дагаж орж ирээд, Монголбанкны асуудал бас нэлээн яригдчих шиг

боллоо. Орон тоог нь цөөлнө, үр ашигтай ажиллуулна энэ тэр гээд. Тэгэхдээ ер нь Монголбанк дээр 500 хүн ажиллаж байхад бол энэ төсвөөс санхүүжээд байдаг байгууллага өөрөө биш. Энэ тийм олон хүн байгаад байгаадаа ч бас биш. Энэ чинь бол өөрөө тогтолцоо, үүрэг хариуцлагын байгууллага. Монгол Улсад нийтдээ 42 их наяд төгрөгийн хадгаламжийг зохицуулж явж байгаа зохицуулагч, 5 тэрбум долларыг удирдаж байгаа бас санхүүгийн мэргэшсэн хүмүүс, юу гэдэг юм тэр мөнгө угаах гэдэг юм уу, терроризмыг санхүүжүүлэхгүй байх гэдэг дээр ажиллаж байгаа ийм нарийн мэргэжлийн илүү олон талын олон улсын түвшинд хамтын ажиллагаагаа шаарддаг өндөр чадамжтай ийм тогтолцоо энэ бол хүний тоог хасъя, бууруулъя гээд хасаад бууруулаад хийчихдэг байгууллага бол биш гэж би энэ Монголбанкыг өмөөрч бас хэлэх гээд байгаа юм. Тэгээд сая бас зарим гишүүдээс гарч ирж байна. Соронзонболд гишүүн энэ тэрнээс Хадгаламжийн даатгалын корпорацтай холбоотой үйл ажиллагааны талаар гээд. Монголбанкны тухай хуулийн 19 дээр зүйлийн хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилтэд нь хяналт тавина л гэж байгаа юм Монголбанк.

Тэгтэл нь манай Тэргүүн дэд ерөнхийлөгч маань ажлаа өгч яваад, бараг 2 жил болчихож байна уу. Тэгээд энэ Хадгаламжийн даатгалын корпорацын үйл ажиллагаа, би өөрөө тэр дотор ажиллаж байсан хүн учраас зориуд хэлэх гэж орж ирээд байгаа юм. Корпорацын удирдах байгууллага нь Банкн дахь мөнгөн хадгаламжийн тухай хууль дээр байгаа юм. Хадгаламжийн даатгалын үндэсний хороо байна гэж байгаа юм. Тэгээд Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга. Тэгээд Үндэсний хорооны даргын эзгүйд түүний үүргийг Үндэсний хорооны даргын томилсон аль нэг гишүүн гүйцэтгэх бөгөөд Үндэсний хорооны даргын үүрэг гүйцэтгэж байгаа гишүүн Үндэсний хорооны даргаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ. Тэгтэл энэ Дэд ерөнхийлөгч өөрөө хууль дээр байхгүй ийм ажил барьж авч хийгээд байгаа юм. Эдийн засгийн байнгын хорооноос гарсан тогтоол бол Тэргүүн дэд ерөнхийлөгчийг Дэд ерөнхийлөгч орлоно гэсэн хуулийг өөрчлөх хэмжээний тогтоол бас гараагүй. Тэгээд зарим гишүүд дээр болохоор бас Ерөнхийлөгч болоорой энэ тэр гээд ...1 минут нэмж авч болох уу дарга аа.

Р.Сэддорж: 1 минут Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Зарим гишүүд дээр болохоор Ерөнхийлөгч болоорой энэ тэр гэдэг үг хэлүүлээд, надад бол жоохон зарчимгүй санагдсан. Яг таны хажууд Монголбанкны Ерөнхийлөгч өөрөө ажлаа хийгээд сууж байна. Тэгээд юу гэдэг юм, 1 том даргын хамаарал бүхий хүмүүс гэхээрээ албан тушаал, халаа сэлгээ яригдах болгонд л өшөө дээшээ явна гэж байдаг Монголбанканд хэдэн хунтайж шиг хүмүүс байдаг. Тэгэхээр тэр хүмүүсийг нэр устай нь бас зарлаад яах вэ. Дараа нь болохгүй бол ярих цаг ирэх байх. Тэгээд Дэд ерөнхийлөгч сая энэ хуурамч дипломын асуудлаар 120 сая төгрөгийн асуудал үүсээд, 1 хүн амиа егүүтгэчихсэн. Гэтэл хуулиар олгоогүй эрхийг хэрэгжүүлээд, тэнчээнээс бас цалин авч байгаа байх. Тэгээд яг урдах урдах ажлаа хийхгүйгээр, илүү дутуу ажил руу орохгүй байвал зүгээр байна л гэдэг ийм санал хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: 4 номер.

Г.Энхтайван: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын гишүүдийн Улсын Их Хурлын Байнгын хороо дээр хэлсэн асуудал дээр бол би

тайлбар хэлмээргүй байна. Гишүүн тэр өөрөө тухайн тайлбар хэлсэн гишүүнээсээ асууж тодруулах нь таны бүрэн эрх. Та энэ дээр өөрөө тэр тухайн хүнээс асуугаарай.

Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4-д Тэргүүн дэд ерөнхийлөгчийн эзгүйд Дэд ерөнхийлөгч орлоно гэсэн Төв банкны тухай хуулийн заалттай. Яг энэ хуулийн заалтын дагуу Эдийн засгийн байнгын хороо тогтоол гаргасан гэж ойлгосон. 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр Сэддорж даргын гарын үсэгтэй Эдийн засгийн байнгын хорооны тодруулга хүргүүлэх тухай албан бичиг ирсэн. Энэ дээр ч гэсэн Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Тэргүүн дэд ерөнхийлөгчийн эзгүйд Дэд ерөнхийлөгчид үүрэгт ажлыг түр орлон гүйцэтгэхээр заасан тухай энэ албан бичигт бол ирүүлсэн байгаа. Таныг Эдийн засгийн байнгын хорооноос гарсан аливаа бичиг шийдвэртэй танилцаж байхыг хүсье.

Р.Сэддорж: Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Да.Цогтбаатар: Уг нь бол би сая санал хэлсэн юм. Асуулт асуугаагүй юм л даа. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайдтай ойр, хамаарал бүхий гэхээр бүр гишүүдээ загнаад сууж байдаг тийм аймар бүрэн эрхтэй гэж таныг бол бодсонгүй. Би зүгээр зарчмын шаардлага л тавьсан юм. Өөрийгөө та бол бүр Ерөнхий сайд гээд бодчихсон юм уу Монгол Улсын, эсвэл Монголбанкны Ерөнхийлөгч гээд бодчихсон юм уу. Яах вэ, Найдалаа гишүүн хэлээд байна. Хараат бусаар байгаарай гээд. Гэхдээ ийм зарчимгүй байгаарай гэж бол хэлээгүй байх.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Асуулт, үг хамт явсан. Одоо тогтоолтой холбоотой асуулт, үг байгаа. Тэгээд энэ бол Эдийн засгийн байнгын хорооноос хараат бус Монголбанк руу ажил төрлийг нь заагаад байгаа, тэдээр цомхотго энэ тэр гээд байгаа зүйл бол биш. Энэ бол Монгол Улсын хэмжээнд өнөөгийн дэлхийн зах зээл, өнөөгийн төсөв, төсвийн тодотголтой холбоотой, төрийн албаны албан хаагчдад зориулсан шийдвэртэй бол холбоотой юм. Төрийн хэмнэлтийн бодлоготой холбоотой юм. Та бүхэн энийг хэмнээч ээ, энэ дээр арга хэмжээ аваач ээ, хэмнээч ээ, боломж, бололцоо байна уу гэсэн ийм л мэдээлэлтэй танилцаж байгаа шүү гэдгийг хэлье.

Улсын Их Хурлын гишүүдтэй хүндэтгэлтэй хандахыг хүсье.

Монголбанкны бүтцийн талаар Монгол банкны мэдээлэлтэй танилцаж дууслаа.

18.32 цаг.

Хэлэлцэх асуудлын 6. **Байнгын хорооны тогтоолын төсөл.**

Монголбанкны бүтцийн талаар Монголбанкны мэдээллийг сонссонтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулсныг та бүхэнд тараасан байгаа. Энэ тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

“Монголбанкны бүтэц бүрэлдэхүүний талаар авах арга хэмжээний тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.11.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Эдийн засгийн гадаад дотоод нөхцөл байдал болон учирч болзошгүй эрсдэлийг харгалзан төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах зорилгоор орон тоог цөөрүүлж, бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Монголбанканд даалгасугай.

2.Тогтоолын төсөл хэрэгжүүлэхдээ байгууллагын хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсгэхгүй байхад анхаарч, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа Улсын Их Хуралд танилцуулахыг Монголбанканд даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай.

Эдийн засгийн байнгын хорооны дарга.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгээр тасалъя. Шижир гишүүнийг нэмье. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Би тогтоолын төслийг дэмжиж байгаа. Аливаа институцийн хуулиар хүлээсэн чиг үүргийг хүндэтгэлтэй хандана. Хараат бус, бие даасан ажиллах гэдэг асуудал дээр нь хүндэтгэлтэй хандана. Тэгэхдээ хараат бус байна гэдэг бол энэ зах хязгааргүй, өөрөө төсвөө баталдаг, өөрөө орон тоогоо ингэж нэмээд явдаг ийм зүйл бол байдаггүй юм. Аль ч төрийн институцэд. Өнөөдөр та бид нар Улсын Их Хурал болоод явж байгаа. Бид хэдийн ажиллах орон тоог ч гэсэн бараг Үндсэн хуульд зааж өгсөн юм шүү дээ. 126 гэж. Тэгэхээр ер нь энэ жоохон хэмжээ хязгаар бол байх ёстой. Энийг олон жил гуйвуулж ирлээ. Монголбанкны бүрэн эрх, хараат бус байдалд халдах гэж байгаа юм шиг гишүүдийг айлгадаг. Ерөөсөө л хүрч болохгүй. Тэгээд одоо хэдүүлээ бараг орон тоогоор нь гаргавал их өөр юм гарна шүү дээ. Ямархуу л байгаа бол. Тэгэхээр энэ зүйл цэгцрэх цаг болсон. Өнөөдөр төр өөрөө бас төсвийн орлого бүрдүүлэлт дээр нэлээдгүй хүндрэлтэй гээд шүүх эрх мэдэл дээр хүртэл хэмнэлттэй, цагдаа дээр хүртэл хэмнэлттэй явж байхад энд ийм зүйл яригдахгүй байна гэдэг бол зарчмын хувьд асар буруу. Тэгээд өнөөдөр Монголбанкыг бид нар төсвөө өөрөө баталдаг гэж байгаа боловч энэ чинь шууд мөнгө хэвлэх хэж байгаатай ялгаагүй байхгүй юу. Энэ мөнгө чинь юу юм, эцсийн дүндээ эдийн засагт орно. Инфляц л болж байгаа шүү дээ. Ханшаа алдахгүй гээд доллар зарж байна. Энэ ханшийн зөрүүг нь хэн төлж байгаа юм. Жирийн ард түмэн, бизнес төлж байгаа байхгүй юу. Тэгээд ингээд бодохоор энэ зарчим зүйлүүдээ бас ойлгодог байгаарай.

Би Лхагвасүрэн Ерөнхийлөгчид хандаад байгаа юм биш. Би Лхагвасүрэн Ерөнхийлөгч мэдээллээ авсан. Үнэндээ хэлэхэд Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн хувьд 15 орон тоо л нэмэгдсэн юм байна лээ. Тэгэхээр энэ анхнаасаа маш замбараагүй явж ирсэн байна гэдэг зүйлийг л хэлээд байгаа байхгүй юу. Тэгээд бид хэд ер нь цаашдаа Монголбанкны хараат бус бие даасан байдалд халдахгүйгээр ядаж энэ үйл ажиллагааны тайланг нь сонсдог болмоор байна. Улсын Их Хурал чинь гадаад

дотоод аль ч асуудлыг авч хэлэлцэх сонсож шийдвэрлэх эрхтэй шүү дээ. Өнөөдөр яг хэчнээн төгрөгийн төсөв батлаад, юунд зарцуулаад, энийг ямар үр дүнтэй зарцуулсан юм бэ гэдэг зүйлийг Монголбанкны хэмжээнд, Санхүүгийн зохицуулах хорооны хэмжээнд бид хэд зүгээр ярьдаг баймаар байна шүү дээ. Тэгээд энийгээ гол ярьдаггүй мөртөө ямар үр дүн гаргаад байгаа нь ойлгомжгүй байж байж л яваад байдаг. Үнэхээр бас Монголбанк хариулж чаддаг бол хэлмээр байна. Хэчнээн төгрөгийн орлого олдог юм. Ашгийн төлөө л гэж өөрсдийгөө бас ярих гээд байдаг юм шиг байгаа юм. Бид бол төсөвт хамаагүй гээд. Мөнгө хэвлэж байгаа чинь ер нь үндсэндээ ард түмний мөнгө шүү. Тэгээд хэчнээн төгрөгийн орлого гаргаад, хэчнээн төгрөгийн үйл ажиллагаа бүх юман дээр зарлага гардаг юм. Тэгээд би энийг яриад явахаар Монголбанкны хараат бус бие даасан байдалд эдийн засгийн background-гүй хэдэн хүмүүс халдах гэж байна гэж яриад байдаг. Харин ч үгүй байх. Юм гэдэг чинь шүүх эрх мэдлээсээ хүртэл хэчнээн орон тоотой шүүгч нар ажиллахыг бид нар зааж өгч байгаа шүү дээ. Тэгэхдээ энэ хүрээндээ бүрэн эрхээ хэрэгжүүл гээд хэзээ ч оролцдоггүй. Яг үүнтэй ялгаагүй л байх ёстой.

Тийм учраас энэ тогтоол зайлшгүй гарах ёстой. Шаардлагатай бол Төв банкны хууль дээр .../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 3 номер. Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Би ерөнхийдөө Улсын Их Хурлаас ийм тогтоол гаргахад Төв банкны зүгээс бол нэг их татгалзаад байх зүйл байхгүй. Нэгэнт улсын төсөв тодотгоод, тодорхой хэмжээний хэмнэлт хийгдэхээр явж байгаад бол бид хамтдаа энэ ажлыг бол зохион байгуулаад хийгээд явж чадна. Тэгэхээр ямар ч байсан энэ тогтоол гарах юм бол яг үүнтэй нийцүүлээд, үр ашгаа нэмэгдүүлэх, ялангуяа өөрийн Монголбанкны үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх тал руу нь бол бид хэд зохион байгуулалтаа өөрчлөөд ингээд явахад бол бэлэн байгаа.

Монголбанкны өнөөдөр бол санхүүгийн тайланг олон улсын Пи Даблью Си агентлаг баталгаажуулсан. Тэгэхдээ санхүүгийн тайлан маань өөрөө олон улсын нягтлан бодох бүртгэлийн тайлагналын аргачлалын дагуу хийгдээд явж байгаа. Энэ тайлангийнхаа тайлангаа бол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороон дээр бол 5 сард бид танилцуулсан байгаа. Тэгээд танилцуулаад тайлангаа бол тавьсан.

2024 онд Монголбанк 300 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Энэ ашиг бол ерөнхийдөө алтны үнэ өндөр байсан. Монгол Улсын валютын нөөц бол тодорхой хэмжээнд өсөж, нэмэгдэж байгаа учраас эдгээрээс орж ирж байгаа хүүгийн орлого, эндээс бий болсон. Тэгээд нэгэнт л 1991 оноос хойш Төв банк Монгол банк болж байгуулагдаад өнөөдрийг хүртэл санхүүгийн тайлан гараад явж байгаа учраас санхүүгийн тайлан бол нэлээн бодлогын хувьд бодлогын хүүгийн зардлаараа бол алдагдалтай байдаг. Тэгэхээр өнгөрсөн онд бий болсон орлого маань өөрөө алдагдлыг бууруулаад явж байгаа. Тэгэхлээр бол өнгөрсөн оны энэ 300 тэрбум төгрөгийн орлого бол Монголбанкны хуримтлагдаад явж байгаа алдагдлыг бууруулахад зарцуулагдсан байгаа.

Р.Сэддорж: Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, орон тоог нь цөөрүүлэх тухай тогтоолын төслийг дэмжиж байна. Агуулгыг нь. Тэгээд

зүгээр Монголбанкныг зөвхөн орон тоо ч биш, зүгээр шинэчлэгдээсэй гэж би бол боддог. Ямар чиглэлээр вэ гэхээр 1 дүгээрт бүтэц зохион байгуулалт. Мэдээж хэрэг яг зорилго руугаа нийцүүлээд.

2 дугаарт, бодлого, арга барилын хувьд жишээлбэл зээлийн хүүг бууруулахтай холбоотой ажил дээр арай өөр маягаар ажиллаасай гэж бодож байгаа. Тэгээд Соронзонболд гишүүний ахалсан ажлын хэсэг дээр бид нар бас яриад байгаа юм. Тэгээд зарим арга хэрэгслүүд өмнө нь байсан зүйлсийг өөрчлөхгүй бол цаг үе өөр болсон. Банкнууд өөр болсон. Зээлдэгчид, зах зээл өөр болсон. Тэгэхээр зарим газартаа бол жоохон түрэмгий гэдэг юм уу, тодорхой шийдэмгий арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм. Түүнээс яг нөгөө стандарт байдлаар сахиад хэвтээд байх юм бол зээлийн хүү буурахгүй, буурахад нь нөлөөлөх боломж бас байгаа шүү. Зөвхөн инфляцаас гадна.

Дээр нь бас энэ санхүүгийн салбарыг зохицуулж байгаа байгууллага Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болчихож байгаа. Яг үнэндээ бол Монголбанкны үндсэн үүрэг санхүүгийн зах зээлийг зохицуулах гэхээсээ илүүтэй яг мөнгөний бодлогоо эдийн засгийнхаа тогтвортой байдлыг аваад, тэр санхүүгийн салбарыг банк, банк бусаар нь хувааж авч байгаа, зохицуулж байгааг нэгтгэх ёстой юм шиг санагдаж байгаа юм. Одоо яг Их Хурал дээр Эдийн засгийн байнгын хороо дээр бид нар бүтэц орон тоо ярихаасаа илүүтэй иймэрхүү юм ярих юм бол хамгийн зөв оновчтой болох юм байгаа юм. Тэгэхгүй бол банкыг яагаад ч юм ялгаж аваад тэнд ингээд өмчилчихсэн юм шиг авчихсан. Тэнд нь хаягдчихсан юм шиг Санхүүгийн зохицуулах хороо ингээд ийм хоёрдмол утгатай. 1 тогооны юмыг 2 талаас хутгаад байгаа байхгүй юу. Тэгж зохицуулахаар чинь 2 өөр юм гарна. Үр дүн гарахгүй байгаа шалтгаан нь бас энд байгаа шүү. Уялдаа байдаггүй байх боломжгүй. Яагаад гэвэл тусдаа хуулиар заасан 2 зохицуулагч байгууллага хараат бусаар ажиллаж байгаа болохоор болохгүй.

Саяын харин тэр яг тогтоолын төсөл дээр жишээлбэл ийм өгүүлбэр байгаад байна л даа. Орон тоог нь цөөлөх гээд. Гэтэл хуульд Монголбанкны Ерөнхийлөгчийнх нь бүрэн эрхийнх нь хэмжээнд оновчтой тэрийгээ тогтоох нь өөрийнх нь эрх байгаа байхгүй юу. Бид нар шууд цөөл, олшруул гэж байгаа нь өөрөө эрх зүйн хувьд буруу болчих юм биш үү дээ. Энийгээ бас сайн харж үзэхгүй бол болохгүй. Түүнээс биш яг орон тоог оновчтой болгох талыг бол би дэмжиж байна. Яг ийм тогтоол гаргачхаад ямар үр дүн гарна гэж хүлээж байх юм. Араас нь иймэрхүү маягийн тогтоол гараад байх юм бол энэ чинь өөрөө яг хараат бус байдалд нөлөөлнө шүү.

Яагаад Монголбанкны болон төрийн байгууллагуудын орон тоо нэмэгдээд байна гэхээр хараат бус байгаа болохоор л нэмэгдээд байгаа байхгүй юу. Бид нар ингээд тогтоох тусмаа улам хараат бус болгоод, хараат бус болгох тусмаа орон тоо, үр ашгийг нь улам муутгаад байгаа нэг ийм асуудал байгаа шүү. Тэгээд Сайнзориг гишүүний хэлж байгаа тэр магадгүй яваандаа орон тоон дээр нь хатуу жишиг тогтоочих юм бол бараг нялуунаас шулуун болчихож магадгүй.

Тийм болохоор байнгын хорооны гишүүдээсээ бас яг энэ дээр бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох талаас шийдвэр гаргаж .../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Найдалаа гишүүнд.

Б.Найдалаа: Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох талаар шийдвэр гаргаж болж байна. Тогтоол гаргаж болж байна. Зүгээр энэ дээр эрх зүйн талаасаа цаашдаа буруу жишиг болчих вий гэдэг талаас нь хуульчид, Байнгын хорооны зөвлөхүүд бас ажиллаасай гэж бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Би 1 санал хэлье. Энэ тогтоолын 1 дүгээр хэсэг дээр сахилга батыг мөрдүүлэх гэгчхээд таслал тавиад үр ашиг таслал бүтээмжийг нэмэгдүүлэх гэж өөрчлөөд, тэгээд үрэлгэн байдлыг хязгаарлах гэдгийг арай өөрөөр ажил үүргийн давхардлыг арилгах уялдааг хангах зорилгоор гэвэл илүү зүгээр юм болов уу гэсэн ийм санал байна. Өгүүлбэрийн хувьд.

Тэгээд ер нь бол түрүүний Найдалаа гишүүний хэлээд байгаа тэр орон тоог цөөрүүлж, бүтэц, бүрэлдэхүүнээ яаж хийх вэ гэдгийг бол мэдээж Монголбанкны удирдлагууд өөрсдөө судлаад, явал хамгийн оновчтой гээд шийдвэрээ гаргах байх л даа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Шижир.

Ө.Шижир: Монголбанкны үндсэн зорилт бол өөрөө үндэсний мөнгөн тэмдэгт, төгрөгийг тогтвортой байдлыг хангахад оршино гээд бүр Төв банкны тухай хууль дээр байгаа шүү дээ. Энэ бол өөрөө юу гэсэн бэ гэхээр инфляцыг тогтвортой барина. Нөгөө талдаа төгрөг болон ам.доллар бусад гадаад валютын эсрэг төгрөгийн ханшийг тогтвортой барина л гэсэн үг шүү дээ. Энэ өөрөө эдийн засгаараа юуг цаагуураа илэрхийлж байна вэ гэхээр гадаад худалдааг макро эдийн засгийг бүгдийг нь дэмжиж байгаа хэлбэрээр уг нь илэрхийлж байгаа юм. Ер нь бол Монголбанк өөрөө Засгийн газрын аль нэг бүрэлдэхүүн биш. Бас Сангийн яамны харьяа ч биш. Тийм болохоор би бол нэг юм хэлэх гээд байгаа юм.

Яагаад гэхээр сүүлийн 4 жилд улсын төсвийн зарлага 12 их наяд байж байгаад, өнөөдөр 32 их наяд болчихсон. Ерөнхийлөгчийн хориг орж ирэхээс өмнө 35 их наядаар батлагдсан. Тухайн үед Засгийн газраас орж ирж байгаа төсөв дээр инфляцыг 6 хувьд барина гэсэн. Одоо инфляцыг барьж чадаагүй. Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр Монголбанк улсын төсөв батлах үед яг тодорхой байр суурь илэрхийлдэг баймаар байгаа юм. Уучлаарай Улсын Их Хурал, Засгийн газраа та нар Засгийн газрын зардлыг 35 их наяд болгоод өсгөчих юм бол бид нар инфляцыг 6 хувьд барьж чадахгүй. Яагаад гэвэл манай зах зээлийн дотоод боломж ийм. Манай ДНБ ийм гээд ингээд бодит юмаа ярьдаг болохгүй бол манай Их Хурлын гишүүд ч хүртэл ингээд яг тухайн үед тойрог тойрог ч гэдэг ч юм уу, эсвэл өөрсдийнхөө төсөл хөтөлбөрүүд рүү оруулаад төсвийн зардлыг тэлчихдэг. Тэлээд ирэхээр бид нар тэр их зардал дээр тэр чинь буцаад инфляцыг 6 хувьд барих мөнгөний бодлогыг нийлүүлэлтийг тогтвортой барих энэ тэрийн зорилго чинь биелэхгүй болчихож байгаа байхгүй юу. Тэгээд буцаад Монголбанкныханыг загнаад суугаад байдаг. Та нар 6 хувьд барих ёстой гэсэн яасан, 1 бол Засгийн газраа та нар 6 хувьд барих гэсэн гээд энэ чинь Их Хурал баталж байгаа байхгүй юу. Тэгэхээр Монголбанк жил бүрийн улсын төсөв дээр тодорхой байр сууриа илэрхийлдэг баймаар байгаа юм. Монгол Улсын Их Хурлаар Засгийн газрын өргөн барьсан энэ төслөөр бид нар 35 их наяд дээр Засгийн газрын зардал орж ирж байгаа бол инфляц 6 хувьд баригдахгүй. Энийгээ тодорхой хэлдэг баймаар байгаа юм. Жил бүр. Уучлаарай Улсын Их Хурлаа та хэдийн төсвийн зардал чинь ийм өндөр байгаа тохиолдолд бид нарын мөнгөний бодлого, валютын ханш ингэж чадахгүй. Яагаад

гэвэл та нарын баталсан 35 их наядын зардлыг чинь 20 тэрбум нь импортыг дэмжсэн буюу гадаад худалдаа руу чиглэсэн валют болоод явж байна. Тийм учраас бид нар валютын ханшийг төдөд барьж чадахгүй гээд тодорхой юмаа хэлэхгүй болохоор үр дүнд нь юу болдог вэ гэхээр эргээд Монголбанкныхныг Их Хурлын гишүүн нь загнаад сууж байдаг байхгүй юу. Тэгэхээр манай Их Хурлын гишүүд ч хүртэл, тэр Монголбанк ч тэр яг ийм юмнууд дээр тодорхой байр сууриуд илэрхийлдэг баймаар байгаа юм. Үгүй ээ, яаж ч бодсон сүүлийн 4 жилд 12 их наядаас 32 их наяд буюу 20 их наяд дээр өсөж байгаа энэ төсвийн тэлэлтийг чинь бид нар яаж инфляцыг 6 хувьд барих юм. Энэ чинь энгийн хүн ч ойлгохгүй шүү дээ. Энгийн хүн ч ийм боломжгүй байхгүй юу даа. Өрхийн аж ахуй дээр та нар бодоод үз нээрээ. Өрхийн аж ахуй дээр ч боломжгүй байхгүй юу. Жижиг бизнес дээр ч боломжгүй. Тэгэхээр яг Монголбанк ийм байр сууриудаа тодорхой илэрхийлээд, яг төсөв батлахад мөнгөний хүрээний мэдэгдэл орж ирэхэд ийм байр сууриуд сууриудаа илэрхийлдэг байгаасай гэж хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: Санал хэлсэн үү. Улсын Их Хурлын гишүүн Жаргаланг нэмье. Жаргалан.

Б.Жаргалан: Өмнө нь Монголбанк Эдийн засгийн байнгын хороо, Улсын Их Хурлын чуулган дээр асуудал танилцуулж ч орж ирж байхад ч гэсэн би удаа дараалан хэлж байсан. Төв банкны хараат бус байдал гэж бий. Төв банкны Ерөнхийлөгч 6 жилээр томилогддог. Мөнгөний бодлого бол Улсын Их Хурлаар үндсэн чиглэлээ батлуулаад, ингээд бас хараат бус байдлаар хэрэгжээд явах ёстой. Тэгээд сүүлийн үед болохоор энэ Монголбанкны ба улс төрийн бодлогын манлайлал дутагдаад байгаа учраас одоо бүр сүүлдээ Их Хурал, Эдийн засгийн байнгын хороо аргаа бараад энэ бүр гэдэс дотор луу нь ороод, энэ орон тоогоо ингэж барь, тэгж барь гэсэн тогтоол батлах гээд сууж байна шүү дээ. Тэгэхээр энэ бол бас нэг талаасаа зарчмын хувьд бол өрөөсгөл зүйл байгаад байгаа юм. Гэхдээ яагаад ийм байдалд хүрчхэв ээ гэдгээ бас хэдүүлээ дүгнэлт хийх ёстой байгаад байгаа байхгүй. Сая гишүүдийн хэлээд байгаа яг Монголбанкны зүгээс гаргаж байгаа тэр улс төрийн манлайлал өнгөрсөн хугацаанд бол туйлын хангалтгүй байлаа. Яг одоо Монголбанкны зорилтуудаа хэрэгжүүлэх байдал дээр ийм манлайлалтай ажиллаж чадахгүй байсан учраас одоо эргээд бүр Монголбанкны дотоод үйл ажиллагаа, орон тоо руу нь хүртэл Улсын Их Хурал орох гээд байна шүү дээ. Тэгэхээр Улсын Их Хурал бол бас хамаагүй энэ орон тоо руу нь ч гэдэг юм уу, Монголбанкны тэр хараат бус байдалд ингэж хандаж, ийм аймар гэдэс дотор луу нь орсон тогтоол баталж болох эсэх дээр нь би бас эргэлзэж байна.

Яагаад вэ гэхээр энэ чинь бас маш буруу жишиг эхлүүлчих байхгүй юу. Тэгэхээр цааш цаашдаа бол энэ гишүүдийн хэлээд байгаа шиг энэ орон тоог цөөрүүлж энэ тэр гэдэг нь болохоор бас бүр тусгайлан заачихсан үг болж байж магадгүй. Тэгэхээр орон тоог оновчилж гэдэг юм уу, тэгээд бүтэц, бүрэлдэхүүний бодлогоо шинэчлэн танилцуулах гэдэг юм уу тийм ерөнхий үгээр энэ тогтоолынхоо төслийг найруулдаг сан уу. Эс бөгөөс бид нар нөгөө нуухыг нь авах гээд нүдийг нь сохолно гэдэг шиг зүйл бас болгочхож магадгүй ийм нөхцөл байдал руу очоод байна. Тэгээд яг энэ дээр бас Монголбанкны удирдлага бас дүгнэлтүүд хиймээр байна л даа. Сая ч гэсэндээ өнгөрсөн 7 хоногт чуулганы нэгдсэн хуралдаан дээр жишээлбэл үгийн алдаа гаргаж байна. Тэгэнгүүтээ тэрийгээ тухай бүр залруулахгүй байгаад байна. Тэгээд энэ Монголбанкны үйл ажиллагаатай холбоотой, энэ мөнгөний бодлоготой холбоотой асуудал дээр Улсын Их Хурал дээр ийм хариуцлагагүй мэдэгдлүүд яваад байхаар энэ бүхэн чинь зах зээлд бас тодорхой дохионууд өгөөд, эргээд нөгөө валютын ханш, эргээд нөгөө инфляцдаа бас

нөлөөлөх тийм зүйлүүд гараад байна шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр энэ бүхэн дээр хаана хаанаа хэдүүлээ бас хариуцлагатай байж энэ зах зээлд ямар дохио өгч байгаагаа бас бодох л хэрэгтэй. Ийм зүйл байна гэсэн санал хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж санал хэлж дууслаа.

Тогтоолын төсөл дээр гишүүдээс санал гарсан.

1.Эдийн засгийн гадаад дотоод нөхцөл байдал болон учирч болзошгүй эрсдэлийг харгалзан төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах зорилгоор орон тоог цөөрүүлж, бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Монголбанканд даалгасугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ байгууллагын хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсгэхгүй байхад анхаарч, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа Улсын Их Хуралд танилцуулахыг Монголбанканд даалгасугай гэж.

Энэхүү тогтоолын заалт дээр гишүүдээс гарсан санал.

1.Эдийн засгийн гадаад дотоод нөхцөл байдал болон учирч болзошгүй эрсдэлийг харгалзан төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, ажил үүргийн давхардлыг арилгах зорилгоор орон тоог оновчтой байдлаар бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Монголбанканд даалгасугай гэж өөрчлөх найруулгын өөрчлөлтийг дэмжье гэсэн томъёоллоор бас санал хураалт явуулна. Ингээд тогтоолоо батална. Санал хураалтад гишүүд бэлдэнэ.

Маргааш Эдийн засгийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хамтарсан хурал өглөө 9 цагаас хуралдана. Гишүүдэд зар дуулгаж байна. Ерөнхий хяналтын сонсголын тов дараалал тогтох тухай.

Гишүүд ирж байгаа. Тэгээд энэ хугацааг ашиглаад дараагийн 8 дугаар асуудлаа хэлэлцье.

19.08 цаг.

Эдийн засагт тулгамдаж буй асуудлууд болон холбогдох байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхланг мэдээллийг танилцуулахыг урьж байна. Сайдын микрофоныг нээе. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн мэдээлэл хийе. 3 номер.

Б.Лхагвасүрэн: Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпорацаас бүрддэг ийм байгууллага байгаа.

Тэгээд санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь бол шийдвэр гаргахдаа зөвлөмж хэлбэрээр гаргаад явдаг байгаа. Тэгээд та бүхэнд өнөөдрийн макро эдийн засгийн өнөөгийн байдал, тулгамдаж буй эрсдэл, холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг, тэгээд дээр нь Монголбанкны зүгээс 2025 онд авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны талаар товч мэдээллийг та бүхэнд хүргэе.

Оны эхний 5 сарын байдлаар Монгол Улсын гадаад валютын орох урсгал өнгөрсөн оны мөн үеэс 1,8 тэрбум доллароор буурсан бөгөөд үүний 1,6 тэрбум доллар нь нүүрсний экспортын орлого буурсантай холбоотой байгаа. Энэ нь эдийн засгийн идэвхжил, валютын ханш, төсвийн орлого зэргээр эдийн засагт бол нөлөөлж байгаа болно. Тэгээд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй эрсдэлийн талаар хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

Тус зөвлөл улиралд 1 удаа хуралдах товтой хэдий ч эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан оны эхнээс эхний 5 сард ээлжит бусаар 5 удаа хуралдаж, холбогдох асуудлыг хэлэлцэж, зөвлөмж гаргасан болно.

Зөвлөлийн хуралдаанаар макро эдийн засаг, төсөв, санхүүгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв байдал, мөн хөгжингүй орнуудын худалдааны бодлогод гарч буй өөрчлөлтийн Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого болон гадаад валютын нөөцийн хүрэлцээт байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээ, мөн санхүүгийн зохицуулалттай салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг ерөнхий агуулгын хүрээнд тодорхой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байгаа.

Эдийн засагт үүсэж буй эрсдэл, эмзэг байдлыг бууруулах чиглэлд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс тодорхой шийдвэрүүдийг гаргахын зэрэгцээ нийт 3 зөвлөмжийг гаргаж, Засгийн газарт болон зөвлөлийн гишүүн байгууллагуудад бол хүргүүлээд байна. Үүнд,

Дотоодын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, экспортод учирч буй бэрхшээлийг арилгах. Ингээд 2025 оны 3 сарын 18-нд энэ шийдвэрийг гаргасан байгаа.

Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Хадгаламжийн даатгалын корпорацын эзэмшиж буй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг олон улсад арилжаалах энэ шийдвэрийг 2025 оны 3 сарын 25-ны өдөр гаргасан.

Гадаад валютын нөөц, банкны салбарын урт хугацаат гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор урт хугацаат своп хэлцлийн зохицуулалтад өөрчлөлт оруулах, гадаадын банк санхүүгийн байгууллагуудтай санхүүгийн хэлцэл хийх замаар гадаад валютын улсын нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах 2025 оны 4 сарын 1-нд зөвлөмж гаргасан байгаа.

Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсэгт заасан банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийн хязгаарлалтын арга хэмжээг хангуулах хугацааг 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулах хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах, дэмжлэг үзүүлэх гээд энэ бас 2025 оны 4 сарын 1-нд энэ зөвлөмж гаргасан байгаа.

Монгол банкны зүгээс гадаад орчны тодорхой бус байдалтай холбоотойгоор эдийн засагт учирч болзошгүй эрсдэлтэй уялдуулан эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэр алдагдахаас сэргийлсэн бодлогыг 2024 оны сүүлийн хагасаас хэрэгжүүлж байна. Энэ нь нийлүүлэлтийн шинжтэй инфляц өдөөгдөж, ужгирахаас сэргийлэх, эрэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулах бодлоготой нийцтэй явж байгаа болно.

Гадаад эрэлтийн сөрөг шоктой үед эдийн засгийн хэт тэлэлтээс үүдэлтэй гадаад валютын эрэлтийг саармагжуулж, эдийн засагт үүсэж болзошгүй хүндрэлийг бууруулах ийм зорилготой байгаа. Энэ утгаараа Монголбанкны зүгээс энэ чиглэлд дараах арга хэмжээг бол авч хэрэгжүүллээ.

Төсвийн тэлэлт улс орнуудын сонгуулийн өрнөлтэй холбоотойгоор дэлхийн томоохон эдийн засгийн бодлогод гарч болзошгүй өөрчлөлтүүдийг харгалзан мөнгө санхүүгийн бодлогыг чангаруулж эхэлсэн. Тухайлбал 2024 оны 9 дүгээр сараас төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлж эхэлсэн бөгөөд нийт 3 удаагийн 5 нэгж хувийн өсөлтөөр 1,7 их наяд төгрөгийн нөөцийг банкны системээс татаж, эргэлтэд орохыг саармагжуулсан.

2025 он гараад Мөнгөний бодлогын хороо 4 удаа хуралдаж, мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаж байна. Хүлээлтээр дамжин үнийн өсөлтөөр эрчимжих 2 дахь үеийн нөлөө нэмэгдэх эрсдэлээс сэргийлэх, гадаад орчны таагүй төлөвийн үед дотоод эдийн засагт хэт тэлэхээс сэргийлэх зорилгоор оны эхнээс бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувьд хүргээд байна. Хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 50 хувьд хүргэх, тэтгэврийн зээлд зохицуулалт хийхээр бас шийдвэрлэсэн байгаа. Цалин, тэтгэврийн орлогын өсөлтийг даан, хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж буй нь төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханшинд дарамт учруулахын зэрэгцээ эдийн засагт сөрөг шок үүсвэл өрхийн санхүүгийн чадамж доройтох эрсдэлийг харгалзан эдгээр шийдвэрүүдийг бол гаргасан байгаа.

Зарим тэтгэврийн зээлдэгчдээс ирүүлсэн гомдол Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлын байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдээс Монголбанканд ирүүлсэн хүсэлтийг харгалзан өнөөдөр Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны хурлаар тэтгэвэр тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд өр орлогын харьцааны зохицуулалтыг хүчингүй болгохоор шийдвэр гаргасан байгаа.

АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас тус улсын Засгийн газрын үнэт цаас эзэмшигч нарт зориулан хэрэгжүүлдэг FIMA repo facility хөтөлбөрт олон улсын төлбөр тооцооны банкаар дамжуулан оролцож, 467 сая ам.долларын богино хугацааны эх үүсвэрээр гадаад валютын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг ингээд сайжруулж ажиллалаа. АНУ-ын тарифын бодлогын нөлөөгөөр олон улсад худалдаа эдийн засгийн төлөв муудаж, гадаад зах зээлийн эрсдэл тодорхой бус байдал хурдтай нэмэгдсэн хэвээр байна. Иймээс гадаад, дотоодын эдийн засгийн орчны тогтворгүй байдлыг шалтгаалах болзошгүй эрсдэлд бэлтгэлтэй байх, гадаад валютын нөөцийн хүрэлцээтэй байдал болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах ийм зорилгоор саяын АНУ-ын Холбооны нөөцийн банктай ингээд хамтран ажиллаж байна.

Цаашлаад дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс 2025 оны эхний хагас жилд 5,9 тонн үнэт металл худалдан авч, гадаад валютын нөөцийг 408 сая ам.доллараар нэмэгдүүлээд байна.

Монгол Улсын банкны систем 2025 оны эхний 5 сарын байдлаар 788 сая ам.долларын гадаад эх үүсвэрийн зээл, бондоор олон улсын санхүүгийн зах зээлээс босгож бас авчраад байна.

ОУВС-ийн дүрмийн 4 дүгээр заалтын зөвлөлдөх уулзалтууд өнгөрсөн сард болж, эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдалд буй гарч буй өөрчлөлтүүдтэй холбоотойгоор мөнгөний бодлого, санхүүгийн салбарын зохицуулалтын хүрээнд Монголбанкнаас авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээний зөвлөмжийг бас өгснийг та бүхэнд бас танилцуулъя гэж бодож байна.

Инфляц зорилтот түвшинд буурч, тогтворжих хүртэл хатуу мөнгөний бодлогыг хэвээр хэрэгжүүлэх;

Монгол Улсын гадаад валютын нөөцийг хэмжээг зохистой түвшинд хадгалах, ханшны илүү уян хатан бодлого хэрэгжүүлэхийг зорих;

Макро зохистой бодлогын зохицуулалт, санхүүгийн салбарын хяналт шалгалтыг бэхжүүлэх нь зээлийн өсөлтийг тогтворжуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал байна гэж ОУВС-ийн зөвлөмжид бол дурдсан байгаа. Ц

Цаашид эдийн засаг, санхүүгийн тогт тогтвортой байдлыг хангах санхүүгийн зуучлалын хэвийн үйл ажиллагааг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд Монголбанк бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана гэж танилцуулга бэлдсэн байгаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Жавхлан Сангийн сайд, Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Мөнх-Ундарга Монголбанкны Санхүүгийн эрх зүйн хэлтсийн дарга, Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Итгэлсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн газрын дарга, Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Батболд Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн захирал, Баатарсүрэн Хадгаламжийн даатгалын корпорацын Гүйцэтгэх захирал, Ууганбаатар Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, Энхжаргал Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүн, Эрдэнэбаяр Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн.

Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Соронзонболд гишүүнээр тасалъя. Лувсанжамц гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Одоо экспортын орлого ер нь бид нарын хүлээлт яг сэргэх хугацаа ер нь намар хэр бодитой хүлээлттэй байгаа вэ гэдэг асуулт байна. Өөрөөр хэлбэл коксжих нүүрсний үнэ маань нэлээн уначихлаа. Эрчим хүчний нүүрсээ экспортлоод байна. Үүнийгээ дагаад экспортын орлого маань багасаад байдаг. Тэгэхээр үлдэж байгаа хагас жилд орж ирэх нүүрсний экспортын орлогыг ер нь төлөвлөж байгаагаараа орж ирнэ гэж харж байна уу. Юу гэж харж байгаа вэ гэдэг нэг асуулт байна.

Р.Сэддорж: Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Одоо бидний хийгээд байгаа энэ тодотгол маань ерөөсөө яг таны асуултад хариулт болж байгаа юм. Мөнгөний бодлого оны эхнээс хойш 2 ч удаа хуралдсан. Сая бараг 3 дахиа хуралдав уу даа. Тэгээд мөнгөний бодлогынхоо хатуу төлөвийг хадгалсан байгаа. Үүнтэй нийцүүлж ер нь тодотгол хийгдэж байна гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл мөнгөний бодлого хатуураад, төсвийн бодлого хэмнэлтийн горим руу шилжиж байна. Энд хэрвээ бид нар 1, 2 дугаар улиралд төсвийн тодотгол хийсэн бол шүү бол магадгүй 1 их наяд, 2 их наядаар хийх байсан байх. Ингээд бид ямар ч байсан 5 сарын 31 гэдэг тоог бол хүлээсэн. 5 сарын 31-ээр 535 тэрбум төгрөг төсвийн хэмнэлтийн хуулиар шууд хэмнэгдсэн. Цаана нь яах вэ, бид нарын төсөөллөөр манайх Монголбанк дээр 2,3 их наядаар орлого тасарна. Сангийн яам бид тооцоолж байсан Монголбанк 2,8, ер нь бид Монголбанкны тоогоор авсан даа. Ингээд ер нь 3,3 их наядаар орлого тасрах нь гэдэг ийм оны эцэс хүртэлх ийм прогнозыг хийгээд, ингээд хэмнэлтийн тодотголыг хийсэн байгаа. Тэгэхээр 2,8 их наядаар яг орлого талдаа тасрах дүн нь бол энэ байна. Тэгэхээр 2,8 гэдэг маань 800 орчим сая доллароор орлого тасарна. 800-аас мэдээж шууд нүүрстэй холбоотой нь 600-аад сая доллар орлого төлөвлөж байснаас тасарна гэж харж байгаа. Тэгэхдээ энэ маань бид нар биет хэмжээгээ гүйцээж гаргаад, үнийн уналтаас нь бид нар алдах хэсэг юм байгаа юм шүү. Одоогоор 7 сарын 1-ний байдлаар өнгөрсөн жил бид 42 сая тонн нүүрс гаргачихсан байсан. Энэ жил 35 сая тонн буюу 6-7 сая тонны биет хэмжээний тасралттай явж байгаа. Үлдсэн хугацаанд биет хэмжээгээ нөхнө гэсэн ийм тооцоотой ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Эхлээд ямар ч байсан Эдийн засгийн байнгын хороо дээр ирцдээ орчхоод, хуралдаа суухгүй, ирцээ бүрдүүлэхгүй хуралдаан сунжруулаад байгаа бусад Байнгын хорооны гишүүдийг хүрч ирэхийг хүсэж байна. Цагтаа ирээд, хуралдаа суудаг нь хохироод, дундаас нь гараад явчихдаг ийм гишүүд бол ажлаа хийгээч ээ л гэж бодож байна.

2 асуулт байна. Хүснэгт 2 дээр байгаа Монголбанкнаас банк бус санхүүгийн байгууллагын хэрэглээний зээлийг бууруулахад чиглэлд авсан арга хэмжээ гээд 3 арга хэмжээ байна. Эхний чиглэлээр банкны салбарт мөрдүүлж буй хэрэглээний зээлийн зохицуулалтыг банкны бус санхүүгийн салбарт зэрэг хэрэгжүүлэхийг хүсэх тухай Монгол банкнаас Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн албан тоот бичгүүд дэмжсэн эсэх дээр нь ерөөсөө тэмдэглэгээ байхгүй байна. Энийг яагаад байхгүй байгаа юм бол. Дэмжсэн, дэмжээгүй. Дэмжээгүй бол яагаад тэгсэн бэ гэсэн эхний асуулт.

2 дугаарх нь бас адилхан. 2, 3 дээр байгаа хэрэглээний зээлийн зохицуулалтыг банкны бус санхүүгийн салбарт зэрэг мөрдүүлэх саналын тухай гээд дэмжсэн эсэх нь үгүй гэж байна. Энэ бас яагаад үгүй гэсэн юм. Банкны болон банкны бус санхүүгийн салбараас олгох автомашины зээлд зээл үнэлгээний харьцааг нэвтрүүлэх гээд энэ ард нь бас үгүй гэхихсэн байх юм. Хойд талын тайланг нь уншихаар нэвтрүүлсэн гээд биччихсэн байх юм. Энэ хүснэгт нь хойд талын тайлбартайгаа өөр байгаа юм болов уу. Энэ яасан юм бол.

Дараагийнх нь Банкны тухай хууль байна. 2023 ондоо багтаагаад 20 хувиас дээш хувьцаа эзэмшигчтэй банкнууд байхгүй болно. 1 этгээд байхгүй болно гэснийг 2026 оны 12 дугаар сарын 31 хүртэл сунгасан. Үүний хэрэгжилт ингээд 3 жилээр сунгаад өгөхөөр хэрэгжих боломжтой юм уу. Хувийн хэвшлийн банкнуудаас энийг

яг 2026 онтой нийцүүлээд хийх боломжтой байна уу, үгүй юу. Тэр ажлын бэлтгэл явц ямар байгаа юм бол гэсэн 4 асуулт байна.

Р.Сэддорж: 4 асуулт байна. Хариулт 5 номер. Жамбаажамц дарга.

Т.Жамбаажамц: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хороо Жамбаажамц байна. Та энэ хүснэгттэй холбоотой урд тал нь тэр хүргүүлсэн санал гээд огноотой байх шиг байна. 2022 оны 3 сар, 2022 оны 12 сар, 2023 оны 1 сар гээд. Ерөнхийдөө бол энэ банк бус санхүүгийн байгууллагуудад банкнаас олгож байгаа зээлийн асуудлыг энэ оны 3 сарын 2025 оны 3 сарын 20-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны хурлаар хязгаарласан байж байгаа. Өөрөөр хэлбэл шийдвэр нь сая энэ онд гарсан. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн байгууллагууд банкнаас өнгөрсөн жилийн жилийн эцсийн байдлаар бол нэр бүхий арилжааны 10 банкнаас 77 банк бус санхүүгийн байгууллага 622 тэрбум төгрөгийн зээл авч, урт, богино хугацааны зээл авч цааш нь дамжуулж үйл ажиллагаа явуулсан байдаг. Тэгэхээр энийг манайх Санхүүгийн зохицуулах хороо өмнө нь бас Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр бас энэ асуудлаа танилцуулсан. Тэгээд энэ асуудлыг бол шийдсэн. Мөн хэрэглээний зээл дээр та бас асуулаа. Машин барьцаалсан хэрэглээний зээл. Мөн яг энэ 3 сарын 20-ны хурлаар машин барьцаалсан буюу машины лизингийн машин барьцаалсан зээлийг өр орлогын харьцаа буюу урьдчилгаа төлбөр үнэлгээний харьцаа дээр хороо нэлээн өндөр шаардлага тавьчихсан. Өөрөөр хэлбэл машин ББСБ-аар зээлээр авч байгаа иргэн урьдчилгаа төлбөрийг 40-өөс доошгүй хувийг нь төлж байж, үлдсэн 60 хүртэлх хувь дээр нь зээл авах энэ нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ нь бол өөрөө Монголбанкны мөнгөний бодлогын томоохон шийдвэр гарсан. 3 сарын 7-ны өдөр. Тэр мөнгөний бодлогын макро шийдвэртэйгээ нийцтэй байдлаар. Тэгээд тогтвортой байдлын зөвлөл дээрээ танилцуулаад тэгээд Санхүүгийн зохицуулах хорооны хурлаас шийдээд, энэ шийдвэр одоо хэрэгжээд явж байгаа. Хороо хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавиад явж байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Лхагвасүрэн Ерөнхийлөгч 3 номер.

Б.Лхагвасүрэн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. 2021 оны 1 дүгээр сард Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Нэмэлт, өөрчлөлт ороход бол 2 томоохон зарчмын ийм өөрчлөлт орсон байгаа. 1 нь бол банкныг Хөрөнгийн биржид бүртгэлтэй, нээлттэй, хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх. 2 дахь томоохон зарчмын заалт нь бол хувьцааны төвлөрлийн дээд хязгаарыг 20 хувь байхаар тогтоосон байгаа. 2023 онд бол манай системийн нөлөө бүхий 5 банк бол Хөрөнгийн биржид нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжиж IPO хувьцаагаа нээлттэй арилжаалсан. Тэгээд ерөнхийдөө 11 хүртэлх хувиа ингээд арилжаалчхаад байгаа юм. Нийтдээ 700 гаруй тэрбум төгрөг болсон. Үүнээс ингээд цаашаа дахиж хувьцаагаа нэмж гаргах 2 дахь IPO хийхэд бол хөрөнгийн биржийн төлбөрийн чадвар бол хүрэлцэхгүй байгаа учраас цаашдаа гадагшаа, гадаадын хөрөнгийн зах зээл рүү бол гарахаас өөр гарц, гаргалгаа байхгүй байгаад байгаа юм. Өөр 1 зүйл нь гэвэл мэдээж заавал нээлттэй хувьцаат хэлбэрээрээ олон нийтэд арилжаалах биш бас хаалттай хэлбэрээр..../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Гадаадаас стратегийн хөрөнгө оруулагчийг олж авчрах ийм бас боломжууд байгаа юм. Тэгээд гаднын хөрөнгө оруулагчтай уулзахад бол бас 2 зүйл хэлээд байгаа юм.

1 дүгээрт Компанийн тухай хууль дээр бол хяналтын багц бол 33 хувь гэж заасан байгаа юм. Тэгэхээр хэрвээ ийм хяналтын багцгүй бол 20 хувь бол өөрөө сонирхол бол төрүүлэхгүй байна. Тэгэхээр компанийнхаа тухай хуультай нийцүүлээд, энийгээ өөрчлөөч гэсэн санал тавиад байгаа юм. Тэгээд тэр утгаараа 2021 онд гарсан хуулийн заалтаар бол 2023 оны эцэст энэ 20 хувьд орох ёстой байсан. Тэгэхээр нэгэнт энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэх боломжгүй учраас 2026 он болтол ингээд хугацааг нь сунгачихсан. Хэдийгээр 2026 оны эцэс хүртэл хугацаа явж байгаа ч гэсэн гаднын хөрөнгө оруулагчтай уулзахад бол энэ 20 хувь бол өөрөө хангалттай хангалттай тоо хэмжээ биш байна. Дээр нь бас банкыг бол 2 ялгаж байгаа. 1 нь системийн нөлөө бүхий банканд бол 33, жижигхэн банканд бол 20 хувь бол бүр сонирхол татахгүй байна. Энд бол 51-ээс дээш хувийг .../минут дуусав/

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүн. Болчихсон у.

Сангийн сайдаас 1 юм асууя. Энэ нөгөө тээврийг төрийн худалдан авахаар олж өгч байгаа асуудал ер нь зөв гэж үзэж байгаа юу. Тээврийг. Тэр нөгөө олон жолооч нар тэр дээр маш хэцүү байна. Хамгийн бага үнэ өгөх нь ордог юм. Тэгэхээр ерөөсөө Монголчууд тэрэнд нь орох ямар ч боломжгүй. Нөгөө хувиараа 1, 2, 10 машинтай, 5 машинтай. хүмүүс боломжгүй гээд байгаа юм. Тэрийг та юу гэж үзэж байна вэ.

Монголбанк, Санхүү зохицуулах хорооноос тэр аппликэйшний зээлийг л иргэд маш их ярьж байна. Энэ хүүхэд залуучуудын аваад байгаа, хэрэглээд байгаа энэ юмыг эргэж харж болохгүй юу гээд энэ дээр ийм 2 асуулт байна. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сэддорж даргын асуултад хариулъя. Би тантай санал нийлж байна. Тэр ерөөсөө болохгүй байгаа юм. Хэчнээн сайн хууль байсан ч гэсэн амьдрал дээр хэрэгжээд эхлэхээрээ ингээд олон шалгуур дундуур гардаг. Олон цоо шинэ хуулийг баталж байх үед, үзэл баримтлалыг нь яригдаж байх үед амьдралд шинээр гарч ирэх тэр тохиолдол болгоныг бас хараагүй байх ийм зүйл бол амьдрал дээр шалгагдаж байна. Шалгуураар гарч ирж байна. Яг энэ Худалдан авах ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулахаар ингээд Улсын Их Хурал дээр ч бас ажлын хэсэг гарчихсан ажиллаад явж байгаа. Тийм учраас тэр дээр бас энэ зохицуулалтуудыг хиймээр юм шиг байгаа юм. Тухайлбал, одоо бас 1 томоохон салбарын зохицуулалт гэх юм бол нөгөө Эрчим хүчний тухай хууль орж ирчхээд байна. Энэ бас л тэр хуулиар зохицуулалт нь болохгүй болчихоод хууль нь салаалж ингэж орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхдээ бид бас хамаагүй бас тавиад туучхаж болохгүй. Ер нь энэ төрийн компаниуд бол яг энэ ерөнхий хуулиар бол явах ёстой. Тэгэхдээ тэгж байна гээд бас тэр компаниудын үйл ажиллагааг ялангуяа дотоодын оролцогч нарт тэр боломжийг нь тавьж өгч байгаа тэр зүйлүүдийг нь бас хязгаарлачхаад байж болохгүй юм байгаа юм. Ялангуяа тэр тээврийн компаниуд дээр үнэхээр зовлон гарч ирж байна лээ. Тэгэхээр хэдүүлээ намар хэлэлцэх байх. Энэ хууль. Тэр дээр их сайн анхааръя. Ялангуяа манай Эдийн засгийн байнгын хороон дээр тэр асуудлыг их сайн ярих ёстой шүү дээ. Тэр дээр нэлээн бэлтгэл хангаж байгаад ярилцацгаая.

Р.Сэддорж: 5 номер.

Т.Жамбаажамц: Сэддорж даргын асуултад хариулъя. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйл ажиллагаагаа иргэдэд хүргэх гэж байгаа бас нэг суваг бол энэ финтек буюу цахим технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ байж байгаа. Зээлийн үйлчилгээ. Өнөөдөр нийтдээ Монгол Улсад 67 банк бус санхүүгийн байгууллага финтек буюу энэ зээлийн үйл ажиллагаагаар бол финтекийн үйл

ажиллагаа цахим аппликэйшнээр дамжуулж зээл олгож байгаа. Ямар нэгэн барьцаагүй, хиймэл оюун ухаан, технологид суурилж тэр зээл авч байгаа иргэнийг бол тодорхой зайнаас төлбөрийн чадварыг нь тодорхойлж, зээл олгоод бол явж байгаа. Гол нь Санхүүгийн зохицуулах хорооноос бол энэ олон аппликэйшнээс зэрэг зээл авах, зээлийн дарамтад оруулахгүй байхад онцгой анхаарч ажиллаж байгаа. Үүний нэг хэлбэр нь бол зээлийн мэдээллийн санг яг цахим зээл дээр бол бодит цагийн горимоор нийлүүлэх ийм ажлыг бол хийж хэрэгжүүлж ажиллаж байна. Монголбанктай хамтраад.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Эдийн засагт тулгамдаж буй асуудлууд болон холбогдох байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээлэлтэй гишүүд танилцаж дууслаа.

19.32 цаг.

Санал хураалт явуулъя. Өмнөх асуудал руу орно.

Эхлээд Байнгын хорооны тогтоол Монголбанктай холбогдуулсан тогтоолыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлдье. Ирцээ хасъя. Улсын Их Хурлын гишүүд чөлөөг бичгээр, хүндэтгэх шалтгаантай хүмүүс бичгээр авсан байна.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 13.1.8 хуралдаан даргалагчийн эрх, үүрэг 13.1.8 дээр хүндэтгэн үзэх шалтгаантай гишүүнд чөлөө өгнө гэсэн ийм байгаа. Чөлөөг бичгээр авсан. Ингээд цахимаар авсан байгаа. Улсын Их Хурлын гишүүн Мандхай, Найдалаа, Батчимэг, Ганхуяг нарын гишүүд чөлөө авсан байна. Ирцээс хасаж өгнө үү. 4 гишүүн. Ингээд гишүүд санал хураалтдаа бэлдье. Батсүмбэрэл гишүүн, Жаргалан гишүүн, Ундраа гишүүн.

“Монголбанкны бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөх талаар авах арга хэмжээний тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.11.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

Нэг.Эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдал болон учирч болзошгүй эрсдэлийг харгалзан төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, ажил үүргийн давхардлыг арилгах зорилгоор орон тоог оновчтой байдлаар бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Монголбанканд даалгасугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ байгууллагын хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсгэхгүй байхад анхаарч, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа Улсын Их Хуралд танилцуулахыг Монголбанканд даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм найруулгаар баталъя.

Найруулгатай холбоотой, тогтоолтой холбоотой санал гаргах гишүүн Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Энэ тогтоол дээр эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдал болон гэж байгаа. Тэгээд гадаад нөхцөл байдал яг ямар байгаа юм. Дотоод нөхцөл байдал ямар байгаа юм гэдэг чинь өөрөө тодорхойгүй байгаад байна шүү дээ. Их сайн байхад нь бууруул гээд байгаа ч юм шиг. Энэ чинь түүх болоод үлдэнэ дээ энэ тогтоол. Тэгэхээр экспортын бүтээгдэхүүний үнэ буурч байгаа байдал ч гэдэг юм уу, тодорхой, тэр нөгөө ганган үгнүүд байдаг шүү дээ. Мөчлөг энэ тэр гээд. Тэгээд энийгээ тодорхой болгоод нөгөө гоё ганган үгнүүдээ энэ дээр бичвэл яасан юм. Тэгээд энэ чинь Монголбанкны түүхэнд үлдэх гэж байгаа том тогтоол шүү энэ чинь. Монголбанк гэдэг бурхан багштай адилхан болчихсон, зарлиг гаргадаг, Ерөнхийлөгчийн бас ажил төрөлтэй холбоотой асуудал ярьж байгаа учраас эдийн засгийн гадаад байдал нь ямар байгаа юм, дотоод байдал нь ямар байгаа юм. Монголбанкны өөрийнх нь сахилга батын асуудлыг дурдах хэрэгтэй шүү дээ. Энэ байгууллагын. Тэгээд энэ үрэлгэн байдал гээд тодорхой биччихсэн байна. Үрэлгэн байгаа юм байна. Сахилга батгүй байгаа юм байна энэ байгууллага. Дарга, цэрэггүй байгаа юм байна. Орлогч нар удирддаг болчихсон юм байна. Тэгээд энийг нь тодорхой бичиж өгвөл яадаг юм. Тэгээд тогтоолыг бол дэмжиж байгаа. Жоохон тодорхой байвал зүгээр байх гэж бодож байна. Найруулга дээр.

Р.Сэддорж: Ингээд тогтоолын эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдал хүндрэлтэй байгааг гээд Батсүмбэрэл гишүүний оруулсан саналаар байгааг болон учирч болзошгүй эрсдэлийг харгалзан төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажил үүргийн давхардлыг арилгах зорилгоор орон тоог оновчтой байдлаар бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Монголбанканд даалгасугай. Энэхүү тогтоолыг Батсүмбэрэл гишүүний оруулсан гадаад, дотоод нөхцөл байдал хүндрэлтэй байгааг сая нэмлээ. Ингээд саяын уншсанаар Монголбанкны бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөх талаар авах арга хэмжээний тухай тогтоолыг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.39 цаг.

Нийтийн өмчийн тухай хуулийн санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлдье. Бадамсүрэн гишүүн, Батсүмбэрэл гишүүн, Жаргалан гишүүн. Ингээд бүгдээрээ санал хураалтдаа идэвхтэй оролцоцгооё.

1.Нийтийн өмчийн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлал лийн хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Жаргалан гишүүн орж байна уу. Сайнзориг гишүүн.

Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд элсэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Шинжлэх ухаан технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39.Эрүүл эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн. Томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.““Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Нийтийн өмчийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна.

Хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

20.02 цаг.

Хэлэлцэх асуудал 7.

Байнгын хорооны тогтоолын төсөл байна.

Монгол Улсын дунд богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц тайлагналтын талаар Эдийн засаг хөгжлийн

яамны мэдээллийг сонссонтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсэгт заасныг үндэслэн байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулсныг та бүхэнд тараасан байгаа. Энэ тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Санаачилж байгаа гишүүнд протоколын хувьд зүгээр үлдээгээч. Би нөгөө Эдийн засаг, хөгжлийн яам ажлаа хийж чадахгүй болчих вий гэдэг дээр бас санаа зовоод байгаа юм. Уг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиа хэрэгжүүлээд л юмнууд орж ирнэ. Бид хэд хууль байсаар байхад дахин дахин ийм тогтоол баталж өгөөд, Засгийн газарт чиглэл өгнө гэдэг юмыг гайхаад л байгаа юм. Засгийн газар чинь угаасаа Үндсэн хууль болон бусад хуулиараа хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй шүү дээ. Тэгэхээр Бадамсүрэн гишүүн надад юу хариулаад өгөөч гэхээр энийг Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн Шадар сайд Учрал сайдтай ч юм уу яамныхтай ярилцаж асуудалгүй гэж хэлэлцсэн юм байгаа биз дээ. Тэгээд баахан ийм хууль давсан юм яагаад сүүлдээ намар ингээд юм оруулж ирж болдоггүй, үүнтэй нь зөрөөд байна гэдэг юм руу хэдүүлээ орчих вий. Тэгэхээр би зүгээр тодруулж протоколын хувьд үлдээлгэж байгаа шүү_ Тэрнээс өөр юм байхгүй.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүн тайлбар хэлье.

М.Бадамсүрэн: Манай Эдийн засгийн байнгын хорооноос 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлж бэлдэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг хэлэлцээд, ажлын хэсгийн гишүүд энэ дээр санал нэгдсэн гэдгийг бас хэлэх нь зүйтэй. Яагаад гэхээр энэ хуулиар зохицуулж чадаагүй, тухайлбал, энэ шалгуур үзүүлэлттэй холбоотой, мөн хөгжлийн төлөвлөгөө дээр ямар нэгэн хөрөнгө оруулалтын хэмжээ дээр зардлын дээд тааз заах юм уу, үгүй юм уу. Энийг тэр төсвийн хүрээний мэдэгдэлтэйгээ уялдуулах юм уу, үгүй юм уу гэх зэргээр шаардлагатай ийм саналаа оруулж ирэх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах, хэлэлцүүлэх, ил тод байлгах, батлуулах, энэ үйл явцыг илүү сайжруулах шаардлагатай гэж үзэж, энийг боловсруулсан байгаа. Манай ажлын хэсгийн гишүүд өөрөөр хэлбэл ажлын хэсгийн гишүүд ажилсан ажлаа үр бүтээлтэйгээр дуусгая гэдэг, хаалтаа хийе гэдэг ийм зүйл дээр санал нэгдсэн.

2 дугаарт нь Эдийн засаг, хөгжлийн сайд энэ тогтоолын төслийг танилцсан. Тэгээд мэдээллээ хийгээд, тэгээд энэ бол хэрэгжүүлэхэд болно. Үүнтэй танилцлаа гэдэг ийм саналаа хэлсэн гэдгийг хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Тогтоолын төслийг уншъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Засгийн газарт чиглэл өгөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны

танилцуулгатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасгай.

1.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан хугацаанд багтаан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээг Улсын Их Хуралд танилцуулах;

1.2.Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4-д заасан хугацаанд багтаан Засгийн газарт танилцуулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

1.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1, 6.10.2 дахь заалт болон 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулах;

1.4.Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах Улсын төсвөөс санхүүжих шаардлагатай төсөл, арга хэмжээг тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцүүлэн боловсруулах;

2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд

3.Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.1, 6.10.2 дахь заалтын дагуу Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл арга хэмжээг эрэмбэлсэн байх шаардлагыг бүрэн хангуулах. Тухайн жилийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийн хоорондын уялдааг ханган боловсруулж байх.

4.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төсөл арга хэмжээг нарийвчилсан байршил, төсөв зардлын дүнтэйгээр тусгах эсэх, эсхүл бүсүүдэд болон нийслэлд хэрэгжүүлэх гэсэн байдлаар тусгах эсэх, тухайн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нийт дүнгээр нь ангилж тусгах эсэх талаар тус тус судлан аль оновчтой хувилбарыг сонгох.

5.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгах төсөвт шаардагдах ажлуудын нийт зардлын дээд хязгаарыг хуулиар тогтоох эсэх, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэлтэй хэрхэн нийцүүлэх талаар судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах эсэх саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн жилийн төсвийн саналыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалтын дагуу хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлж тус төлөвлөгөөнд нийцүүлэн нэгтгэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан төсвийн төслийг өргөн мэдүүлж, нийтэд ил тод мэдээлэхдээ Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг

үндэслэн эрэмбэ тогтоосон баримт бичгийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай. Эдийн засгийн байнгын хорооны дарга.

Тогтоолын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэлээр тасалъя.Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Тогтоолын 2 төсөл яваад, би учрыг нь сая л ойлголоо. Тэгээд Жаргалан гишүүн 1 нэмэлт юм оруулж байгаа юм байна. Тэгээд энэ заалтууд нь тэр 1.1, 1.3 энэ тэр бол хууль дээр байгаа юмыг давхардуулсан маягтай л харагдаж байна. Уншихад бол. Тэгээд тэр 1.2 дээр Ерөнхий сайдыг бичээд Шадар сайдыг араас нь бичих заавал шаардлага байгаа юм уу. Найруулга талаас нь харахад.

2 дахь нь тэгээд саяын Сайнзоригийн хэлж байгаатай л төстэй байна л даа. Нөгөө баахан ажлууд хийх гэдэг. Энэ намар чинь бид нар хүндрэлтэй байна л гэж яриад байгаа. Алт хөтөлбөр гээд л яриад эхэлсэн. Алт хөтөлбөрөө аваачаад чөдөр тушаа болчихсон ч юм шиг байдалтай бид нар маргаантай байдалтай л зогсчихсон байгаа шүү дээ. Хэлэлцүүлэг. Тэгэхээр энэ ажил чинь өөрөө цаашдаа энэ Засгийн газраа, Эдийн засгийн яамаа, Сангийн яамаа ажил хийхэд нь их төвөгтэй байдалтай болох юм биш үү. Энэ байдлыг тогтоол санаачлагч нар болон тогтоол дээр нэмэлт засвар оруулж ирж байгаа гишүүд юу гэж ойлгож, бодож байгаа юм. Тэр хууль санаачлах, хуулиар тогтоох асуудлыг нь заавал тогтоол гаргахгүйгээр Байнгын хорооны хурлын тэмдэглэлээр явчхаж болохгүй байгаа юм уу. Тэгээд энэ дахиад хэрэгждэггүй тогтоол гараад явчих вий дээ. Энэ дээр чинь асуулт асууж болох билүү, болохгүй билүү. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариулж болох билүү. Бямбацогт сайдыг энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн автор гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тогтоолууд та ер нь үзсэн үү. Тэгээд ер нь Засгийн газрын ажил хийхэд хэрэгтэй тогтоол болоод байна уу. Чөдөр болох гээд байна уу. Тэгээд чөдөр болгох юм хэдүүлээ бас хийгээд баймааргүй байгаа юм. Их Хурал эргээд Засгийн газраасаа шаардлага тавьж болдоггүй. Тэгээд мөн Жаргалангийн оруулж байгаа тэр нэмэлт задалсан заалтууд бол бүр л хэрэггүй л шахуу л юм харагдаж байна. Тэр 1.1, 1.3 энэ тэр бол. Тэгээд заавал ч үгүй тэгээд 2 сайдын нэр заавал давхардаж бичих гээд техникийн юмнууд харагдаад л байх шиг байх юм. Тэгээд эндээ хариулт аваадахъя.

Р.Сэддорж: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлаад, энэ анхдагч хууль 2020 оноос эхэлж хэрэгжиж эхэлсэн байгаа. Тэгээд үүгээрээ бид нар яасан гэвэл төрийн бодлого тодорхой байх, тогтвортой байх, харилцан уялдаатай байх асуудлыг шийдсэн. Тэгээд 2021-2025 онд анхны 5 жилийн үндсэн чиглэлийг Их Хурал баталсан. Биелэлт нь их тааруу гарсан. Цаашаагаа дараагийн 5 жилийн төлөвлөгөө бас 2025-2030 он хүртэлх энийг Улсын Их Хурал батлах ёстой. Энэ бол үндсэндээ чиглэл өгч байгаа нь зөв гэж харж байгаа. 2026-2030 онд Монгол Улсыг хэрхэн яаж хөгжүүлэх вэ. Энэ дээр 1 дутуу орхигдсон зүйл бол бид нар урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 энэ 30 жилийн хугацаатай бодлоготой. Дунд хугацааны зорилтот хөтөлбөр гээд бид нар 8 төрлийн зорилтот хөтөлбөр батлах ёстой. Үүнээс ганцхан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд ганцхан зорилтот хөтөлбөр баталсан байгаа. 7 бас бодлогын бичиг баримт

батлаагүй байгаа. Эдийн засгийн, нийгмийн, байгаль орчны гээд ингээд 7 төрлийн бичиг баримт, зорилтот хөтөлбөр 10 жилийн хугацаатай батлаагүй байгаа. Энийг энэ тогтоол дээр заагаагүй байна. Тусгаагүй байна. Тийм болохоор нэгэнтээ Засгийн газарт чиглэл өгч байгаа бол энэ орж ирэхгүй байгаа дунд хугацааны бодлогын бичиг баримтуудыг хурдан оруулж ир гэдэг чиглэлийг Их Хурлаас өгөх ёстой. Энэ орхигдсон байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөө жилийн төсөв 2 бас хоорондоо уялдахгүй байгаад байгаа асуудал байгаа. Энийг бид нар яаж уялдуулах вэ, ерөөсөө л төлөвлөлт чухал гэдгийг л энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд хийж өгмөөр байгаа юм. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиар төлөвлөлт чухал гэж үздэг боловч нөгөө талд нь Сангийн яам Төсвийн тухай хуулиараа Төсвийн хууль суурь хууль учраас Төсвийн тухай хуулиа барина гээд Их Хурлын баталсан төлөвлөгөөг ерөөсөө тоодоггүй. Энийг бас бид нар цэгцлэхгүй бол ингээд хууль хоорондын зөрчил бас гараад байгаа. Тэгэхээр 2 хуулийг хооронд нь нийцүүлэх, уялдуулах ерөөсөө л Монгол төрийн эхлээд төлөвлөдөг байя. Урт, дунд, богино хугацаандаа харилцан уялдаатай байя. Дээрээс нь салбар дундын зохицуулалтыг бас уялдуулах ёстой. Мөн бас бүс орон нутгийг уялдуулах ёстой. Энэ уялдаануудыг харж байгаад оруулж ирэх асуудал бас оруулах ёстой байх. Тэгэхгүй бол энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль дээр гараад байгаа 1 асуудал бол яг энэ салбар дундын зохицуулалт, бүс орон нутгийг хооронд нь бас уялдуулах, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хүртэл баталсан мөртөө бид нар баруун бүстээ уг нь санаа бол Улаанбаатартай адилхан таталцлын төвүүдийг бүс болгондоо бий болгох ёстой байдаг. Гэтэл ингээд ерөөсөө аль аймаг нь яаж ялгарах юм, давуу тал дээр яаж тулгуурлах юм, аль нь яг таталцлын баруун бүсийн төв нь болох юм. Өмнөд бүсэд ямар таталцлын төвтэй болох юм. Зүүн бүсэд аль аймаг нь илүү таталцлын төв болох юм гэдэг нь тодорхойгүй байгаад байгаа болохоор үндсэндээ Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, Улаанбаатар гэсэн ганцхан таталцлын төвийг задлах энэ бодлого .../минут дуусав/

Р.Сэддорж: Бямбацогт сайд 1 минут.

С.Бямбацогт: Тийм болохоор Засгийн газарт бас чиглэл өгөөд, үндсэндээ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиа хэрэгжүүлбэ, энэ гараад байгаа алдаа дутагдлыг уялдаагүй, хууль хэрэгжихгүй байгаа хуулийн хийдэл, энэ бүгдийг цэгцэлье гэсэн тогтоол гарах нь бол зөв. Гарахдаа хамгийн гол нь дутуу орхигдсон зүйлүүд харагдаж байх шиг байна. Энийгээ бас нэмээд оруулаад, илүү сайжруулаад оруулчихвал бас үр дүнтэй болох болов уу л гэж хэлье дээ.

Р.Сэддорж: Бямбацогт сайд гүйцээж, сайжруулж оруулж ирэх хэрэгтэй гэж үзэж байна уу. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тийм. Өнөөдөр Эдийн засаг, хөгжлийн яам руу ямар асуудал орхигдсон байна гээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас саналыг нь аваад, маргааш Байнгын хороогоор оруулаад, тэгээд чуулганаар цохиулчхаж болох байх гэж бодож байна. Тийм байна. Байнгын хорооны тогтоол юм байна. Чуулганаар орохгүй шүү дээ. Тийм болохоор нөгөөдөр ч Байнгын хороо хуралдаад баталчхаж болно.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Энэ тогтоолын төслийг болохоор Бадамсүрэн гишүүн бас санаачлаад Эдийн засгийн байнгын хорооны өмнөх 7 хоногийн хурал дээр анх оруулж ирсэн. Тухайн үед болохоор дөнгөж гар дээрээ авсан учраас тэр үед болохоор Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй

албан хаагч нар танилцуулга хийсэн юм. Тэгээд түүнтэй холбоотойгоор миний оруулж ирсэн тэр сүүлийн хэдэн заалтуудыг болохоор Эдийн засаг, хөгжлийн яамныхантай хамт сууж байгаад уг нь томьёолсон ухаантай байхгүй юу. Аль болох ийм хуулийн биелэлтийг хангаж ажиллах талаар. Тэгэхээр Бадамсүрэн гишүүний санааг бол дэмжиж байгаа. Юу вэ гэхээр ер нь энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтөө Улсын Их Хурал цаг тухайд нь Засгаас бас шахаж шаардаж байх ёстой гэсэн агуулгаар. Тэгээд нөгөө 5 жилийн үндсэн чиглэл болохоор бас яг нөгөө хугацаа нь дуусаагүй байгаад байгаа шүү дээ. 8 сарын сүүлээр дуусах ёстой байгаад байгаа. Тэгэхээр тэр хугацаа нь болмогц нь л даруй оруулаад ир. Тэгээд ар араас нь бусад нөгөө жилийн төлөвлөгөөнүүдээ батлаад, яг түүнийхээ дагуу төсвөө батлаад явъя гэсэн санааг л агуулж байгаа ийм тогтоол гэж ойлгоод байгаа. Тэгээд тогтоолын төслийг бол агуулгын хувьд бол дэмжээд байгаа юм. Хөгжлийн яамны саналууд бол уг нь тэр эхний томьёолсон 4, 5 заалтын хүрээнд бол орсон юм. Тэрийг би бодож олоогүй, Хөгжлийн яамны залуучуудаас асуугаад, яг ямар хуулийн заалтуудыг та нар оруулбал зүгээр гэж бодож байна гэдэг агуулгаар уламжилж байгаа байхгүй юу. Тэгэхээр уг нь тэр ажил бол түрүүчийн 7 хоногт хийгдээгүй биш, хийгдсэн. Магадгүй бүр илүү сайжруулах ёстой гэж үзэх юм бол бас Байнгын хорооны гишүүд олонхоороо шийдэх нь зөв байх.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүн томьёоллоо товч уншъя.

М.Бадамсүрэн: Манай байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэг ер нь ажил хэрэгчээр энэ ажлын хэсгийнхээ ажлыг өндөрлүүлж байгаа юм. Энэ магадгүй шинэ жишиг байж магадгүй гэж бодож байгаа. Тийм учраас энэ тогтоолын төслийг та бүхэн маань дэмжиж өгөөч. Сая Бямбацогт сайдын хэлдэг тэр дунд хугацааны буюу тэр 8 зорилтот хөтөлбөрөөс 1 нь бол бүсчилсэн хөгжлийн бодлого нь батлагдчихсан байгаа. Тэгэхээр үлдсэн 7 зорилтот хөтөлбөрийг агуулгаар нь буюу дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хуульд заасан хугацаанд боловсруулж батлуулахыг гээд. Яагаад гэхээр ингэж салбарын стратеги гэж хэлж болохоор энэ бодлогыг батлуулахгүй болохоор хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр бүх зүйлүүд маань орж ирэхгүй байгаа юм. Нийгмийн талын зүйл, уул уурхайн, байгаль орчны гээд энэ зүйлүүдийг бүхэлд нь боловсруулаад авчих юм бол цаашдаа үүндээ нийцүүлж, урт, дунд, богино хугацаандаа төсвөө зөв төлөвлөх, Эдийн засаг, хөгжлийн яам зөв төлөвлөлтөө хийгээд, тэгээд манай мэргэжлийн Байнгын хороо энэ дээр нь танилцаад, тэгээд бодлоготой, чиглэлтэй явахгүй бол гэнэт санаандгүй 1 төсөв, гэнэт энэ төсвийг оруулъя гэвэл тэр байдлаар ороод байх нь буруу байна гэж бид бол оношилсон. Тэгэхдээ энийг бол манай ажлын хэсэг бол маш олон талаас нь ярилцаж, маш ажил хэрэгчээр энэ дээр хандаж, энэ Байнгын хорооны тогтоолыг боловсруулсан. Тэгээд манай Жаргалан гишүүн бас идэвхтэй Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтарч, бас нэмэлт саналуудыг оруулж байгаад бас их баяртай байна. Ажил хэрэгчээр бас цаг зав гаргаж, энэ тогтоолын төсөл дээр саналаа өгсөн Жаргалан гишүүнд бас баярлалаа.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Бадамсүрэн гишүүний санаачилга бол зөв юм. Дэмжээд байгаа юм. Тэгэхдээ саяын яриад байгаа юмнуудыг нэмж оруулах нь зөв байна. Дээр нь энэ тогтоол дээр дахиад жоохон ажиллах асуудлууд байна. Тэгээд Байнгын хороо батлах учраас энэ чинь маргааш, нөгөөдөр чуулган хаасны дараа ч Байнгын хороо хуралдаж болж байгаа юм. Одоо тэгээд бушуу туулай борвиндоо баастай гэж яаран сандран ийм тогтоол өнөөдөр заавал батлах шаардлагагүй байна гэж би Жаргалан, Бадамсүрэн 2 журмын нөхөртөө бас хэлж байна. Тэгээд энэ тогтоолоо

дэмжиж байна. Тэгээд яг өнөөдөр батлаад яах вэ гэсэн ийм саналтай байна. Саяны Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын энэ хуулийг санаачилж хийсэн хүнийхээ хувьд оруулж байгаа тэр саналуудыг бас оруулах нь зөв. Тэгээд энийг энгийн байдлаар, өргөн хүрээтэй, бодитой дорвитойхон тогтоол гаргая гэсэн ийм саналтай байна.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтад оръё. Бадамсүрэн гишүүн санал хураалтад бэлдье. Батсүмбэрэл гишүүн, Жаргалан гишүүн болсон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг үндэслэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бүгд бэлэн үү. 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэг хийхэд өөр саналтай гишүүд байна уу. Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Тогтоолын үзэл санааг бол дэмжиж байгаа. Жаргалан гишүүн ээ, тэгээд хэлж байна шүү дээ. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль дээр байгаа зарим он цаг юмнууд давхардаж байна. Зарим заалтуудтай нь миний харж байгаагаар. Хууль дээр байж байгаа юм чинь.

2-т нь саяын яриад байгаа тэр дунд хугацааны хөтөлбөр төлөвлөгөөг яаралтай оруулж ирэх заалтыг нэмээд, дараагийн хурлаар оруулж хэлэлцүүлэх ийм горимын саналыг гаргаж байна Сэддорж дарга аа. Тэгээд Жаргалан, Бадамсүрэн хоёрынхоо тогтоолыг бол дэмжиж байгаа. Тэгээд энэ саналуудыг нэмье.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн горимын санал гаргая. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Саналаа өгч амжсангүй. Тийм учраас саяын саналыг хүчингүй болгоод, Батсүмбэрэл гишүүнийхээр хойшлуулаад дараагийн хурлаар баталгаажуулчихъя. Саяын саналыг хүчингүй болгож өгнө үү.

Р.Сэддорж: Ингээд Сайнзориг гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 64,3 хувийн саналаар санал эмжигдлээ.

Ингээд Батсүмбэрэл гишүүний гаргасан саналын дагуу “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлууллаа.

20.26 цаг.

Хэлэлцэх асуудал ганцхан асуудлыг сонсоно.

Хадгаламжийн даатгалын корпорацын өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаар мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал Сүхбаатарын Баатарсүрэнг мэдээллээ танилцуулахыг урьж байна. Микрофоныг нээе. Ажлын хэсгийн 3 номер.

С.Баатарсүрэн: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүдийн оройн амгаланг айлтгая.

Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал Баатарсүрэн. Хадгаламжийн даатгалын корпорацийн ерөнхий танилцуулга, чиг үүрэг, тэгээд Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийн өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулъя. Дэлгэрэнгүй танилцуулга мэдээлэл бас гишүүдэд хүргэгдсэн байгаа байх.

Хадгаламжийн даатгалын корпораци маань 2013 онд Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдсанаар үүсгэн байгуулагдсан. Гол зорилго нь бол иргэдийн банканд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, банкны салбарын сахилга батыг сайжруулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах ийм үндсэн чиг үүрэгтэй. Бас хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах.

Үндсэн үйл ажиллагаа нь бол даатгалын хураамжийг төвлөрүүлэх, даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид нөхөн төлбөр олгох, сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу удирдах, банкнуудын санхүүгийн эрсдэлийг үнэлэх замаар банкны салбарын эрсдэлийг бууруулах үндсэн чиг үүрэгтэй.

Корпораци маань өөрөө албан журмын даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч, төрийн өмчит хуулийн этгээд байгаа. Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийг бол даатгалын тохиолдол бий болохоос өмнө урьдчилан бүрдүүлдэг. Тэгээд ижил суурьтай буюу бүх банкнуудад ижил хэмжээний даатгалын хураамжийг тогтоох байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг байгаа.

Банкин дахь харилцах хадгаламжийн дансны 20 сая төгрөг хүртэлх харилцах хадгаламжийг даатгадаг. Нийт арилжааны банкнууд бол Хадгаламжийн даатгалын корпорацийн албан ёсны гишүүн. Даатгагдсан байгууллагууд нь байгаа.

Банк татан буугдаж, даатгалын тохиолдол бий болоход даатгалын нөхөн олговор олгох үйл ажиллагааг ажлын 10 хоногт эхлүүлж, нөхөн төлбөрийг 3 жилийн хугацаанд хийж дуусгах тийм үндсэн үүрэгтэй.

Хадгаламжийн даатгалын корпорацийн удирдах дээд байгууллага нь бол Хадгаламжийн даатгалын үндэсний хороо байгаа. Үндэсний хорооны дарга нь бол Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч байдаг. Тэгээд санхүү төсвийн асуудал эрхэлсэн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, тэгээд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн санал болгосон 3 гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Дэд дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр Хадгаламжийн даатгалын үндэсний хороог үйл ажиллагаа явуулдаг. Одоо хадгаламжийн даатгалын корпораци маань 3 газар, 7 нэгжтэйгээр 58 хүн, тэгээд дээрээс нь түрүүн бас танилцуулсан дотоод аудитын нэгжийг оруулах юм бол 62 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа.

Хадгаламжийн даатгалын корпораци маань бас олон улсын хадгаламжийн даатгагчдын холбооны гишүүн байгууллага. 100 гаруй орны гишүүнчлэлтэй олон улсын хадгаламжийн даатгагчдын байгууллага байгаа. 9 бүсэд хуваа хуваагдаж үйл

ажиллагаа явуулдаг. Монгол Улс бол Евро-Ази болоод Азийн бүсийн холбоонд давхар харьяалагддаг. 2022 оноос манай улс өөрөө Евро-Азийн бүсээ бас тэргүүлж ажиллаж байгаа. Манай бүсэд 8 орон үйл ажиллагаа явуулдаг ийм байдалтай байгаа.

Голлох хийгдсэн ажлууд гэвэл 2013 онд байгуулагдсанаас хойш Капитал банк, Хадгаламж банкийг татан буулгах ажлыг зохион байгуулж, даатгалын нөхөн төлбөрийг олгосон. Тэгээд олон улсын шинж чанартай яг гол бодлогын шинж чанартай 2 удаагийн томоохон уулзалт, хурлыг бид нар зохион байгуулсан байгаа.

2018 онд Хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орж, Хадгаламжийн даатгалын корпорац маань өөрөө Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллага болсон. Мөн хадгаламжийн даатгалын мандат нь бас өөрчлөгдсөн байгаа. Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө бол 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 831 тэрбум төгрөг байгаа. Үүний 557 тэрбум төгрөг нь бол хадгаламжийн даатгалын хураамжийн орлогоор бүрдүүлсэн. 345 тэрбум нь болохоороо Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтаас олсон өгөөжийн орлогоор бүрдүүлсэн ийм байдалтай байгаа.

Хуулийн дагуу бол нийт хадгаламжийн дүнгийн 10 хувьд хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө хүрэхэд бол хөрөнгө хуримтлуулах үйл ажиллагаагаа зогсоож болно. Ерөнхийдөө хангалттай боллоо гэж үзэхээр байгаа. Манайд энэ тоо бол ерөнхийдөө 2 орчим хувь дээр явж байгаа. Тэгэхээр Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө бол бас яг одоогийн энэ банк санхүүгийн салбарынхаа эрсдэлийг хаахуйц хэмжээнд бол хүрээгүй байгаа.

Дэлхийн банктай хамтраад бид нар бас судалгаа хийгээд шаардлагатай түвшинд ямар хугацаанд хүрэх вэ гэдэг ажлуудыг бол тогтмол хийж, тестэлж үзэж байдаг. Ерөнхийдөө бол 7-12 жилийн хугацаанд Хадгаламжийн даатгалын сан бол өнөөдрөөс цааш хангалттай хөрөнгөтэй болно гэдэг тийм судалгаа явж байдаг.

Нийт харилцах хадгаламжийн хэмжээ бол 44,7 их наяд төгрөг байгаа. Үүнээс даатгагдсан харилцах хадгаламж нь болохоороо 10,6 их наяд. Даатгагдсан хадгаламжид хадгаламжийн даатгалын эзлэх хувийн хэмжээ нь бас 7,8 хувьтай байгаа. Тэгээд энэ нь өөрөө бас дахиад өөр зорилтот түвшний бас судалгаанууд дээр ашиглагддаг байгаа. Хамгийн сүүлд хийсэн судалгаагаар бол энэ 7,8 хувийг бид нар 15 хувьд хүргэхэд бас хадгаламжийн даатгалын сангийн хүрэлцээ бол хангалттай байхуйц бас түвшинд очих юм байна гэдэг асуудал яригдаж байгаа. Тэгээд мөн л адилаар нөгөө түвшиндээ хүрэхийн тулд 10 орчим жилийн хугацаа бид нарт дахиад хэрэгтэй байгаа.

Товчхондоо Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө бол системийн нөлөө бүхий 5 банкин дээр ямар нэгэн байдлаар хүндрэл буюу нөхцөлтэй байдал үүсээд татан буугдах ажиллагаа хийгдэхэд бол коверлож хүрэхээргүй байгаа. Системийн нөлөө бүхий биш банкнууд бүгдээрээ нийлээд Хадгаламжийн даатгалын сан бүрэн .../минут дуусав/

Р.Сэддорж: Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Лувсанжамц гишүүнээр тасалъя. Байхгүй. Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Танилцуулга хийсэнд баярлалаа. Ганцхан асуулт байна. Хүснэгт 4 дээр Хадгаламжийн даатгалын хураамж төвлөрүүлсэн мэдээлэл 2025 оны 2 дугаар улирлаар тэрбум төгрөгөөр гэж байна. 0.33.Чингис хаан банк төлөгдөөгүй дүн 0,8 хувь, Үндэсний хөрөнгө оруулалтын банк төлөгдөөгүй дүн 0,65 гэсэн ийм 2 тоо байна. Энэ 2 банкин дээр ер нь ямар арга хэмжээ авдаг юм бол. Эсвэл энийг яах хэрэгтэй юм. Бүгд адилхан төлөөд явж байхад 1, 2 банк нь төлөхгүй ингээд яваад байж болдог юм уу. Ямархуу тайлбар хэлж байгаа юм бол. Үндэслэлийг нь сонсмоор байна. Тэгээд цаашдаа авах арга хэмжээ юу төлөвлөж байгаа вэ гэдэг үндсэн асуулт асууя.

Р.Сэддорж: 4 номер.

Г.Энхтайван: Гишүүний асуултад хариулъя. Үндэсний хөрөнгө оруулалт, Чингис хаан банктай холбоотой асуудал 2019, 2020 оноос хойш бол эхлээд явж байгаа. Төв банкны зүгээс энэ 2 банкиг тогтворжуулах төлөвлөгөө хэрэгжүүлээд явж байгаа. Яг өнөөдрийн нөхцөл байдалд яг одоо байгаа санхүүгийн нөөцөөрөө бол энэ 2 банк өөрт байгаа тэр хадгаламжийн хэмжээнд тохирсон даатгалын хураамжийг бол төлөх боломжгүй байгаад байгаа юм. Мөн төв банкнаас тавьдаг заавал байлгах нөөцийн хэмжээг ч бас төлөхгүй яваад байгаа. Энэ дээр бол төв банк торгууль тавиад явж байгаа. Ер нь бол энэ 2 банктай холбоотой асуудлыг бол төв банк тогтворжуулаад, илүү түргэн хугацаанд сэргээн босгох, банкиг дунд хугацаанд буцаад хэвийн байдалд оруулахаар тийм төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа. Энэ хүрээнд бол банкны хувьцаа эзэмшигч нар нэмэлт хөрөнгө оруулагч олж ирэх, гадаадаас нэмэлтээр хувьцаа гаргаж, түүндээ байгаа телевишн гэж ярьдаг шүү дээ. Хувьцааг дайлютед болгоод шинэ хувьцаа гаргаад, түүндээ хөрөнгө оруулагч оруулж ирэхээр бол төлөвлөгөөг Төв банканд өгөөд ажиллаж байгаа.

Чингис хаан банктай холбоотой бол гадаадын хөрөнгө оруулагч сонирхож байгаагаа илэрхийлсэн. Төв банканд бол албан бичиг ирүүлээд байгаа.

Үндэсний хөрөнгө оруулалтын банкин дээр ч гэсэн өмнөх өнгөрсөн 2024 онд бол хэд хэдэн гадаадын хөрөнгө оруулагч сонирхож байгаа гэсэн албан бичгийг ирүүлсэн.Одоо хувьцаа эзэмшигчдтэй бол хэлцлийн шатад л явж байгаа. Нэмэлтээр хөрөнгө оруулалт орж ирсэн тохиолдолд бид бүхэн энэ Хадгаламжийн даатгалын энэ хураамжийг нөхөн төлүүлнэ.

Р.Сэддорж: 3 номерыг үргэлжлүүлж хариулъя.

С.Баатарсүрэн: Лувсанжамц гишүүний асуултад Дэд ерөнхийлөгчийн хариулт дээр нэмээд хариулчихъя. Хадгаламжийн даатгалын корпорацын зүгээс бол энэ хураамжаа төлөхгүй байгаа банкнууд дээр зөрчлийн хэрэг нээж байгаа. Улсын байцаагч нар. Тэгээд зөрчлийн хэргийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шалгаад, шүүхийн процесс руу орж байгаа. Тэгээд төлүүлэх шийдвэр гаргах, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэх иймэрхүү яг зарчмаар ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Энэ хадгаламжийн даатгалтай холбоотой хэмжээ хуулиараа 20 сая төгрөг байгаад байгаа. Тэгэхээр ер нь цаашдаа энэ 20 сая төгрөгийг одоогийн зах зээлийн нөхцөл байдалтай харьцуулж үзэхэд энийг цаашдаа нэмэгдүүлэх талаар та бүхний санал ер нь ямар байдаг юм бэ. Энэ дээр бас арилжааны банкнууд өсгөх санал гаргаж байсан санагдаад байна.

2-т болохоор бол Монголын банкны холбооноос бас арилжааны банкнууд гадаад валютын хадгаламж, гадаад валютын харилцах дансыг жишээлбэл хадгаламжийн даатгалд хамрагдахгүй байх талаас нь санал гаргавал ямар вэ гэдэг санал тавьж байсан. Энэ тал дээр та бүхний санал ер нь ямар байдаг юм гэж асуумаар байгаа юм.

Дээрээс нь болохоор хадгаламжийн даатгал маань өөрөө 20 сая төгрөгөөр ингээд хязгаарлагдчихаад байдаг. Гэтэл нөгөө даатгалын нийт хэмжээгээ бодож байгаа дүн маань өөрөө харилцах хадгаламж 20 сая төгрөгөөс их дүнтэй үлдэгдлээс бодоод байдаг. Энэ дээр бас арилжааны банкнууд энэ хувийг багасгах тал дээр анхаарвал сайн байна гэдэг асуудал яриад байдаг л даа. Тэгэхээр энэ дээр та нарын өөрсдийн чинь ерөнхий төлөвлөгөө ер нь ямар байгаа юм бэ гэж асуумаар байна.

Дараагаар нь болохоор Хадгаламжийн даатгалын корпорац Төрийн банкны тодорхой хувийг эзэмшдэг санагдаад байна. Тэгэхээр Төрийн банкны хувь эзэмшлээ ямар байдлаар хэрэгжүүлж байна вэ. ТУЗ-ийн гишүүдийн хэдийг нь Хадгаламжийн даатгалын корпорац өөрөө хувь эзэмшигчийн хувьд саналаа өгч санал болгож байгаа вэ гэдэг ийм асуултууд байна.

Р.Сэддорж: 3 номер хариулъя.

С.Баатарсүрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. 20 сая төгрөгийн хадгаламжийн даатгалын даатгаж байгаа энэ хэмжээг нэмэгдүүлэх ажил бас бид нар дээр яригдаж байгаа. Энэ өөрөө хуулиараа 20 сая гээд заагаад өгчихсөн байдаг учраас бас хуульд өөрчлөлт оруулах ажил байгаа. Өнгөрсөн жил хөндлөнгийн байгууллагаас хөндлөнгийн судлаачдыг авч бид нар ажиллуулаад, ер нь энэ 20 сая төгрөг ямар байвал зохимжтой вэ гэдэг ажлыг бас хийлгэж үзсэн. Тэгээд яг одоогийн түвшинд бол 50-60 сая төгрөг болох боломжтой. Ер нь бол дундаж нөгөө хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийн хэмжээ нь нэмэгдчихсэн.

2013 онд энэ хууль анх гарч байх үед бас энэ 20 сая чинь өөрөө 13 мянга орчим доллар байсан. Яг энийг нь ингээд бодохоор энэ чинь 50 орчим сая төгрөг ч юм уу ийм болчихсон байгаа. Тэгэхээр энийг бол нэмэгдүүлэх ажил хийгдэнэ. Хийхээр бид нар бас ийм үе шаттай ажлууд хийж байгаа.

Ковидын үед бид нар долларын харилцах хадгаламжийг хураамжаас чөлөөлөх арга хэмжээг ковидын хуулиар авч ажиллаж байсан. Энэ бол яах вэ, нөгөө долларжуулалтаас сэргийлэх, иргэд төгрөгийн харилцах хадгаламжаа доллар луу илүү хөрвүүлэхээс сэргийлж байгаа ийм арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан. Яг одоо бол энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэх ер нь бол шаардлага багатай байна гэж бас үзэж байгаа. Нийтлэг ерөнхий олон улсынх нь зарчим нь бол валют байхаас үл хамаараад, дотоодын төгрөг байхаас үл хамаараад шууд хураамжаа авдаг байдалтайгаар ийм жишиг явж байдаг.

Тэгээд дээрээс нь түрүүн бас дурдсанчлан нөгөө сангийн хүрэлцээ хангалтгүй байгаа учраас Хадгаламжийн даатгалын санг л бид нар ер нь аль болох өсгөх шаардлагатай байгаад байгаа.

Хадгаламжийн даатгал авч байгаа сууриа нөгөө даатгагдаж байгаа хадгаламжаас авах уу, нийт хадгаламжаас авах уу гээд энэ бас яг нөгөө банкнуудаас тавьдаг асуулт байгаа. Үндсэн хуулийн цэцээс хүртэл яг магадалгаа гарсан. Тэгээд бас л мөн адил яг энэ олон улсын 100 гаруй гишүүн байгууллагуудаас

авсан судалгаагаар үзэхэд бол ерөнхийдөө 60 орчим хувь нь нийт хадгаламжаасаа авдаг. Тэгээд энийг яаж тайлбарладаг вэ гэхээрээ ерөнхийдөө энэ хадгаламжийн даатгалын тогтолцоо гэдэг маань өөрөө санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилготой учраас санхүүгийн салбараа хамгаалж байна гэдэг утгаараа нийт харилцах хадгаламжаасаа хураамж авч, даатгалын сангаа бүрдүүлдэг байх нь зүйтэй юм гэдэг систем явж байгаа.

Манайх Төрийн банкны 45 хувийг эзэмшдэг. Хадгаламж банкныг татан буулгаад, гүүр банк Төрийн банкныг байгуулж, сайн активыг нь Төрийн банк руу шилжүүлэх ажиллагаа хийгдсэн. Одоогийн яг манай эзэмшлийн хувь IPO-н дараа бол 44,6, 45 орчим хувь байгаа. Яг бид өөрсдөө .../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер 1 минут.

С.Баатарсүрэн: Төлөөлөн удирдах зөвлөлд нь орж, яг энэ төлөөлөх эрхээ бас хэрэгжүүлэхгүй байгаа. Энийгээ Сангийн яаманд төлөөлөх эрхээ шилжүүлж өгдөг байгаа. Яг энэ хувь эзэмшилтэй холбоотойгоор бас Хадгаламжийн даатгалын корпорац нь энэ Төрийн банкны хувь эзэмшлээ дуусгая, энэ хувьцаагаа заръя, шилжүүлбэ гэдэг хүсэлтийг бол холбогдох Засгийн газарт болоод Монголбанканд удаа дараа манай байгууллагын зүгээс бол гаргаж тавьж байгаа.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулж асууя. Батнайрамдал гишүүнийг нэмээрэй.

Л.Соронзонболд: Хөрөнгө оруулалтын чинь бараг 64 хувь нь болохоор Засгийн газрын олон улсад гаргасан үнэт цаасанд байршдаг юм байна. Тийм ээ. Тэгэхээр үүнийг дагаад ер нь бол 2024 оны танай үйл ажиллагааны орлого, зардлыг харахаар 2024 онд жишээлбэл хэдэн төгрөгийн ашигтай ажилласан бэ. Ханшийн тэгшитгэлийн орлого тэр дотроо хэдэн хувийг эзэлдэг вэ гэсэн ийм асуултууд байна.

Р.Сэддорж: 3 номер.

С.Баатарсүрэн: Хадгаламжийн даатгалын санг болохоор яг хуульд заасны дагуу Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаас, тэгээд Засгийн газрын баталгаатай үнэт цаас гээд ерөнхийдөө 3-4 санхүүгийн хэрэгсэлд оруулах заалттай. Банкин дээр депозит хэлбэрээр ч юм уу байршуулах бол боломж байхгүй. Монголбанкны харилцах дансанд манайх мөнгөө байршуулдаг байсан юм. Монгол банк тодорхой хэмжээний хүү бодож өгдөг. Тэгээд өнгөрсөн жилээс энийгээ зогсоогоод, тэгээд бид нар энэ олон улсын зах зээл дээрээс Монголын Засгийн газрын үнэт цаасыг авсан.

Ханшийн тэгшитгэлийн өнгөрсөн оны ашиг, алдагдал ерөнхийдөө 10 гаруй тэрбум төгрөгийн ханшийн тэгшитгэлийн ашиг хийсэн байгаа. Өнгөрсөн жилийн нийт орлого гэх юм уу, ашиг гэх юм уу, орлого маань өөрөө 140 орчим тэрбум төгрөг. Үүнээс зардал маань 9 тэрбум орчим төгрөг. Ингээд 131 тэрбум төгрөгийн ашигтай ерөнхий байдлаар ажилласан..../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер гүйцээж хариулъя.

С.Баатарсүрэн: Хураамжийн орлого маань өөрөө 89 тэрбум төгрөг. Байгаа сангийнхаа хөрөнгийн өгөөж буюу хөрөнгө оруулалтын өгөөж маань өөрөө 31 тэрбум төгрөг байгаа. Тэгээд банкнуудын зүгээс банкны холбоо өөрөө бас манай

үндэсний зөвлөлд төлөөлөл нь байдаг. Тэгээд банкнуудын зүгээс бол энэ хураамжийн орлогоос хорогдуулахгүйгээр өсгөж байгаа өсөлт буюу хөрөнгө оруулалт хийгээд олж байгаа өгөөжийнхөө тодорхой хувиас давахгүй хувийг нь үйл ажиллагааныхаа зардалд зарцуулаач гэдэг шаардлагыг бол тавьдаг. Тэгээд энэ Төрийн хэмнэлтийн хуультай холбогдуулаад сүүлийн 2, 3 жилээр бол бид хэд төсвөө нэлээн танасан. Нийт жилдээ олж байгаа өгөөжийнхөө 25 хувиас хэтрүүлэхгүйгээр зардлаа барьж байя гэдэг дээр ерөнхийдөө зарчмын хувьд тохирчхоод байгаа юм. Үндэсний зөвлөлийн гишүүдтэйгээ. Үндэсний хорооныхоо гишүүдтэйгээ.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Оройн мэнд хүргэе. Сая маш чухал юм ярьчихлаа л даа. Тэр хадгаламжийн даатгалын корпорацад гадаад валют болон төгрөгийн харилцах хадгаламжийн данс нэг ёсондоо даатгалд бол 20 сая хүртэл. Энэ хэдэн онд гэсэн бэ. 2014 онд батлагдсан гэсэн үү. 2013 онд. Тэгэхээр 20 сая төгрөг 2013 оны дүн өнөөдрийн дүн 2 хоорондоо зөрүүтэй харагдана л даа. Тэгэхээр энэ нөгөө хадгаламжийн даатгал, нөгөө deposit insurance. Энэ өөрөө нөгөө банкны эрсдэл даах чадвар, эрсдэлд бас шууд нөлөөлдөг учраас яг үүний тохиромжтой яг зөв хэмжээ нь маш чухал гэж бодоод байна л даа. Тэгэхээр 2013 онд 20 сая төгрөгөөр тодорхойлж байхад нийт хадгаламжийн хэдэн хувь нь даатгалд хамрагдаж байсан бэ. Тухайн үедээ тэр хамгийн зөв оновчтой гэж л мэдээж 20 саяыг тодорхойлсон байгаа шүү дээ. Тэгэхээр энийг өнөөдөр 10 жилийн дараа, 12 жилийн дараа харьцуулах юм бол яг тэр түвшнийг өнөөдөр 2025 онд хадгалахад энэ 20 сая хэд болж өсөх шаардлагатай байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт бас яг олон улсын жишгийг тэр дундаа олон улс гэхээр хөгжсөн орнуудыг аваад яах вэ, тэр дундаа Ази Номхон далайн бүсийн ч юм уу, ойролцоо орнуудын арилжааны банкнууд дээр байгаа яг тэр хадгаламжийн даатгал яг дундаж хэд орчим байж байж тухайн орнуудад зохистой байна. Тэгэхээр би энэ 2 асуултыг асуугаад байгаа юм. Яагаад гэхээр зохистой түвшин маань өөрөө хуучирчихсан харагдаад байна л даа. Тэгээд зохистой түвшин чинь өөрөө 12 жил өнгөрчихсөн. 12 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг бас нэлээн тэлсэн. Банкнуудын активыг аваад үзсэн ч гэсэн бас хэд дахин тэлсэн байгаа. Тэгээд валюттай харьцуулах юм бол энэ 20 сая төгрөг чинь валюттай харьцуулахад ханшаа алдсан. 2 тал руу эсрэгээрээ явчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зохистой түвшин чинь аль түрүүн хуучирчихсан байна гэсэн дүгнэлт бол эндээс харагдаад байна. Тэгэхээр энэ дээр та бүхэн юу гэж бодож байгаа вэ. Энэ дээр өөрчлөлт оруулахын тулд хууль дээр өөрчлөлт орох ёстой юу. Эсвэл та нар өнөөдөр ТУЗ-өөр шийдвэр гаргах боломжтой юу. Яг шийдэл нь энэ дээр юу юм бол. Энэ асуултад хариулт авчхаад, тодруулъя.

Р.Сэддорж: Хариулт. 3 номер.

С.Баатарсүрэн: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Тантай санал 1 байна. Ерөнхийдөө манай энэ тоо хоцорчхоод байгаа юм. Яах вэ даатгаж байгаа хэмжээ маань 2013 оны 20 сая маань. Түрүүн бас дурдсан өнгөрсөн онд энэ тоо, энэ түвшин манайд ямар байвал оновчтой байх вэ гэдэг судалгаа хөндлөнгийн байгууллагаар хийлгэж үзээд ерөнхийдөө 60 орчим сая, 50-60 орчим сая төгрөг одоо бол байх ёстой юм байна гэдэг тийм үр дүн гарсан байгаа.

Олон улсад хамгийн сүүлийн үеийн мэдээллээр үзэхэд 2250 доллароос эхлээд 150 мянган доллар хүртэл орон болгон янз бүр. Нөгөө орлого, хадгаламжийнхаа хэмжээ, эдийн засгийнхаа нөхцөл байдалтай уялдаад өөр өөр ялгаатай байдалтай байгаа. Зарим нь бүр яг тухайн нөхцөл байдлаас нь хамааруулаад шийдвэрлээд хязгааргүй даатгадаг ч тохиолдол байгаа. Нөгөө бүх хадгаламжийг нь. Манайд энийг өөрчлөхийн тулд яах ёстой вэ гэхээр банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд л өөрчлөлт оруулна. Хуулиараа заагаад өгчихсөн байгаа.

Р.Сэддорж: 4 номер үргэлжлүүлж хариулъя.

Г.Энхтайван: Одоо банкин дээр байгаа хадгаламжийн нийт бүтцийг ажиглахаар нийт хадгаламжийн 37,9 хувь нь 100 сая төгрөг хүртэлх хадгаламжтай байгаад байгаа юм. Тэгээд сая сүүлд Эдийн засгийн сургалт судалгааны хүрээлэнгээс хийсэн 1 судалгаагаар хэрвээ хадгаламжийн даатгалын дээд хязгаар 20 сая байгааг 50 сая төгрөг хүртэл болгох юм бол 100 сая төгрөг хүртэлх хадгаламжтай иргэдийн эзлэх хувь нь 53 хувь болж өсөх юм байна лээ. Тэгэхээр энэ нь нэг талаасаа нэгж хадгаламж эзэмшигчдийн хэмжээ нэмэгдээд, нөгөө талаасаа бас хадгаламжийн нийт бүтцэд эзэлж байгаа жижиг хадгаламж эзэмшигчдийн тоо ч бас буурна. Энэ нөгөө талаараа банкны эрсдэлийг даван туулах, бид бүхэн резилент гэж ярьдаг шүү дээ. Ямар нэгэн гадаад дотоод шокт резилент байх тийм чадвар нь бол илүү нэмэгдэнэ гэсэн тийм судалгаа хийгдсэн байсан. Тэгэхээр нэмэх нь бол зайлшгүй л байгаа.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Яг 2013 онд би энэ сэдэв дээр Азийн 57 банкин дээр deposit insurance буюу хадгаламжийн даатгал буцаад тухайн банкны эрсдэл даах чадварт хэрхэн нөлөөлдөг вэ гэдэг судалгаа хийж олон улсын сэтгүүл дээр гаргаж байсан байхгүй юу. Тэгэхэд нэг ёсондоо тухайн банкны эрсдэл даах чадвар яг хадгаламжийн даатгал хэр үйлчилдгээсээ шалтгаалаад шууд хамааралтай байдаг. Тэгээд энийг нь баталж харуулж байсан юм л даа. Тэгэхээр энэ маш чухал. Цаашлаад энэ зээлийн хүүг бууруулах тал дээр ч гэсэн банкны эрсдэлтэй холбоотой учраас шууд нөлөөлөх маш том нөлөө байдаг байхгүй юу 1 дүгээрт.

2 дугаарт бас нэг ёсондоо жижигхэн хадгаламжтай маш олон хүмүүс байгаа шүү дээ. Тэгэхээр тэр хүмүүст бас нэг ёсондоо тэдний хадгаламжийг даатгаад, эрсдэлгүй болгох маш том орон зай байхгүй юу. Тэгэхээр энэ 2-ыг хослуулж л энэ хуулийн өөрчлөлт бол зайлшгүй шаардлагатай гэдэг нь эндээс харагдаж байна шүү.

Р.Сэддорж: Санал уу. Ингээд хамгийн удаан хуралдаж байгаа Байнгын хороо болж байна.

Ингээд мэдээлэлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Хадгаламжийн даатгалын корпорацын өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар болон Хадгаламжийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн талаарх мэдээлэлтэй Эдийн засгийн байнгын хорооны гишүүд танилцаж дууслаа.

Та бүхэн тулгамдсан асуудлууд, танай байгууллагын хувьд санал байвал бичгээр ирүүлээрэй. Тулгамдсан ямар асуудлууд байна. Монголбанк бас мөн адилхан. Монголбанк цаашдаа яг ард иргэд бол биднийг, та бүгдийг л харж байгаа. Сая тэр тэтгэврийн асуудлаар шийдвэр гарснаас болж ямар эмзэг байна. Тийм ээ.

Тэр зээлийн асуудал. Яг л амьдрал тийм байгаа. Тийм учраас та бүгдээс асар их зүйл шалтгаалж, ард иргэд харж байгаа шүү гэдгийг хэлье.

Ингээд танилцаж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

20.52 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ